みんぱくリポジトリ
国立民族学博物館学術情報リポジトリ National Museum of Ethnolo

хх зуун Монголчууд

メタデータ	言語: eng 出版者: 公開日: 2009-04-28 キーワード (Ja): キーワード (En): 作成者: I., ルハグワスレン メールアドレス: 所属:
URL	https://doi.org/10.15021/00001890

МАХН-ЫН ТХ-НЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, МОНГОЛ УЛСЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ САЙД АСАН ПААВАНГИЙН ДАМДИН

1 Улаанбаатар орох зам
2 Улаанбаатарын анхны өглөө
3 Ардын хувьсгалын 25 жилийн ойн баяр, наадам
4 Техникумийн бэлтгэл анги
5 МАХН-ын Төв Хороонд
6 Зөвлөлт улсад суралцах болов
7 Москвагийн амьдрал
8 Монгол улсын Аж үйлдвэрийн яамны сайд
9 Аж үйлдвэрийн комбинат
10 Дайны дараах үеийн аж үйлдвэрийн хөгжилт
11 Хүнд үйлдвэрийн болон цахилгаан эрчим хүчний салбарын хөгжилт
12 Нэхмэлийн үйлдвэр
13 Хүнсний үйлдвэрүүд
14 Хувьчлалын алдаа, завхралууд
15 Үндэсний үйлдвэрүүдийг сэргээх бодлого
16 Ямааны ноолуурын "Говь" үйлдвэр

1 Улаанбаатар орох зам

П.Дамдин: Энэ жил таны бичсэн "Монголын ирээдүйн тухай миний бодол" гэдэг нэртэй өгүүлэл манай сонинд гарсныг би олж уншсан. Энэ өгүүллийг би хавар уншсан юм. Тэгж би анх удаа таны тухай мэдсэн. Энэ удаа та надтай уулзах сонирхолтой байна гэдгийг И.Лхагвасүрэнгээс сонсоод тэр өгүүллийг дахиад уншиж үзлээ. Их сайн бичсэн өгүүлэл байна. Ингэж илэн, далангүй бичиж байх нь их сайн хэрэг. Би бас Аяко Кимурагийн бичсэн "Тархины тураал" гэдэг өгүүллийг уншиж үзсэн. Тэр өгүүллийг ч бас л сайн бичсэн байна билээ. Манай зарим хүмүүс их дургүйцсэн дээ. "Биднийг дайрч, доромжиллоо!" гээд байгаа юм. Би хувьдаа дэмжиж байсан. Зөв шүү дээ. Бидэнд байгаа дутагдлыг яг үнэнээр нь хэлсэн байна билээ. Үнэн юмыг үнэнээр нь бичих ёстой. Би түүнийг таны шавь гэж дууллаа. Тийм үү?

Коногая Юүки : Үгүй. Тэр жаахан хатуу бичсэн юм шиг байна билээ?

П.Д.: Би бол ширүүн, хатуу талын хүн дээ. Та Аякотой уулзвал, "П.Дамдин гуай бичсэн зүйлийг чинь уншсан байна. Их талархаж байна лээ шүү!" гэж хэлээрэй. Аяког өөрийг нь гомдоохоор юм хүмүүс манай сонинд бичсэн байна билээ. Түүнд гомдох хэрэггүй. Ихэнх Монголчууд миний адилаар Аяког дэмжиж байгаа байх гэж би бодож байна.

К.Ю: Энэ удаа Монгол улсын шинэ үеийн түүхийн сэдвээр тантай ярилцах гэж би бодсон юм. Энэ үед Улаанбаатар хот болон бусад газарт олон тооны үйлдвэр, завод байгуулсан түүхээр баян шүү дээ. Та үйлдвэрүүд байгуулж байсан ажлынхаа тухай ярьж өгнө үү?

П.Д.: И.Лхагвасүрэнгийн бичиж өгсөн олон асуултууд байна.
К.Ю.: Яг асуултанд хариулж байгаа юм шиг биш, тэр асуултуудыг дэлгэрүүлээд таны намтар шиг яривал сайн байна.
П.Д.: Намтараас эхлэх үү? Та нэг хугацаа хэлчих. Дэлгэрэнгүй яривал хэдэн цаг ч ярьж болно. Товчхон бол хэдэн минутанд ч багтааж болно шүү дээ.
К.Ю.: Өнөөдөр 6 цаг хүртэл ярилцаж болох уу?
П.Д.: Болно, болно.
К.Ю.: Тэгвэл та хэдэн онд хаана төрсөн бэ? Өөрийн бага насны тухай, аав, ээжийн тухай, сургуулийн насныхаа тухай, Улаанбаатарт хэдэн онд ирсэн, тэгээд орос руу хэдэн онд сурахаар явсан, буцаж ирээд хаана ямар ажил хийж байсан тухай ярьж өгнө үү?
П.Д.: Би танд төрсөн нутгаа танилцуулъя. Увс аймгийн Өндөрхангай сум юм шүү дээ. Улаанбаатараас 1000 гаруй км-д оршдог. Энэ бол нилээд хол газар шүү дээ. Дээр үед хүмүүс Богдод мөргөх гэж тэмээн жингээр ирдэг байсан юм гэнэ билээ. Нэг талдаа хоёр сар явдаг байсан гэсэн. Хавар гараад намар буцаж ирдэг гэж ярьдаг байсан. Бидний үед арай өөр, машин гарчихсан байсан. Манай аймгийн төв Улаангомоос шуудан явдаг болсон байлаа. Өндөрхангайгаас Улаангом ороод, тэндээс шууданд суудаг байсан. Гэвч энэ зам бол цаг хугацаа, зардал мөнгө их шаарддаг юм. Манай аав, ээж Улаанбаатар орохдоо Завхан аймгийн төв Улиастай хүртэл морь, тэмээгээр явсан юм. Би аав, ээжийгээ дагаад анх Улаанбаатарт ирсэн.
И.Лхагвасүрэн: Та сургуульд суух гэж анх Улаанбаатарт ирсэн үү?
П.Д.: Үгүй. Би 17 нас хүртлээ ямар ч сургуульд суугаагүй. Малчин байсан хүн шүү дээ. Манай аавынх олон биш, цөөн биш, дунд зэргийн малтай айл байлаа. Манайх зуугаад хонь, арваад үхэр, хорь гаруй адуу, тав - зургаан ачилгын тэмээтэй айл байсан. Манай аав дархан хүн байсан юм шүү дээ. Их нэр хүндтэй хүн байлаа даа. Мөнгө, төмөр, зэс, гуулиар юу л бол юуг ч хийдэг байв. Дээлийн товч, ээмэг, бөгж, цоож, цуурга, эмээл, хазаарын мөнгөн хэрэлэл зэрэг хүмүүсийн захисан зүйлүүдийг хийж өгдөг байв. Ийм учраас олон малгүй ч гэсэн манай амьдрал муугүй, дориун байсан билээ.
К.Ю.: Та ах дүү олуулаа юу?
П.Д.: Би гурвуулаа. Би ахтай, дүүтэй. Манай ах цэрэгт явсан юм. Тэр үед цэрэгт 3-4 жил явдаг байсан. Цэрэгт явсан хүүгээ эцэг, эх нь эргэдэг сайхан заншил манай монголчуудад байдаг юм. Манай ах цэрэгт яваад, дэвшээд офицер болоод, Батлан Хамгаалах Яаманд ажиллаж байв.

Манай аав, ээж цэрэгт явсан хүүгээ эргэх, нийслэл Улаанбаатар хотыг үзэх, Ардын хувьсгалын 25 жилийн ойн баяр наадмыг үзэх зорилгоор дүү

бид хоёрыг аваад хотод ирсэн юм. Энэ бол 1946 он байсан. Манай аав, ээж бид нар нутгаасаа бараг 4 сард л гарсан байх. Завхан аймгийн төв хүртэл тэмээгээр явсан. Тэнд ирээд шуудангийн машинд суусан. Анх машинд суух их хэцүү, аймаар байлаа. Тэр үед машин маш бага явдаг байсан. Долоо хоногт ганц шуудан очвол очно. Хот явах гэсэн хүн олон байсан. Завхан аймгийн төвд их удаж байж арайхийж машинд суусан даа.

К.Ю.: Ямар машин шууданд явдаг байсан бэ?

П.Д.: Шууданд "ЗИС-5" гэдэг орос машин явдаг байсан юм. Одоо бүр байхгүй. Музейд л байдаг байх. Нутгаасаа аав, ээж хоёр, дээр нь дүү бид хоёр хамт гарсан. Тэрний хажуугаар аав дархан, нэр хүндтэй хүн байсан болохоор аавыг дагаж Улаанбаатарыг үзэх, цэрэгт явсан хүүтэйгээ уулзана гээд нэг өвгөн, аавын танил Заяат гэдэг хятад хамт гарсан. Манай нутагт ердөө хоёрхон хятад байсан юм. Аав дархан хүн байсан болохоор хоорондоо хорших, багаж хэрэгсэлээ бие биенээсээ авах зэргээр хамтарч ажилладаг болоод аавтай их найз байсан юм байна л даа. Аавыг хот явна гэж дуулаад өнөө хужаа чинь:

-Чи намайг аваад яваач, Улаанбаатарыг үзүүлээд өгөөч! гэж гуйсан юм байж. Ингээд бид дөрөв дээр нэг өвгөн, нэг хужаа нэмэгдлээ. Ганц хүнийг бол шуудангийн машинд суулгах амархан шүү дээ. Олон хүнийг бол мэдээжийн хэрэг хэцүү байсан. Бид Завхан дээрээс нэг машинд суулаа. Би түүнийг одоо болтол мартдаггүй юм.

Тэндээс бид "Цагаан оломт" гэдэг газар ирсэн. Цагаан оломт гэдэг газрыг мэдэх үү? Увс, Ховд, Говь-Алтай, Завхан аймгуудын дундах тээврийн төв буудал байсан юм шүү дээ. Энд машин арай элбэг байсан даа. Бид нэг машинд гуйж суулаа. Бид 6-7 хүн байсан. Нийт манай нутгаас 8 хүн байсан. 8 хүнийг машинд суулгах их хэцүү байсан л даа. Тийм учраас их л удсан даа. Машинд суугаад арваад хоног явж Улаанбаатарт орж ирсэн. Байсхийгээд л эвдрээд зогсчихдог муу машин байсан,нөгөө талаар тэр үеийн жолооч нар их дурааараа байсан. Дэглэм, журам муутай байсан. Тэр үед машин жолоодсон хүн гэдэг чинь их том, лут хүн байна шүү дээ. Тэр дуртай газраа, аймгийн төв дээр ч юмуу ирээд л зорчигчидоо буулгаад хаячихна. Өөрөө айл хэсээд, архи уугаад ч юмуу алга болчихно. Ингэж явсан учир Улаанбаатарт 10 хоноод орж ирсэн байх.

Улаанбаатарт орж ирэхэд их сонин байсан. Би байшинг анх удаагаа л харлаа. Би чинь 17 настай байсан хүн шүү дээ. Ахтай уулзах ёстой байсан боловч хаяг адресийг нь мэдэхгүй учраас их мунгинасан даа. Хөдөөнөөс орж ирээд нөгөө машин хүмүүсийг буулгаад л хаячихсан. Хүмүүс тараад, тараад л явцгаасан байх. Ах, дүү нь аваад явах нь явсан байх. Тэр үед одоогийнхтой адил, тэдэнд гарлаа угтаж ав гэсэн холбоо юу ч байгаагүй юм шүү дээ. Бид ч машинаас буугаад, аав нэг морин тэрэг хөлсөлж аваад,

өнөөх дээрээ юмаа ачаад, өөрсдөө дээр нь суугаад явцгаалаа. Хачин л юм яваа биз. Би одоо ч тод санадаг юм. 1-р арван жилийн урдуур явж байлаа. Маршал Чойбалсангийн байрны хажуугаар шүү дээ. Гэтэл цагдаа зогсоолоо. Тэр үед тэнд цагдаа байсан юм байлгүй. Их ачаа ачсан тэргэн дээрээ долуулаа суучихсан явж байгааг хараад зогсоож л дээ. Цагдаа:
-Ингэж явж болохгүй! Бууцгаа! гэж байна.
Тэгээд л бүгдээрээ бууцгаалаа даа. Тэр цагдаагаас Батлан Хамгаалах Яамны байшин хаана байдгийг асуулаа. Одоогийн Хөдөө Аж Ахуйн Яамны байшинг мэдэх үү? Биднийг ирж байхад тэнд Батлан Хамгаалах Яамны контор байсан юм. Одоо үүдэнд нь байгаа малчин, тариаланч хоёрын барималын оронд буу барьсан 2 цэргийн баримал байсан юм. Тэнд ирээд аав дотогшоо орлоо. Удалгүй ах гүйж гарч ирээд л аав, ээждээ үнсүүлээд намайг үнсээд л, дүүг бас үнслээ. Тэр үед ах өөрийн гэр байхгүй, нэг айлд суудаг байсан юм. Нэг настай авгайн гэрт суудаг байлаа. Тэр нь дөрвөн ханатай жижиг гэр байсан юм л даа. Биднийг яваад очихоор 10 шахам хүнтэй болж байгаа юм. Тэгж анх би Улаанбаатарт ирж байлаа.

Би яагаад сургуульд ороогүй юм бэ? гэвэл нэг ийм түүх бий. Манай нутагт сургууль тэр үед зун хичээллэдэг байлаа. Амьдралын шаардлагаар их зөв байсан юм шиг. Өвлийн цагт сургууль хичээллэдэггүй байлаа. Зун бол мал маллахад хүн хүчний шаардлага байхгүй. Харин өвлийн цагт аав, ээждээ туслах шаардлага байдаг юм. Анх манай суманд бага сургууль байгуулагдаж, зун хичээллэдэг байлаа. Тэр үед сумын захиргаа малчдаа дагаад нүүдэг байлаа. Сумын төвд сумын даргын контор, намын даргын контор гээд 5-6 гэр байх. Сургуулийн хоёр гэр байна. Анх сургууль байгуулагдахад би хоёрхон долоо хоног л суусан юм. Би ер нь дураараа хүүхэд байсан юм шиг байгаа юм л даа. Би зун мах, гурил, чихэр иднэ. Сүү, цагаан идээнд дургүй, айлын дураараа хүүхэд байсан юм шиг байгаа юм. Намайг сургуульд ороход аав том шуудайтай чихэр аваад, 10 кг л байсан байх, сургуулийн захиралд өгөөд:
-Захиралаа! Манай хүүхэд чихэр идэхгүйгээр байж чаддаггүй юм. Та үүнээс манай хүүхдэд өдөрт хоёр ширхэгийг өгч байгаарай! гэж хэлээд явж билээ. Би өдөрт захирал дээр орно. Надад хоёрыг л өгнө. Тэр чихэр нь олон янзын чихрийг холиод хийсэн байсан.

Тэр үеийн сургууль монгол гэрт хичээллэдэг, ширээ сандал байхгүй. Нэг дэвсгэр гэрээсээ авч ирнэ. Тэр дэвсгэрээ дэвсээд дээлээ нөмрөөд унтана. Өглөө босоод дээлээ гудсандаа боогоод сандал болгоод, түүн дээрээ суучихна. Өвдөг дээрээ ном, дэвтэрээ тавина. Тэр үед харандаа цаас гэж байгаагүй юм. Мод харуулдаад дээр нь тос, үнс түрхээд дэвтэр хийнэ. Сүүлний өөхийг түрхээд, дээр нь үнс, хомоол түрхэнэ. Ёстой сайхан гөлийсөн юм болно доо. Түүн дээрээ хулсан үзгээр бичнэ. Хулсыг

үзүүрлээд үзэг болгоно. Японд байдаг уу? Түүгээрээ бичнэ. Бичсэнээ арилгаад дахиад бичнэ. Тийм дэвтэртэй байлаа. Дэвтрээ өвдөг дээрээ тавьж байгаад хичээлээ хийнэ дээ. Хичээл юу зааж байсан бол? Бодвол үсэг зааж байсан байх. Тоо зааж байсан байх. Тийм маягаар хоёр долоо хоног сурсан юм. Би аав, ээжээ санаад л, хоол ундаа санаад л хэцүү байлаа. Сургуулийн хоол гэдэг чинь нэг л их заваан, хэцүү хоол санагдаж байсан. Би мал малладаг хүүхэд байсан болохоор нэг морь олж унаад давхичихвал манай гэр холгүй юм шиг л санагдаад байв. Явна гэж бодоод л явах гэхээр, 7-8 настай байсан болохоор төөрчих байх гэж айгаад л байдаг байлаа. Уг нь нутгаа сайн мэдэж байсан юм л даа.

Тэгж байтал ашгүй аав, ах хоёр намайг эргэж ирлээ. Захиралтай уулзлаа.

-Манай хүү ямар байна? гэж байна.

Тэгээд л би аавыг үзээд л уйлчихсан. Би аавтай хамт явна гэлээ.

-Үгүй, чи сургуульдаа сур! Явж болохгүй! гэж байна аа. Би явна л гээд байлаа.

-Та захирал дээр орж чөлөө авч өг! гээд аавыг шаллаа.

Аав сумандаа их нэртэй хүн байсан. Пааван дархан гээд хүмүүс их хүндэлдэг байлаа. Аав захирал дээр дахиад л орлоо доо.

-Захирал аа! Манай хүү гэрээ санаад, ээжийгээ санаад байх шиг байна. Та хэд хоногийн чөлөө өгөөч! гэж аав хэллээ.

-Хичээл дуусаагүй байхад болохгүй, дахиад хүрээд ирэхэд чинь хүүхдүүд шинэ юм үзсэн байна! гээд захирал аавд тайлбарлаж байна. Би ч заавал явна гээд чаргууцалдаад уйлаад л байсан. Аав:

-Түр эхтэй нь уулзуулаад ирье, эх нь ч санаад байна! гэж учирлаж хэллээ.

-Захиралаа! Би 14 хоног яваад ирье! гэж хажуугаас нь би өөрөө захиралд хэллээ.

Тэгж яваад, би тэр чигээрээ сургуулиас гарсан. Сургууль гэдэг чинь дэмий юм байдаг юм гэж бодох болсон. Ингээд л би сургуульгүй өссөн юм даа. Манай ах бол сургуульд сурсан. Тэр үед дэлхийн 2-р дайн болж байлаа. Шинэ үсэг эхлэн зааж байлаа. Хуучин Монгол үгийг миний ээжийн аав Сэрээтэр өвөө маань зааж өгсөн юм. Тэр бас малчин хүн байсан. Тэгсэн хирнээ бичиг үсэгтэй хүн байсан. Тэр намайг бүр 5-6 настай байхад зааж сургасан юм. Монгол улс бол аймагт, аймаг нь суманд, сум нь багт хуваагддаг байсан. Манай аймаг тэр үед 16 сумтай, манай сум бол 11 багтай, манайх бол 10-р багт багтаж байсан. Шинэ үсэг заахын тулд эхлээд багийн бүлгэм гэж байгуулагдсан юм. Тэнд шинэ үсэг зааж байсан. Би багийн бүлгэмд сууж шинэ үсэг тайлагдаад, дараа нь шат ахиад сумын бүлгэмд суусан. Тэр үед багийн дарга л юу хэлнэ, тэр нь хууль байсан юм. Багийн дарга намайг бүлгэмд явуул гэсэн болохоор

сумын бүлгэмд очиж суусан юм. Ингэж би шинэ үсэг тайлагдсан юм. Зун ахыг амралтаараа очиход тоо заалгадаг байсан. Ах аймгийн дунд сургуульд сурдаг байлаа. Иймэрхүү маягаар бичиг, үсэг тайлагдсан хүн Улаанбаатарт орж ирж байгаа юм л даа.

17 настай, бичиг үсэг тааруухан, тэгсэн хирнээ тамхи татдаг. Би чинь хоёр төрлийн гаанстай байлаа. Нэг нь соруултай гоё, түүнийгээ Монгол гутлынхаа түрийнд хийчихдэг байв. Хөдөө малд явахдаа соруулгүй гаансаа буюу мод толгойгоо авч явна. Ээж машинаар юм оёдог байсан учраас надад тамхины уут оёод өгчихсөн. Би чинь хөдөө байхдаа нилээд дээгүүр хүнд орно. Аавыг дагаад жонжуунд явна. Жонжуу гэж мэдэх үү? Жонжуу гэдэг чинь найр. Хүүхдийн даахь авах найр, шинэ гэр барьсны найр болно. Аав сумандаа их нэр хүндтэй хүн байсан болохоор их олон найранд уригддаг байлаа. Заримд нь хүрэлцэхгүй, аавын өмнөөс би явна. Очоод нөгөө даахиа авхуулж байгаа хүүхдийн даахийг хайчилна. Хол, ойрын төрөл, садан, танилаас хамааранд,халзан цагаан хонь эсвэл морь аваарай гээд мялаана. Хадагаа бариад л өгчихнө. Аавыг төлөөлж байгаа учраас намайг нилээд дээгүүр суулгана. "Пааван гуайн хүү ирлээ!" гээд л хүндэлнэ шүү дээ. Ойр дотны төрөл бол аав өөрөө очно. Аав том мал, даага, бод малаар мялаана. Иймэрхүү боловсролгүй, нилээд бүдүүлэгдүү хүн нийслэл хотыг анх үзэж байлаа даа.

Завханаар дайрч явахдаа Улиастайд ирж л би цахилгааныг анх үзэж байсан юм. Нэг айлд буугаад байж байтал орой болоход нэг бөндгөр шилийг эргүүлчихлээ. Гэтэл их гэрэл гараад л, дуу ч гарах гээд байгаа юм шиг санагдаж билээ. Тэр үед чинь унтраалга гэж байхгүй, шууд чийдэнгийн шилийг эргүүлээд асаадаг байж л дээ. Тэр айлд бас нэг дугариг хар юм байсан. Хүн яриад л, дуу дуулаад л байсан. Тэр бол радио байж. Манай аймаг төвөөс хол учраас хөгжлөөс нилээд хоцорсон байж л дээ. Радио, цахилгаан, утас, сонин хэвлэл байгаагүй юм. Хаяа нэг сонин, хэвлэл очидог байсан байх. Би хөдөө байхдаа ертөнц бол баруун тал нь Туруун, зүүн тал нь Зүүнхангай юм байна даа л гэж боддог байсан. Машин бол жилдээ хаяа нэг очино. Аймгийн дарга, аймгийн намын хорооны даргын машин байна. Ачааны машин маш ховор очно. Бид нар машины мөр хараад л хөөгөөд давхичихна шүү дээ. Хэдэн сарын өмнө явсан нь ч бүү мэд шүү дээ. Хээр талаар явсан машины мөр гэдэг чинь алга болдоггүй юм. Морьтой тэр мөрийг хөөгөөд л давхиад байна. Тэр чинь хэдэн хоногийн өмнө явчихсан мөр ч байж болно шүү дээ.

Жилд нэг удаа хөдөө "Сурталын бригад" гэж нэрлэдэг ухуулгын хэсэг очдог байсан. Уран сайхан, суртал ухуулга, кино, дуу, хөгжим бүгд хамт ирнэ. Улаанбаатараас ийм сурталын бригад жилд нэг удаа л ирнэ дээ. Бид нар ирсэн бүх киног нь үзнэ. Концерт гарна. Сурталын бригад

цөөн хүнтэй явна. Дуулдаг хоёр хүн байна, кино гаргадаг механикч байна. Тэд нар улс орны хөгжлийг харуулсан самбар гаргана. Үзэсгэлэн ч гэх юмуу даа. Ухуулгаа бас хийнэ. Ингээд нэг суман дээр 3-4 хоноод явна. Тэд нар сум дамжаад л цааш яваад байна даа. Хавар гараад, намар л эргэж ирдэг байсан байх. Манай нам, засгаас тийм арга хэмжээг зориуд зохион байгуулж байсан болохоор аргагүй шүү дээ. Тэгэхэд л би анх удаа Шороотын Цэвээний тоглосон киног үзсэн юм. Шороотын Цэвээн гуайн охин одоо байгаа. Шороотын Цэвээн гэдэг чинь Монголын бараг анхны уран сайхны кинонд тоглосон байх. Тэр кино дуу байхгүй. Хааяа нэг үсэг гараад л ингэх гэж байна, тэгэх гэж байна гэж тайлбарлана. Хөдөөд түүнийг 50 мөнгө юмуу 20 мөнгөөр үзүүлдэг байсан байх. Хээр, гадаа л үзнэ шүү дээ. Экранаа гадаа дэлгэнэ. Настай улсууд билет аваад л гадаа суучихна. Бид нар хүүхдүүдэд түүнийг үзэх мөнгө байхгүй, бас сууж үзэх сонирхолгүй, хамгийн гол нь мөнгө байхгүй л дээ. Тийм учраас морьтойгоо экраны нөгөө талд нь очоод зогсчихдог юм. Хүний дээл хувцас дандаа л буруу талаасаа харагдана шүү дээ. Нутгийн хүүхдүүд ингэж морин дээрээсээ л үзвэр үзнэ шүү дээ. Ямар л кино гарна бүгдийг үзнэ. Хөдөөний амьдрал ийм л байсан юм. Улаанбаатарт нэг ийм л хүн орж ирж байсан юм даа. Одоогийн Хөдөө Аж Ахуйн Яам хаана байна тэнд анх буусан. Түүний урд талд цэргийн дарга нарын хашаа гэж байсан. Нэг л том хашаа байна шүү дээ. Дотор нь олон гэр буусан байсан.

2 Улаанбаатарын анхны өглөө

К.Ю.: Тэр үед хүн зөөдөг морин тэргийг Хятадууд ажиллуулж байсан уу?

П.Д.: Тийм л дээ, хятадууд ч байсан, монголчууд ч байсан. Гол нь Хятадууд байсан байх. Ер нь тэр үед Улаанбаатарт 2-3хан автобус л байсан байх. Би бас анх удаа автобусанд сууж үзлээ. Тэгээд голдуу морин тэргээр л явна шүү дээ. Морин тэрэг бол янз бүр байна. Ачааны морин тэрэг, суудлын морин тэрэг, жирийн морин тэрэг гээд л байна, бүр гоё ч бас байна шүү дээ. Нэлээд баян чинээлэг, чадалтай хүмүүс нь түүнд суугаад явдаг байсан байх. Тэр нь гурван төгрөг, тааруухан нь нэг төгрөг ч гэдэг юмуу, янз бүрийн л үнэтэй байсан даа. Бид нар тийм юманд суухгүй л дээ. Мөнгө ч байхгүй. Бидний хүүхдүүд заримдаа араас нь очоод суучихдаг байсан. Заримдаа хүчтэй шавхуурдана. Нүүрэн дундуур таарч л байдаг юм. Тэгээд морин тэрэгнээс буухад орой болчихсон байлаа. Ахын байсан айлд хоноцгоолоо. Өглөө боллоо. Би анх удаа тэр хоёр давхар байшинг харлаа. Үгүй, мөн хачин өндөр юм харагдаж байна аа. Өөдөө өлийж л харж байлаа шүү дээ.

Тэгээд бид хөдөөнөөс ирсэн хүмүүс болохоор ах, дүү нартайгаа уулзана, нутгийн танил айлуудаар очино, зах явна гээд ажлууд ундарсан

даа. Тэр үед 2 том зах байсан юм. Бараан зах, хүнсний зах хоёр л доо. Хуучин их дэлгүүр, одоо музей байгаа газар бараан зах байлаа. Сэлбийн голыг баруун, зүүн сэлбэ гэдэг байсан юм. Баруун сэлбэ буюу одоогийн Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн баруухан талд бараан зах байсан юм шүү дээ. "Шар дэлгүүр"-ийн орчим гэсэн үг л дээ. Тэр хавь чинь Хятадын район байсан юм. Есөн гудамж, өргөн чөлөөний талбай гээд хачин, хачин гудамжнууд байсан юм. Би ч бас сайн мэдэхгүй. Тэрнээс нилээд урагш яваад, одоогийн цирк байгаа орчимд хүнсний зах байлаа. Би тэр үед өөрөө их сонин хүүхэд байж. Хөдөөний хүүхэд гэж ямар байсан бэ? Аав, ээжийгээ дагаад л явна. Улаанбаатарт хүн олон гэж жигтэйхэн, базарваань хумпад, 17 настай банди гэдэг хөдөө бол бараг авгай авчихна шүү дээ. Хотод ирээд гадуур явахаар төөрчих гээд болдоггүй. Тэгээд ээжийнхээ хормойноос барьчихдаг. Төөрөхгүйн тулд ээжийнхээ хормойноос барьчихдаг. Зогсохоор нь тамхиа гаргаад татна. Газар суучихна шүү дээ. Хамаагүй. Өнөө түрийндээ хийсэн мод толгойгоо гаргаж ирээд тамхиа татна даа. Ээжийгээ явахаар нь өнөөхөө буцааж хийчихээд, хормойноос бариад явна. Үгүй, мөн хөдөөний хүүхэд гэж сонин байсан байгаа биз. Төөрчих гээд болдоггүй. Толгой эргэж жигтэйхэн юм болно шүү дээ. Тэр үед Улаанбаатар хэдэн хүнтэй байсан юм бол доо. Нэг зуун мянга орчим байсан юм болов уу? Миний толгой эргээд л, нөхцөлгүй олон хүнтэй юм шиг санагдаад л байдаг байсан.

Улаанбаатарт ирсний дарааханы сэтгэлээс гардаггүй нэг зүйл бий. Бид нар нутгийн айл, ах дүү нараар орно. Очсон айлууд хоол хийж өгнө. Бууз, хуушуурыг бол идчихнэ. Ногоотой хоол гэдэг аюултай юм байсан юм. Ээ базарваань, үмхий ч гэж жигтэйхэн, үнэр танар гэж хачин муухай. Айлууд голдуу төмс, лууван, байцаа, манжинтай хоол хийдэг байсан байх л даа. Үнэр гэдэг нь жигтэйхэн муухай. Миний огидос хүрээд л, ерөөсөө идэх нөхцөл байхгүй болно доо. Очсон айлууд ч ид, ид хүү минь гээд л байна. Аав, ээж хоёр түүнийг нь идчих юм аа, би бол ерөөсөө идэж чаддаггүй байлаа. Би сүүлд хүртэл ногоотой хоол идэж чаддаггүй байсан юм шүү дээ. Ер нь хачин муухай юм шиг санагддаг байлаа. Нэг удаа дүүтэйгээ хоёулаа явж байлаа. Хүмүүс бөндийсөн улаан юм л идээд байх юм. Харсан чинь амттай бололтой, амтархаад л идэцгээж байв. Миний дүү эмэгтэй дүү байсан юм. Насаар надаас нилээд дүү л дээ.

-Энэ хүмүүсийн идээд байгаа юм нөгөө алим гэдэг нь л байх шиг байна. Хоёулаа нэгийг авах уу гэлээ.

-Тэгье! гэж дүү маань хэлж байна шүү. Тэгээд тэр улаан юмнаас нэгийг авлаа даа. Би ах нь юм чинь түрүүлж аваад л хазсан чинь нялуун, муухай амттай байгаа гэж ярих юм алга.

-Май! Чи ид гээд дүүдээ өглөө. Дүү нэг хазаад :

-Яах вэ? ахаа. Идэх арга алга! гээд хаячихлаа.
Ээ, базарваань, түүнээс хойш тиймэрхүү юм руу ойртохоо байсан шүү. Тэгсэн тэр маань помидор байсан юм билээ. Иймэрхүү л янзтай байлаа шүү дээ.

Тэр үед Улаанбаатарт нүдэнд тусахаар өндөр байшин бол 1-р арван жил сургууль байсан юм. 1-р арван жилийн сургуулийн хажууд маршал Чойбалсангийн байр байсан. Одоогийн Багшийн Дээд Сургуулийн байранд Засгийн газар байрладаг байсан. Улаанбаатар зочид буудлын хажууд шүү дээ. Их сургууль тэр хэвээрээ тэндээ байсан. Манай одоогийн Засгийн газрын ордон байгаагүй. Түүний оронд "Бөмбөгөр ногоон" гэдэг нэрээр алдаршсан театр байсан юм. Тэр байшин дөчин хэдэн онд галд шатчихсан юм шүү дээ.
К.Ю.: Та театрт очиж байсан уу? Театр ямар байсан бэ?
П.Д.: Би очиж байсан юм шүү. Театр гэдэг чинь хачин гоё санагддаг байлаа. Хөдөөнөөс ирсэн хүмүүсийн үздэг л юм нь тэр байсан юм шүү дээ. Би ээж, аавыгаа дагаж хэд хэдэн удаа театрт орсон юм. Ший бас үзнэ. Хүүхэд ший үзэхэд хэцүү байсан юм. Журам хатуутай байлаа. Хүүхэд үзэж болохгүй ший гэж байна. Алаан, хядаантай, байлдаантай ч юмуу, эсвэл хайр дурлал, янаг амрагийн ч юмуу сэдэвтэй шийнд хүүхэд оруулдаггүй байлаа шүү дээ. Жирийн хүмүүжлийн чанартай шийнд бол оруулна. Би ээж, аавыгаа дагаад л очино доо. Бөмбөгөр ногоон театр чинь хэний проект гэдэгсэн билээ дээ? Гадаадын нэг хүний проект байсан гэдэг юм. Орос хүнийх л биш юм даг. Герман ч билүү, баруун Европын нэг хүний зураг, төслөөр баригдсан юм гэдэг. За ингээд л би Улаанбаатар чинь сайхан газар юм гэж ойлгож эхэлсэн дээ. Ирснийхээ маргааш өндөр байшин харсан гэж ярьсан шүү дээ.

Манай ах байсан айл нэг хүүхэдтэй байсан юм. Тэр миний үе л дээ. Түүнийг дагаад төмөр зам гээч юмыг үзэхээр нэг өдөр явлаа. Төмөр зам гэж юуг хэлдэг юм бэ? Би мэдэггүй байсан юм. Тэр үед Улаанбаатар дундуур төмөр зам гарч байсан. Налайх, Улаанбаатарын хооронд явдаг байсан байх л даа. Яг одоо бидний сууж байгаа энэ газарт Сэлбийн гүүр байсан. Одоогийн гүүрнээс урьд нэг гүүр байсан. Төмөр зам яг одоогийн бидний сууж байгаа зочид буудлын дэргэдүүр гараад, Налайхаас төв цахилгаан станци руу очдог байсан. Нүүрс зөөж ирдэг байсан юм. Өнөө хүү төмөр зам энүүхэн энд байгаа, үзэх үү? гэж байна.
-Үзье! л гэлээ. Тэгээд л тэр намайг дагуулаад яваад байлаа. Тэгснээ хоёр нарийхан төмөр заагаад:
-Энэ байна! гэж байна шүү.
-Үгүй ээ, энэ чинь төмөр зам юмуу? гэлээ.
-Энэ чинь төмөр зам байхгүй юу! гэж байна аа.

Надад ямар ойлголт байсан бэ? гэхээр их өргөн төмөр дэвсчихсэн, түүн дээгүүр нь машин, вагон, өөр юу ч юм бэ, явдаг гэж төсөөлөлж байсан юм. Тэгтэл хоёр нарийхан төмөр зааж байна. Тэгж л би анх төмөр замыг үзэж байлаа.

3 Ардын хувьсгалын 25 жилийн ойн баяр, наадам

Тэгээд удсан ч үгүй, Ардын хувьсгалын 25 жилийн ой, улсын баяр наадам боллоо. Энэ бол 1946 оны 7-р сарын 11-ний өдөр юм шүү дээ. Би тэр үед анх удаа маршал Чойбалсанг харсан юм. Тэр үед наадмаа 5-7 хоног хийсэн дээ. Одоо бол наадмыг 2-3 хоногт л хийж байгаа шүү дээ. Хувьсгалын дараахнаар бол наадмыг 10 хоног хийдэг байсан юм гэдэг. Ингээд наадам үзэхээр хамаг байдаг юмаараа гоёж аваад л явлаа даа. Манай төрлийн нэг боловсролтой авгай хотод байсан юм. Тэднийд очиж хоноход баяраар өмс гээд хөөрхөн товчтой цамц, бас энүүгээрээ товчтой нэг өмд өгсөн юм. Тэдгээрээр л 25 жилийн ойд гоёлоо шүү дээ. Миний анх удаа Европ хувцас өмсөж үзэж байгаа маань тэр л дээ. Гутал, ботинка олдохгүй байсан юм. Аав гадуур явж байгаад хаанаас ч юм бэ дээ, комбинатаас л байх, нэг ажлын бакалан гутал авч өглөө. Тэрийг нь өмслөө. Энэ бол миний санаанаас хэзээ ч гардаггүй зүйлүүд юм. Анх удаа ийм хувцас өмсөж үзэж байсан болоод тэр биз дээ.

Гуталд маань өнгө зүс ч гэж байхгүй л дээ. Тэгээд өглөө болгон хөөгөөр будна. Сүүлний тос түрхэж байгаад л хөөгөөр будаад байна. Тэгээд ёстой гялалзтал арчина шүү дээ. Орой тайлахад л хэцүү гутал байсан даа. Үйлдвэрээс тийм гарч байсан байх л даа. Монгол хүний хөлд л их муу таарсан гутал байсан. Их нарийхан түрийтэй, харин доошоо ороод чөлөөтэй л дээ. Түрий нь маш нарийхан учраас түрийгээрээ ордоггүй, орохоороо гардаггүй байлаа. Тэр үед хөдөөнөөс ирсэн хүнд нэг айхтар зовлон байсан юм. Нохой бөөс гэж нэг юм байсан юм л даа. Японд дээр үед нохой бөөс гэж байсан л байх даа. Одоо бол нохой бөөс дэлхийд байхгүй болсон. Манайд нохой бөөс гэж нэг аюултай юм байсан юм. Үсэрдэг, ялангуяа хөдөөнөөс ирсэн хүнийг айхтар их хаздаг. Миний хөлийг хазаад, оройд нь өнөөхийг маажаад, шархлуулчихна. Тэгээд өнөө нарийн түрийтэй гутал өмсөөд өдрийн турш явчихаад орой тайлах гэхээр наалдчихсан байна. Тийм маягаар 25 жилийн ойг үзлээ.

Тэр үед би анх удаа маршал Чойбалсанг харсан юм. Нэг их олон одон зүүчихсэн хүн байсан. Холоос л харж байгаа юм шүү дээ. Ойроос харах боломж байхгүй л дээ. Хөдөөнийхөн маршалыг их хүндэтгэдэг байлаа. Маршал Чойбалсанг харна гэдэг чинь дээр үед хувьсгалын өмнө бол Богдыг харж байгаатай ялгаагүй. Хувьсгалын үед маршалыгаа нэг харчихвал болж байгаа нь тэр л дээ. Баярын үеэр олон хүн, машин, техник

холхилдоод сайхан санагдаж байж билээ.

17 настай хүүхэд гэдэг чинь их том хүн юм шүү дээ. Хурдан явж юм үзмээр санагдаад байдаг. Ээж, аав хоёрыг дагасан чинь явж өгдөггүй, нэг газар очоод л суучих юм. Тэгээд:

-Би түрүүлж яваад юм үзээд ирье! гэж хэллээ.

-Чи төөрчихгүй биз? гэж байна.

-Төөрөхгүй! гэлээ.

Би хотод ирээд 2 сар болчихсон, бас нэлээн костюм маягийн юм олоод гоёчихсон, гараад өгсөн байхгүй юу. Би хотод ирэхдээ Монгол гуталтай ирсэн. Тэгээд л ээж, аав хоёроосоо салаад явчихлаа. Юм ч их үзлээ. Жагсаал болж байсан, өөр юу ч болж байгаа юм бүү мэд шүү дээ. Нар жаргах болж байна аа. Би эргээд аав, ээжийгээ олдоггүй. Суманд бол дор нь олно шүү дээ. Эрээд л яваад байлаа. Олдоггүй. Тэр олон мянган хүн дотор миний ээж, аав олддог янз байдаггүй. Ингээд төөрчихлөө дөө. Одоо яадаг билээ гээд л бодлоо доо. Тэгээд Батлан Хамгаалах Яамны байрыг хайж олъё гэж шийдлээ. Тэр үед яам болгон өөрийн лагерьтай байсан юм. Гэр бариад тэнд нь яаманд ажилладаг хүмүүс нь очино. Яаманд ажилладаг хүмүүс баярын 5-6 хоног тэндээ л байна. Яамны аппаратад ажиллаж байгаа хүмүүс, тэдний гэр бүлийнхэн тэнд үнэгүй хоол иднэ. Тэнд хонож болно. Тэгээд би тэр орой аав, ээжийгээ олохгүй болохоор ухаан гаргаад:

-Батлан хамгаалах яамны байр хаана байна? гэж хүнээс асуулаа. Тэнд очвол нэг цэргийн дарга байна. Өөрийнхөө төөрсөн байдлыг түүнд хэллээ. Түүнээс ах хаана байгааг асуулаа. Тэр хүн ахыг минь олж өглөө. Ингэж би наадмын 3 хоногт нь ээж, аавтайгаа уулзаж чадсангүй. Ийм маягаар 25 жилийн ойг үзэж байлаа.

Тэр үед хөдөөнөөс баяр, наадам үзэхээр хот явбал тодорхойлолт маягийн юмтай ирдэг байсан юм. Одоо тийм тодорхойлолт гэж байхгүй. "Манай сумын Ананд овогтой Пааван нь эхнэр хоёр хүүхдийн хамт яваа нь үнэн" гэсэн утгатай тамгатай бичиг байсан юм. Ийм бичиг авч хотод ирсэн бол 25 жилийн ойгоор нэг ширхэг даалимба өгч байсан юм. Даалимба гэдэг бол манайхан дээл хийдэг хагас хөвөн даавуу юм шүү дээ. Сүүлийн үед манайхан лоозон энэ тэрийг л түүн дээр зурдаг болоод даалимбаар дээл хийхээ больсон юм шиг байна. Тэр бичгийг үзээд даалимбанаас гадна нэг ширхэг дүнсэн тамхи, нэг ширхэг цай өгч байлаа. Аав ийм 3 төрлийн юм өгч байгааг дуулаад намайг дагуулаад түүнээс авахаар явсан юм. Өдрийн турш түүнийг авахаар оочерллоо. Хэдэн зуун хүн оочерлож байсан. Өглөөнөөс аван оочерлоод, орой тийшээ талон авч, түүнийг нэг дэлгүүрт аваачиж өгөөд, тэндээс өнөө даалимба, цай, тамхи гурваа авлаа. Ийм 3 юм авна гэдэг чинь их том үйл явдал болж байгаа юм шүү дээ. Хөдөө бол тийм зүйл ердөө олдохгүй. Дэлхийн 2-р дайн болоод,

Зөвлөлт улс манайд нийлүүлдэг байсан гурил, будаа, цай, тамхи өгөхөө болиод байсан үе юм л даа. Хүнд юм өгөх нь бүү хэл өөрөө Немцүүдтэй байлдаад хэцүү байсан юм шүү дээ. Тэр үед хөдөө цай байхгүй, ногоон навч түүгээд, хатаагаад цайг орлуулан уудаг байлаа. Эсвэл модны холтсыг үрж, цайг орлуулдаг байсан. Японд ч бас цайг орлуулах навч уудаг байсан байж магадгүй. Энэ бол манай ардын хуучин арга шүү дээ. "Хулгана чих" гэдэг ногоон ургамлыг түүж хатаагаад тамхины оронд хэрэглэдэг байв. Тийм учраас хөдөөнөөс ирсэн хүнд нэг цай, нэг тамхи өгнө гэдэг чинь том үйл явдал болж байгаа юм. Ингээд наадам ч дууслаа даа. Нэг өдөр аав:

-Тэнд хүн цай, тамхины талон хаячихсан байна! гэнэ. Хэрэгцээгүй гээд хаячихсан юм шиг байна! гэж байна.

Тэр үед онгоцны буудлаас нааш байдаг талбайд наадмаа хийдэг байлаа. Тэнд үзэсгэлэнгийн байр, худалдааны байрууд гардаг байсан юм. Яг тэр орчим хаясан талон маш их байна гэж аав дуулжээ. Наадам тарчихсан байсан юм шүү дээ. Тэгээд хоёулаа тэнд очиж, түүнийг түүхээр боллоо. Бид хоёр автобус, морин тэргэнд сууж явсаар тэнд очлоо. Урт мод барьчихаад байшингуудын ёроолоор өдрийн турш шороо ухаад явлаа. Аав бид 2-ын олдог талон ч гэж юу байхав дээ. Юү ч олсонгүй. Намайг сайд байхад манай гэр тэр яармагаас цааш 7-8 км-ийн зайнд ууланд байдаг байлаа. Тэр газрыг "Нүхт" гэдэг юм. Манайх тэнд гучаад жил болсон. Сайд байхдаа ажлаа тараад, хүүхдүүдээ дагуулаад дандаа түүгээр явдаг байлаа. Явах болгондоо өнөө аавтайгаа хамт цай, тамхины талон хайж явсан минь санаанд ордог байж билээ. Тэгээд би хүүхдүүддээ:

-Аав нь ч яахав дээ, ард түмнийхээ буянаар машин унаад, төрийн сайд хийгээд, та нар миний машинд суугаад сайхан л явж байна. Аав нь бага байхдаа, аавтайгаа хоёулаа хаясан талон хайгаад энд бүтэн өдөр явж байсан юм шүү дээ! гэж хэлдэг байлаа. Тэр явдал санаанаас ердөө ч гардаггүй байж билээ. Түүгээр явах болгондоо л санадаг байсан. Бараа таваар ийм л ховор байсан үе юм шүү дээ.

Тэр үед одоогийн цагаан талх байгаагүй юм. Харин хар талх бол байсан. Цагаан талх их ховор байсан. Би бас анх удаа цагаан талх идэж үзэж байлаа. Тэр үед дарга нарын ордог 18-р дэлгүүр гэж байлаа. Манай нэг садангийн хүн тэр дэлгүүрт ордог байлаа. Тэр надад нэг удаа дугуй цагаан талх авчирч өгсөн юм. Амт, өнгө нь хар талхнаас шал өөр байж билээ. Тийм ховор талх байж билээ.

И.Л.: Тэр үеийн дэлгүүрт зарж байсан юмнуудаас санаж байна уу? Юу юу зардаг байсан бол?

П.Д.: Идэж, уух юм их л ховор байсан даа. Байгаа юмнууд нь голдуу Оросын юмнууд байсан даа. Чихэр байсан байх. Өргөн хэрэгцээний бараа элбэг биш байсан байх. Тийм ч учраас хаалттай дэлгүүр, талон байсан

байх л даа. Үнэтэй цайтай ч юм байсан л байх. Их дэлгүүр гэдэг өндөр хоршоогоор зөндөө л орж байсан даа. Баяр дуусахаар хөдөөний бид нар чинь буцах болно шүү дээ. 8-р сард яг л өдийд л дээ. Нутаг буцах дөхөөд л, аав, ээж хоёр ах, дүүгийнхээрээ ороод, бэлтгэж байлаа. Би ч гэсэн наадам үзчихсэн, ахтайгаа уулзчихсан, буцна гээд сэтгэл санаа өндөр, сайхан байлаа.

4 Техникумийн бэлтгэл анги

Манай ах Гомбосүрэн бол миний хувь заяанд их үүрэг гүйцэтгэсэн юм шүү дээ. Нэг өдөр ах:

-Одоо энэ хүүхэд 17 нас хүрчихлээ. Бичиг үсэгт тааруухан, ямар ч боловсрол байхгүй, бага дунд сургуулийн ч боловсрол байхгүй, ийм хүүхдийг та нар авч яваад цаашид яах болж байна? Энд сургуульд оруулвал яасан юм бэ? гэв. Тэгээд ах надаас асууж байна :

-Миний дүү энд сургуульд орох нь зүйтэй байх. Тийм үү? 17 настай гэдэг чинь дунд сургууль төгссөн байх үе. Нас чинь яваад өглөө гэсэн үг шүү дээ. Цэрэгт л татагдана өөр юм байхгүй гэж байна. Би Улаанбаатарт, энэ сайхан гэрэлтэй байшинтай, кинотой газар үлдчихмээр ч юм шиг санагдаад л байлаа. Гэтэл ээж, ааваасаа салаад явна гэхээр сэтгэлд нэг л бууж өгөхгүй байлаа. Бодож, бодож байгаад орох сургууль олдох юм бол үлдэхээр шийдлээ. Тэгээд аав, ээжтэйгээ ч ярилаа.

-Намайг үлдээчих! Би эндээ байж байгаад аргалаад сургуульд оръё! гэлээ. Ингээд аав, ээж, дүү гурав буцаж, би үлдлээ.

Тэгээд ах маань сургууль хөөцөлдлөө. Гэтэл намайг авах сургууль олддоггүй. Мөн ч их хөөцөлдсөн дөө. Бага сургуулийн нэгдүгээр анги бол байна. Түүнд чинь 17 настай банди чинь яагаад ч орж болохгүй шүү дээ. Өшөө тамхи татдаг, бараг авгай авах шахсан хүн явлаа шүү дээ, би чинь. Ингээд бага сургуульд нас таардаггүй. Дунд сургуульд орох гэхээр бага сургууль төгсөөгүй учраас авахгүй гэчихдэг байлаа. Ганц орж болох сургууль нь техникум байлаа. Техникум гэж одоо байна уу, байхгүй юу, мэдэхгүй. Тэр үед техникум гэж дунд боловсрол олгодог сургууль байсан юм. Тэгээд л аль нэгэн техникумд орохоор шийдлээ. Гэтэл техникумд чинь бас сургууль төгссөн хүн авна шүү дээ. Би тийм сургуульд орох ганц зөв зам бол арын хаалга л байлаа. Өөр ямар ч арга байхгүй. Арын хаалгыг хэрэглэхийн тулд танил тал хэрэгтэй боллоо. Гэтэл ах нэг өдөр явж байгаад нутгийн танил хүнтэйгээ тааралджээ. Тэр хүн, хүн эмнэлгийн техникумд ажилладаг байсан юм байж. Ах тэр хүнд :

-Манай дүү сургуульд орох зорилгоор үлдчихсэн боловч орох сургууль байдаггүй! гээд учраа ярьжээ. Тэр хүн:

-Танай дүүг чинь өөрийн сургуульд оруулаад өгье! гэжээ.

Нэг өдөр ах их баяртай ирлээ.

-За чамайг сургуульд оруулахаар боллоо! гэж байна.

-Ямар сургууль вэ? гэлээ.

-Хүн, эмнэлгийн техникум! гэж байна.

-Би түүнд чинь орохгүй! гэж би зөрлөө. Хүн эмнэлгийн техникум төгссөн нэг эмч манай суманд байдаг юм. Тэр эмчид хийхгүй ажил ч гэж байхгүй. Дандаа л яр шарх, өвчин, зовлон, үхэл, хагацал, өнөө гайхал "Улаан тариа"- гаа тарихаас өгсүүлээд барагдахгүй их ажилтай юм шиг санагддаг байлаа.

Тэр хүний хийдэг ажлыг бодохоор эмч болох сонирхол ерөөсөө төрөхгүй байв. Үнэн хэрэгтээ доктор Очирбат гэж нутгийнхан нэрлэдэг байсан тэр эмч маш их буянтай ажлыг хийж байсан, нутгийнхандаа амьд бурхан мэтээр хүндлэгддэг болсныг би хожим мэдсэн юм. Тэр үед монголын хүн ам нийгмийн халдпварт өвчин ихтэй байсан юм шүү дээ. Манай хүн ам чинь хувьсгалын өмнө 600 гаруй мянга байсан. Одоо хоёр сая дөрвөн зуун мянга болчихоод байна. Намайг бага байхад Зөвлөлт улсаас их том бригад ирж, бүх хүнийг толгой дараалан үзэж, аав, ээж, ах, эгч, насанд хүрсэн бүх хүмүүсийг шалдлаад, нүцгэлээд, шалгаад, үзсэн юм гэдэг. Тэгээд өвчтэй байгаагий нь өнөө "Улаан тариа" гэдгээр тарьжээ. Нийгмийн халдварт өвчин гэдэг чинь аюултай өвчин шүү дээ. Монгол хүн үндсэндээ устах гэж байсан юм шүү. Одоо та Монголд хамар нь унасан хүнийг бараг харахгүй байх. Би санаж байна. Намайг хүүхэд байхад манай нутагт хамаргүй хүн олон байсан. Тийм өвчин Монгол даяар байсан юм. Монгол хүн үндсэндээ мөхлийн ирмэгт ирсэн байсан гэдэг юм. Энэ өвчинтэй тэмцэх талаар манай нам, засаг тодорхой арга хэмжээ авч бүх орон даяар эмнэлгийн бригад явуулаад 2-3 жилийн дотор дарсан юм. Тэгээд Монгол хүн чинь эрүүл болоод хүн ам өссөн юм шүү. Одоо тэр зам руугаа эргээд орж байх шиг байна.

Хүн, эмнэлгийн сургуульд орохгүй гэдгээ ахад хэллээ.

-Үгүй, Би нутагтаа очиж малаа маллая! Аав, ээжийнхээ хойноос явъя! гэж ахдаа хэлэв. Тэгтэл ах маань :

-За тэгвэл өөр сургууль олъё! гэж байна.

Тэгж байтал ах дайчилгаанд явах боллоо. Энэ Туул голоор чинь Улаанбаатарт хэрэгцээтэй модыг урсгаж ирдэг байсан юм. Тэр тийм том гол байлаа. Сал гэж мэдэх үү? Сал гэдэг бол модыг хооронд нь холбоод, усанд тавьж урсгаад, урд нь нэг хүн, дунд нь нэг хүн сэлүүрдээд явахыг хэлдэг юм. Одоо Туул гол зарим газраа тасарч байгаа шүү дээ. Намайг Улаанбаатарт ирж байх тэр үед түүгээр сал урсгаж байсан. Манай ах залуу, бага дарга учир Батлан Хамгаалах Яамны ажилчидын хэрэгцээний мод бэлтгэх сарын ажилд дайчлагджээ. Салаар заах модыг Туул голыг

өгсөж дээшээ явж бэлтгэдэг байсан юм. Тэгээд сал хийж түүнийг Туул голоор урсуулаад, Туул голын савд авч ирнэ. Ингэж жилийнхээ модыг бэлтгэдэг байлаа.

Ах нэг өдөр:

-Ах нь ингээд салд явахаар боллоо! гэж хэлж байна.

Салд чинь залуучууд л явна шүү дээ. Би сургуульгүй. Ах салд явж байдаг. Ах бид хоёр айлд байж байдаг. Өөрийн гэр орон байдаггүй. Хүндхэн юм болж байгаа биз дээ.

-Одоо яадаг билээ! гээд ярьцгаалаа.

Ахын дарга Цэдэв гэж хүн байсан юм. Одоо тэр хүн Улаанбаатарт амьдарч байна. Би хараяа очиж золгодог юм. Тэр Цэдэв гуай хэлтсийн дарга байсан юм болов уу даа. Би сайн мэдэхгүй байсан л даа. Ах намайг дагуулж Батлан Хамгаалах Яаман дээр очоод тэр даргатайгаа уулзуулж өглөө. Тэр дарга нь ахыг ажилд явуулж байгаа болохоор уулзалгүй яахав.

-Даргаа! Би ингээд дайчилгааны ажилдаа явлаа. Энэ миний дүү байгаа юм. Та үүнийг нэг сургуульд оруулахыг бодооч! гэж захилаа. Цэдэв гуайд ингэж хэлээд л ах явчихлаа.

Тэр үеийн техникум гэдэг чинь ерөнхий боловсролоор бол хүнд 7 жилийн боловсрол олгодог л сургууль шүү дээ. 8 сар дуусах болчихсон, сургуулиуд хичээлээ эхлэхэд бэлэн болоод байлаа. Тэгээд л би Цэдэв гуайтай өдөр болгон шахуу л уулзана даа. Намайг Яаман дотор оруулахгүй л дээ. Батлан Хамгаалах Яамны гадаа очоод л Цэдэв даргыг дуудуулна даа. Цэдэв дарга гараад ирнэ. Тэгж байсаар байгаад Цэдэв гуай намайг санхүүгийн сургуульд оруулсан юм. Дайны дараа үе байсан болохоор цэргийн дарга нар тэр үед их нэр хүндтэй байлаа шүү дээ. Сургуульд ороход бас их төвөг гарлаа. Цэдэв гуай нэг өдөр намайг дагуулаад Санхүүгийн техникум дээр очлоо. Тэнд бид хоёр сургуулийн хичээлийн эрхлэгч Тагар гэдэг буриад хүнтэй уулзлаа. Би анх удаа буриад хүнтэй уулзаж байгаа минь тэр байсан юм. Буриад хүн хэцүү шүү дээ. Хэл нь ойлгогдохгүй. Хөдөөний хүнд бүр хэцүү. Акцент нь ойлгоход хэцүү юм л даа. Тагар гуай настай ч хүн байсан даа. Надаас юм асууж байна. Би ойлгодоггүй. Тэгээд Цэдэв гуайгаас:

-Энэ хүн юу гэж байна? гэж асуулаа. Гэтэл өнөө хүн уурлаад:

-Монгол хүн монголоороо ярьж байхад чи яагаад ойлгодоггүй юм бэ? гэж байна. Тэгээд Цэдэв гуай түүнд ярьж өглөө.

-Энэ бол хөдөөний хүүхэд юм. Ээж, аав нь буцаад явчихсан. Ах нь сал татах ажилд сараар явчихсан. Үүнийг сургуульд оруулах ажлыг надад даалгасан! гээд л ярьлаа даа. Тэгсэн чинь над шиг боловсролгүй хүүхэд их байдаг гэнэ. Энд тэндгүй байдаг юм байх. Тэд нар бага сургууль төгсөөгүй тэгсэн хэрнээ сургуульд орох хүсэлтэй. Нас нь ч нилээд

явчихсан байдаг гэнэ. Тэгээд Тагар багш:

-Шалгалтанд тэнцвэл энэ хүүг бэлтгэл ангид л оруулж болох юм байна! гэж тэр хэлж байна даа.

Техникумын бэлтгэл гэхээр манай хүү одоо гайхаад байгаа юм. Дээд сургуулийн бэлтгэл бол өөр хэрэг шүү дээ. Их, дээд сургуулийн "Бэлтгэл анги" гэж байдаг шүү дээ. Тэр үед техникумын бэлтгэл анги байгуулагдсан юм байж л дээ. Над шиг хөдөөний хүүхдүүдэд зориулсан юм байлгүй, мэдэхгүй.

-Бэлтгэл ангид орсон ч шалгалт авна. Шалгаад тэнцвэл оруулна, тэнцэхгүй бол оруулахгүй шүү! гэж тэр хэлж байна. Тэгээд нөгөөдөр нь шалгалт өгөхөөр боллоо. Тэр өдөр нь би нөгөө сургууль дээрээ яваад очлоо. Тоо, хэл бичиг хоёроо шалгав. Хэл бичгийн шалгалт нь цээж бичгийг бичүүллээ. Багш хэлээд бичүүлж байгаа юм шүү дээ. Би хөдөө, багийн бүлгэмд суугаад бичиг, үсэг тайлагдсан, сумын бүлгэмд суугаад тайлагдсан, бас хөдөөний бүлгэмийн багш хэдэн сар хийчихсэн болохоор хэл, бичигт тийм ч муу биш байсан юм. Ингээд үүрэгтэй дүн авлаа. Тоонд бол би их тааруу байсан даа. "25" дээр "30"-ыг нэмбэл "55" гээд хэлчихнэ. "50"-аас "20"-ыг хасвал "30" гээд бас хэлчихнэ. Ийнхүү 100-ийн дотор нэмж, хасахыг бол бодчихно. Үржүүлэх, хуваах болохоор ерөөсөө чадахгүй. "7"-г 7-оор үржүүлэх гэвэл чадахгүй. 15-ыг 3 хуваах гэвэл бас чадахгүй. Инхүү үржүүлэх, хуваах болохоор толгой эргээд байдаг байв. Ингээд шалгалтынхаа цээж бичигт дээрээ үүрэгтэй, дунд авчээ. Тоо бол нойл. Тэгэлгүй яахав дээ, бутархай тоогоо ялгаж чадахгүй байсан юм чинь. Бутархай тоог би бүр мэддэггүй байв.

-Шалгуулсан хүмүүс нөгөөдөр ирээрэй. Самбар дээр тэнцсэн хүүхдүүдийн нэрийг бичнэ. Нөгөөдөр ирж тэрийг хараарай! гэж байна. Би нөгөөдөр нь гүйгээд ирлээ. Шалгалт өгсөн хүмүүсийн нэр гараагүй байна. Би маш их эрт ирсэн юм. Сургуульд орчих байх гээд баярлаад л, горьдоод байлаа. Багш нар цуглаагүй байгаа бололтой байна. Тэгж байтал 9 цаг боллоо. Нэг багш гарч ирээд өнөө самбар дээр нэрсүүдийг бичиж эхэллээ. Нэрээ хараад байтал миний нэр байдаггүй. Тэнцээгүй нь тодорхой боллоод явчихлаа.

Хөдөөний хүүхэд амьдрах ухаанд бас муугүй байсан байж магадгүй. Хөдөөний 16-17 насны хүүхэд гэдэг чинь малаа маллана, гэрийнхээ бүх ажлыг хийнэ, тамхи татна, архи ууна шүү дээ. Аавын дараа л гэрийн эзэн болж байгаа байхгүй юу. Тийм учраас амьдрах ухааныг муугүй сурдаг байх л даа. Тэгээд өөрөө бодлоо.

-Шалгалтандаа тэнцсэнгүй. Одоо яадаг билээ! гэж. Тэр шалгалтын комиссын дарга нь Цэрэн багш байсан юм. Тэгээд комиссын дарга Цэрэн багш дээр орлоо. Шалгалтанд тэнцээгүй гэдгээ хэллээ. Цэрэн багш миний

шалгалтын тухай ярьж байна. Тэгэхэд л би яаж шалгалт өгснөө мэдсэн юм.

-За хүү минь, чи цээж бичигт бол тэнцэж байна. Тоон дээрээ чи ерөөсөө тэнцэхгүй байна. Чи нэмэх, хасахыг жаахан мэддэг болотой юм. Үржүүлэх, хуваахыг бол ерөөсөө мэддэггүй юм байна. Бутархайг бол бүр ч чаддаггүй юм байна шүү дээ! гэж байна. Тэгээд би бэлтгэл ангидаа ч тэнцэхгүй болж байгаа юм. Надад зөвлөх аав, ээж, ах өөр дотны хүн байхгүй ийм нөхцөлд өөрөө ухаан зарсан байгаа юм л даа. Тэгээд багшаасаа гуйлаа:

-Багшаа! гэлээ.

-Би бол их холоос ирсэн. Увс аймаг бол манай нутаг л даа. Их хол байдаг. Ингээд одоо өвөл болох гэж байна. Ах маань салд дайчлагдаад явчихсан. Аав, ээж маань нутаг буцаад явчихсан. Би өөрөө айлд байдаг. Надад мөнгө байхгүй, хоол байхгүй. Би ийм хэцүү байдалд байна. Намайг энэ сургуульд оруулж өгөөч гэлээ! Нэрийг нь тэр үед сайн мэддэггүй байлаа л шүү дээ. Гэтэл Цэрэн багш хэлж байна.

-За хүү минь! бид энэ талаар ярилцъя. Би ганцаараа шийдэхгүй. Би шалгалт авсан багш нартайгаа ярилцъя. Чи маргааш хүрээд ир! гэж байна.

Маргааш болтол их л удаан хүлээсэн шиг санагддаг юм. Арай гэж маргааш болгоод л яваад очлоо. Тэнд хэдэн багш сууж байна. Өнөө шалгалт авсан багш нар шүү дээ. Цэрэн багш, Дэжидмаа багш, Дулмаа багш, Дашаа багш нар сууж байна.

-Бид ярилаа. Чи харахад их сэргэлэн хүүхэд байна. Чи оролдвол юм сурчихаж магадгүй хүүхэд юм. ДааНч чамд ямар ч бэлтгэл алга. Тийм учраас чи бэлтгэл ангид хагас жил хүртэл суу. Хагас жил гэдэг чинь нэг сарын 1 хүртэл гэсэн үг шүү. 9 сараас эхлээд хагас жил дуустал суу. Хэрвээ хүү минь ээ, чи хагас жилээр муу гарвал хасагдана шүү. Тэгээд чи нутаг явна уу, байна уу, өөрөө л мэдсэн хэрэг болно шүү. Тэр үед чинь өвөл болчихсон байна. Улаанбаатарт их хэцүү шүү дээ. Чи сайн бод! Одоо нутаг буцна уу? Ингээд сургуульд орно уу? гэж байна. Надад зөвлөх хүн байхгүй юм чинь өөрөө шийдээд :

-Би хагас жил дуутал сураад үзье! гээд хэлчихлээ. "Дүүрсэн хэрэг, үзээд алдъя" гэж бодогдоод байлаа.

Тэгээд л хагас жил дуустал ямар ч тусламжгүйгээр суралцахаар боллоо. Тэр үед их журамтай байсан юм. Манай сургуулийн дотуур байртай байсан юм. Тэр дотуур байранд намайг суухыг зөвшөөрсөнгүй. Би айлд байгаа болохоор дотуур байранд орчих санаатай байсан юм. Би нэгэнт туршилтын хүн болж таарч байгаа юм чинь дотуур байранд суулгаагүй юм. Гадуур суудаг хүүхдүүдэд сард зуу гаруй төгрөгийн

хоолны мөнгө өгдөг байсан. Түүнийг надад бас өгөөгүй юм. Их хэцүү байсан байгаа юм шүү. Тэгээд хагас жилээр муу гарахгүй бол эдгээр тусламжийг авдаг болно. Харин нэг л хичээлд муу авбал хасагдана шүү дээ. Цэрэн багш ер нь их хатуу хүн л дээ. Түүхийн багш хүн.

Ингээд би сургуульдаа орчихлоо. Сургуульд орсон анхны өдөр би ганцхан дэвтэртэй очсон чинь тооны хичээл, хэл бичгийн хичээл, аман зохиол, географ, байгаль гээд 5-6 цагийн хичээл орлоо. Би чинь бүгдийг нь нэг дэвтэр дээр л бичлээ. Цэрэн багш ажиглаад:

-Чи ингэж бичиж болохгүй. Хичээл болгоныг тус тусад нь дэвтэр дээр бич. Тооны дэвтэр, хэл бичгийн дэвтэр, географийн дэвтэр гээд тус тусдаа байх ёстой. Ингэж болохгүй гэж байна. Би:

-Надад дэвтэр байхгүй гэлээ.

-За чи дэвтэр олж ав! гэж байна. Тэр үед ч дэвтэр харандаа бас ховор байсан юм. Улаанбаатарт ч ховор байсан юм. Хөдөө бол бүр байхгүй. Ихэнх нь модон самбар дээр бичнэ. Захаар гүйж байгаад хэдэн дэвтэр оллоо. Би ч тэгэхэд их хичээсэн дээ.

Ах дайчилгааны хугацаа дуусаад ирлээ. Намайг сургуульд орсон гэдгийг сонсоод баяр, хөөр болцгоолоо. Бид хоёр нөгөө айлдаа л байгаад байлаа. Цаашдаа өөрийн гэртэй болно гэж ах ярьдаг байлаа. Ах авгай аваагүй байсан юм. Цэрэг хангамж сайтай газар байсан. "Цэргийн хангамжийн газар" гэдэг тусгай байгууллага байсан юм. Тэндээс ахад нэг гэр өглөө. Тэгээд бид нар тэр гэртээ тусдаа амьдрах боллоо.

Би сургуульдаа яваад байлаа. Өдөр ирээд ахын хоол ундыг бэлтгэнэ. Бас манайд нутгийн 4-5 хүн ирсэн байлаа. Монгол хүн гэдэг чинь их сонин шүү дээ. Нэг л танил бол тухайлбал, одоо би Лхагвасүрэнтэй танил бол гэрт нь очоод хэвтчихнэ. Хоолыг нь идээд л байгаад байна. Мөнгө ердөө чиг өгөхгүй. Өөрөө мах, хоол унд хааяа авбал авна. Тэгээд л хоолыг нь идээд л байгаад байна даа. Манай нутгаас ирсэн 4-5 хүн, ах бид хоёртой нийлээд 5-6 хүн байсан юм. Би үндсэндээ тэдний галч нь байлаа. Хоолыг нь хийнэ, түлээ, модыг нь янзлаж бэлтгэнэ. Энэ ажлуудыг хийж дуусаад л дараа нь хичээлээ хийнэ. Надад ширээ сандал гэж олигтой юм байхгүй. Нэг мухар сандал шиг юм, нэг жижигхэн ширээ шиг юм байсан.

Тэгэхэд бид юугаар амьдарч байсан бэ? Тэр үед цэргийн хангамж их сайн байсан юм шүү дээ. Манай ах дэслэгч цолтой, офицер болчихсон байв. Тэр үед цэргийн дарга нар өдөрт 1 кг махны нормтой, сард нийлүүлээд 30 кг мах авдаг байлаа. Өдрийн 500 гр гурил, хоолны хольц авна. Үүнд : давс, хар перец гээд ер нь авахгүй юм байхгүй. Гутлын тосоо хүртэл авдаг байлаа. Би цэргийн агуулахаас түүнийг нь очиж оочерлож байж авна даа. Бид нар өнөө 10 шахам хүн чинь тэр мах, гурилаараа хоол хийж идээд амьдарч байлаа.

Улаанбаатарт өвөл хөдөөтэй адилгүй их хэцүү байсан юм шүү дээ. Хөдөө бол гэрээ эсгийгээр сайхан давхарлачихна. Манайх чинь сайхан байсан юм. Энд чинь ах, бид хоёр дан бүрээстэй гэрт байлаа. Өвөл Улаанбаатарынхан ч гэсэн шалаа дулаалаад, гэрээ давхарлаад сайхан болгоно. Манай гэр дан бүрээстэй, өглөө босоход хаалганы завсраар, ханын хажуугаар цас орж ирээд хунгарлачихсан байдаг байлаа. Пийшин байхгүй, ганц төмөр зуухтай, нойтон түлээтэй, мөн ч хэцүү байсан даа. Миний хувцас тааруухан, зун ирсэн учраас дулаан хувцас байхгүй, их даардаг байлаа. Уушиг муудаад улайгаад байсан. Дан цагаан цамцан дээрээ хөвөнтэй хүрэм өмсөөд,урт өмд өмсдөг байлаа. Би чинь жижигхэн биетэй байсан учраас өмд унжаад явна. Тэр үед Монголчууд өмдийг костюм шиг савхин гутлынхаа гадуур тавьчихна. Миний хөвөнтэй өмд чинь савхин гутлынхаа гадуур явна. Би их жижигхэн биетэй байсан юм шүү дээ. Тэр өвөл их даарсан даа. Орой болоход манайд байгаа хүмүүсийн хоол, ундыг бэлтгэж өгнө. Тэгээд 9-10 болоход тэд нар унтаад өгнө. Би хичээлээ хийгээд, шөнө 11-12 цаг хүргээд унтана.

Тэгээд хагас жилээр бүх хичээлдээ онцсайн гарлаа. Тэгээд би санхүүгийн сургуульд 4 жил онц сурлаа. Ангийн дарга, сурагчдын зөвлөлийн дарга, дараа нь эвлэлийн үүрийн дарга боллоо. Үндсэн анги бол 3 жил шүү дээ. Бэлтгэл ангид нэг жил сурсан юм. Би 1946 онд энэ сургуульд ороод 1950 онд төгссөн. Намайг сурч байхад багш нар маш залуу хүмүүс байсан. Үнэхээр манай шилдэг сурган хүмүүжүүлэгчид байсан байгаа юм. Сүүлдээ 60-70 аад оны үед манай бүгд гавъяат багш болцгоосон шүү дээ. Тагар багш, Цэрэн багш, Дулам, Дэжидмаа багш нар "Монгол улсын гавъат багш" цолоор шагнуулсан. Ийм том сурган хүмүүжүүлэгчид бидэнд зөвхөн эрдэм ном биш, хөдөөний хүүхэд биднийг амьдралд бас сургаж байсан юм. Манай бэлтгэл ангид 20-иод хүүхэд байсан. Ихэнх нь над шиг л сургуулиас завсардсан хүүхдүүд байсан байх. Намайг тэр багш нар харж үзээд сургуульд авсан юм шүү дээ. Уг нь бэлтгэл ангид 15-аас дээш насны хүүхэд авддаггүй байсан. Би 17 настай байсан боловч орчихсон. Би үндсэндээ 2 нас дараад орсон юм шүү дээ. 17 настай бол авахгүй гэж багш хэлээд байсан. Би тэгээд багшаас гуйсан юм л даа.

-Багшаа! Намайг 14-тэй гээд бүртгээд өгөөч! гэж.

Би чинь бие жижигхэн учраас 15-тай гэж болох байсан л даа. Миний гуйснаар багш бүртгэж өгөөд, тэгээд орсон юм шүү дээ.

Сургуульд сурч байхад багш нар эрдэм ном, ер нь соёлд сургаж байж. Биднийг сурч байхад хагас жилийн шалгалт, бас улирлын шалгалт болно. 3 сар болоод л нэг шалгалт, амралт болдог байлаа. Яг амралт болохоор л манай сургууль крантин тогтоочихно. Улаанбаатар хотод өвчин гарсан

гээд багш нар гадагш нь гаргадаггүй байлаа. Гадна байгаа хүүхдийг дотогш нь оруулахгүй. Сүүлд нь сонсоход багш нар хүүхдээ ямар нэг хулигаантсан юманд оруулахгүй, гадуур дэмий тэнүүлэхгүй гээд крантин тогтоочихдог байж. Өдөрт 2 кино гаргаж үзүүлнэ. Хоол унд нь сайн байсан болохоор хүүхэд 16 хоног амрахдаа одоогийнх шиг хулигаантах юм байдаггүй. Тэр үед бид өвчин гарч дээ л гэж бодно. Сүүлд нилээд дээд ангид ороод л багш нар өвчин гарлаа гэж зохиодгийг ойлгосон юм. Манай багш нар биднийг бэрхшээл зовлонг туулан гарах арга замыг бас зааж өгч байжээ.

94-онд манай сургуулийн 70 жилийн ой боллоо. Бидний төгсөгчид цугларлаа. Уг нь ч дандаа цуглардаг л даа. Тэр үед цугласан хүмүүс заал дүүрсэн байсан. Надад урьдчилаад юм ярь гэж хэлээгүй байсан. Гэтэл тэр өдөр та дурсамжаасаа яриач гэсэн хүсэлт ирлээ. Би тэр үед сая та нарт хэлдгийгээ хэлсэн. "Би хөдөөнөөс ямар хүн орж ирлээ. Тэгээд сургуулиа төгсөөд хойшоо Оросод явж сураад, эргэж ирээд нам засгийн удирдлагад орж ажилласан явдал бол миний сайных биш ээ. Энэ сургуульд ардын хүүхдүүдийг хүмүүжүүлсэн том, том сурган хүмүүжүүлэгчид ажиллаж байсны ач гавъяа юм шүү!" гэж хэлсэн. Би ийм л сургуульд ингэж сурсан юм даа. Ингээд Улаанбаатарт хөдөөнөөс орж ирсэн үе дуусч байгаа юм.

П.Д.: Та надаас асуух, тодруулах юм байвал дор, дор нь асуугаад л явах хэрэгтэй. Би таны бичсэн өгүүллийг уншиж үзсэн. Та бол Монголыг, Монголчуудын амьдрал ахуйг судлаж байгаа эрдэмтэн хүн юм байна. Тийм учраас асууж лавлах юм байвал ичиж зоволгүйгээр асуугаарай. Намайг урьж, ингэж уулзаж, ярилцаж байгаад чинь би их баярлаж байна.

К.Ю.: Маш их сонин яриа ярьж өгч байгаад баярлалаа.

П.Д.: Миний ярьж байгаа зүйл таны сонирхолд нийцэж байна уу? Би Лхагвасүрэнг урьд нь таньдаггүй байсан. Манай гэрийг яаж олсон юм бэ? Мэдэхгүй. Японоос ирсэн эрдэмтэн хүн надтай уулзах хүсэлтэй байна гэдгийг бичиж үлдээсэн байсан. Би Лхагвасүрэнд:

-Тэр эрдэмтэн чинь очиж, очиж надтай уулзах гээд байхдаа яадаг юм бэ? гэж хэлээд байгаа юм. Та намайг урьж, уулзаж байгаад баярлаж, талархаж байна. Та бол Монголд их туслаж байгаа, цаашид ч их туслах гэж байгаа хүн юм байна. Тийм учраас асуух юм байвал ичиж зовох хэрэггүй. Би бодсон зүйлээ өөрийнхөөрөө л хэлнэ. Миний ойлголт зөв байж болно, бас буруу ч байж болно, алдаатай ч байж болно. Тэр бол өөр хэрэг. Тийм асуух зүйл байвал та сэтгэл зоволтгүй асуугаарай. За ингээд өөр юу ярих вэ?

5 МАХН-ын Төв Хороонд

К.Ю.: Сургууль төгсөөд дараа нь юу болсон бэ? Орост явсан уу?

П.Д.: Орост явахын өмнө би чинь ажил хийсэн байхгүй юу.

К.Ю.: Тэр талаар ярьж өгөөрэй.

П.Д.: Би сургуулиа "Төсвийн нягтлан бодох" гэдэг мэргэжлээр төгссөн юм. Сургууль төгсөөд МАХН-ын Төв Хороонд очсон. Миний амьдрал их сонин байгаа юм шүү дээ. Би улсад ажил хийж эхлэхдээ МАХН-ын Төв Хорооноос эхлээд, тэндээсээ тэтгэвэрт гарсан. 50-иад онд сургууль төгсөөд МАХН-ын Төв Хорооны санхүүгийн хэлтэст ажиллаа. Түүний өмнө, эхлээд Сангийн яаманд очив оо. Манай сургууль чинь Сангийн яамны харъяа сургууль байсан юм. Намайг ороход санхүүгийн техникум гэдэг нэртэй байгаад, дараа нь санхүү эдийн засгийн техникум гэдэг болсон. Тэгээд сургууль төгсөөд Сангийн яамны "Санхүүгийн хянан байцаах газар" гэдэгт байцаагч боллоо. Болж байна уу? Намайг ажилд орж байх тэр үед Аж үйлдвэрийн комбинатад санхүүгийн шалгалт хийж байсан юм. Би тэр шалгалтад орлцоод нэг сар орчим л ажиллаад байсан байх. Гэнэт нэг өдөр манай яам намайг дууджээ.

К.Ю.: Тэр яам хаана байсан бэ?

П.Д.: Одоогийн Сангийн Яам байгаа тэр л байшиндаа байсан. Тэнд бас Улсын банк байсан. Одоо "Голомт" банк байна. Дээр үед тэнд доор нь банк, дээр нь яам байсан юм. Би дуудсан ёсоор яаман дээрээ яваад очсон чинь урдаас :

-МАХН-ын Төв Хороон дээр оч. Чамайг тэнд дуудаж байна! гэлээ. Би сургуульд сурч байхдаа 1949 онд МАХН-ын гишүүн болсон байлаа. Намын гишүүн хүнийг Намын Төв Хороо дуудахаар бас л их айж очно шүү дээ. Хэрэг хийсэн юм болов уу, юу болсон юм бол гээд л бодож байлаа. Тэгээд очтол, Намын Төв Хорооны санхүүгийн хэлтсийн дарга С.Нанзад гэдэг хүнтэй уулзах хэрэгтэй боллоо. Тэгээд түүнтэй уулзлаа. Тэр хүн сайхан зантай хүн байсан юм. Надтай жаахан юм ярилаа. Надад л настай хүн харагдаж байсан байх. Одоо миний үеийг бодвол хамаагүй залуу хүн байсан даа. Дөчин хэдэн настай л хүн байсан биз. Тэгээд:

-Чамайг эндээ авна. Чи ирэх үү? гэж байна.

Намын гишүүн хүнийг Намын Төв Хорооны санхүүгийн хэлтэс ажилд авах гэж байхад зөвшөөрөлгүй яахав дээ. Тэгээд намайг санхүүгийн хэлтэст "Данс хөтлөгч" болголоо. "Данс хөтлөгч" гэдэг чинь хамгийн доод албан тушаал шүү дээ. Надтай хамт сургууль төгссөн хүмүүс бүгд "Нягтлан бодогч" болцгоосон явж байлаа шүү дээ. Хүмүүст хийж байгаа ажлаа хэлэхэд хэцүү санагддаг байлаа.

-Чи тэнд юу хийдэг юм бэ? гэхээр нь "Данс хөтлөгч" гэж хэлэхээр ичээд, зүгээр л "санхүүд байгаа л...." гээд байдаг байсан. "Данс хөтлөгч" гэж одоо байдаг юмуу, үгүй юмуу мэдэхгүй. Энэ чинь хамгийн доод ажил шүү дээ. Хар, бор ажил гэсэн үг л дээ. Тэр дарга ухаантай хүн л дээ.

Сургууль төгссөн залуу хүнийг ингэж амьдралд сургаж байсан байх. Тэр дарга хэлтэсдээ өөр нэг орон тооны нягтлан бодогчтой байсан юм. Тэгээд намайг данс хөтлөгчөөр хагас жил буюу 1950 оны 7-р сараас 51 оны 1-р сар хүртэл ажиллуулаад дэвшүүлээд нягтлан бодох болголоо. Тэр дарга бас намайг шалгаж л байсан байх. Хийж чадах нь уу, яах нь вэ гэж шалгаж байсан юм билээ. Ингээд би Намын Төв Хороонд данс хөтлөгчөөс нягтлан бодох хүртэл 2 жил буюу 50 оны 7-р сараас 1952 оны 9-р сар хүртэл ажилласан юм.

Япон хүнд ойлгоход хэцүү байж магадгүй нэг зүйл байсан. Бид чинь нягтлан бодох ажлаа сампингаар л бодно шүү дээ. Японд тийм сампин байсан уу? Хятад сампин шүү дээ.

К.Ю.: Байсан шүү. Жаахан өөр байх.

П.Д.: Жаахан өөр үү. Манайх бол Хятад сампин ч л байсан, Орос сампин ч л байсан. Тэр үед бас тооны машин дөнгөж гарч байсан юм. Тэр тооны машиныг "Джержинск" гэж нэрлэдэг байлаа. ЗХУ-ын Джержинскийн нэрэмжит заводод хийсэн машин байсан юм шиг байна билээ. Тэр машин одоо музейд л очсон байх. Түүгээр тоо бодоход 2-ыг 25-аар үржүүлэх бол "2" ба "5" гэж тус тусад нь тоог нь дараад, тэгээд төмөр татуургыг нь татдаг байсан. Миний энэ хоёр хуруу бүр эвэр ургачихсан байдаг байлаа. Төмөр татуурга нь татахад маш хатуу байсан. Өдрийн турш түүнийг татаад байна. Тэр машин Намын Төв Хороонд нэг л байсан. Манай тасагт л байсан байх. Том газар байсан болохоор машинтай байсан юм. Жижиг газар бол машин очихгүй шүү дээ. Өшөө нэг сонин юм болдог байлаа. Энэ бол хүний сэтгэл зүйтэй холбоотой асуудал юм. Өдөрт нь суугаад өнөө тооны машинаар цалин хөлс ч байдаг юмуу, голдуу л цалин хөлстэй холбоотой юм л бодно шүү дээ. Миний найз Сандаг гэж нөхөр байсан юм. Тэр бид хоёр Төв Хороонд цуг очсон юм л даа. Тэр Төв Хорооны санхүүгийн тасгийн байцаагч хийдэг байлаа. Бид хоёр хамтдаа суугаад, өнөө тооны машинаараа бодно шүү дээ. Хүний дэргэд сампингаар бодохгүй.

-Бэлээхэн тооны машин байхад түүнийг ашиглаж чадсангүй! гэж хүмүүс муу хэлнэ шүү дээ. Тэгээд л тооныхоо машиныг "Шарр! Шарр!" хийлгээд л татаад байна шүү дээ.

-Энэ тооны машинд итгэж болохгүй. Тооцоо буруу бодвол шоронд орно шүү дээ! гээд л хоорондоо ярьдаг байлаа. Тийм учраас хоёулаа орой суугаад, өдөр нь тооны машинаар бодсон юмаа сампингаараа бүгдийг нь шалгана даа. Сампингаараа шалгаад зөв байвал сая санаа амрана. Хүний сэтгэл зүй гэдэг чинь ийм онцлогтой юм л даа. Машиндаа тийм сайн итгэхгүй байгаа юм. Тэгсэн хирнээ хүний дэргэд машинаа ажиллуулаад, тооцоогоо боддог байлаа. Тэр тусмаа тэр машин чинь том, том газруудад

нэг, нэг л байна.

Иймэрхүү маягаар ажил хийгээд байж байтал Монгол Улсын Их Сургуулийг төгссөн 4 залуу Төв Хороонд ирлээ. Контор ч багадаад явчихлаа. Тэд нартай танил болоод ирлээ. Тэр 4 намайг их ятгадаг байлаа. -Ийм залуу хүн байж дээд боловсролгүй бол болохгүй. Дээд сургуульд орох хэрэгтэй! гэдэг байлаа. Төв Хорооны үндсэн албан хаагчид нь дандаа дээд боловсролтой хүмүүс байсан. Би яахав дээ, доод тушаалын хүн л дээ. Гэсэн ч намайг хүмүүс дээд сургуульд орохыг ятгаад байлаа.

Дээд сургуульд болохоор 10 жилийн сургууль төгсөөгүй хүнийг авдаггүй байсан. Дахиад л бэрхшээл үүсч байгаа юм л даа. Техникумд бол 7-р ангийн боловсрол л олгодог. Дахиад 10 жил төгсөх шаардлага гарч ирж байгаа юм. Тэр үед над шиг завсрын хүмүүс их байж. Улаанбаатар хотод "Ажилчин залуучуудын оройн дунд сургууль" гэдэг сургууль байгуулагдаад ажиллаж байлаа. Тэнд 8, 9, 10-р ангийг 3 жил сураад төгсөнө. Өдөр нь ажлаа хийнэ шүү дээ. Орой нь өнөөх сургуульдаа явна. За тэр ч яахав дээ. Чанар бол тааруухан шүү дээ. Багш нар нь хичээл их таслана. Сурагчид нь ажил хийж байгаа хүмүүс шүү дээ. Хөдөө гадаа их явна. Ирэхээсээ ирэхгүй нь их байлаа. Багш нар нь ч бас ирэхээсээ ирэхгүй нь их байна. Ямар ч байсан нэг үнэмлэх олж авах хэрэгтэй байсан юм. Тэгээд 2 жил хагас яваад 10 жилийн сургууль төгссөн үнэмлэх авлаа. Тэгээд би хойшоо ЗХУ-д сургуульд явах өргөдлийн тухай, хаана ямар сургуульд сурах, үүний тулд юу хийх тухай бодож эхэллээ. Тэгээд эдийн засагч, өөрийнхөө мэргэжлийн дагуу учраас эдийн засагч л болсон нь дээр гэж боддог боллоо.

6 Зөвлөлт улсад суралцах болов

Та дуулсан уу? "Улсын төлөвлөгөөний комисс" гэдэг байгууллага байсан юм. Тэр байгууллагын нэр дээр сурахаар даргад нь өргөдөл бичлээ. Би Намын Төв Хороонд данс хөтлөгч, дараа нь нягтлан хийгээд бас ч нилээд хүмүүсийг таньдаг болчихсон байлаа. Намын Төв Хорооны нягтлан гэдэг чинь бас ч тийм бага хүн биш байхгүй юу. Цалинд 440 төгрөг авдаг, базарваань том хүн байхгүй юу. Тэгээд өргөдөл бичтэл, эхний жил бүтсэнгүй. Дараа жил нь 1952 онд дахиад бичлээ. Тэр үед ЗХУ-ын төлөвлөгөөний комиссын шугамаар жилд 2 хүн явуулдаг байлаа. 1952 онд 4 хүн явуулахаар болжээ.

Тэр үед журам их нарийн байсан. Тэр явах хүний хоёрыг нь арван жил төгссөн хүүхэд дотроос авахаар болжээ. Энэ бол үг дуугүй, шууд авна гэсэн үг л дээ. Үлдсэн хоёрыг нь ажил хийж байсан хүмүүсээс авахаар тогтсон байлаа. Тэгээд энэ хоёр хүний асуудал дээр одоогийнхоор бол өрсөлдөөн боллоо. Тэгэхдээ чөлөөт өрсөлдөөн биш юм. Шалгалт авна.

Би чинь 10 жил төгссөн, нэг үеээ бодвол жаахан гайгүй болсон байлаа. Тэгээд шалгалтанд орох хүмүүсийг Их сургууль дээр аваачлаа. Шалгаж байна. Би ч шалгалтанд орлоо. Би чинь 10 жилийг оройгоор төгссөн боловч тэр сургууль чанар муутай байсан. Түүх шалгууллаа. Түүх бол яахав дээ, уншаад мэдэж болно. Түүхийн шалгалтанд үүрэгтэй авлаа. Тоо шалгалаа. Дээд тоо шалгаж байна. Би дээд тоог юу мэдэх вэ дээ. 10-р ангийг оройгоор чанаргүй төгссөн юм болохоор мэдэх юм байхгүй шүү дээ. Шалгахаар ирсэн багш нь сүүлд манай Гэгээрлийн яамны сайд болсон Д. Ишцэрэн гуай юм л даа. Сайд болсон хойно нь би түүнд:

-Та нар хүнийг мөн баллаж байж билээ! гэж тоглоомоор хэлдэг байсан юм.

Ишцэрэн гуай шалгахаар орж ирээд л 10-р ангийн тоо өгсөн байх. Надад бол их хэцүү л тоо байсан. Би нэгийг нь ч мэдэхгүй юм.

Саяхан би тэр нөхөртэй тааралдсан. О.Санзайжав гэдэг хүн байсан юм. Тэр Ленинградын Их Сургуульд явсан юм. Тэр их сургуулийн нэгдүгээр курсээс явж байв. Тэр миний хажуугийн суудалд суулаа. Би шалгалт өгч явах хугацаандаа түүнтэй зүс таних болсон байсан.

-Санзайжав аа, өвгөөн! Наадхаа нааш нь өгчих өө, би хуулчихъя! гэлээ. Санзайжав бол "А" хэсэг, би бол "Б" хэсэг байсан юм.

-Дүүрсэн хэрэг, чинийхээр "А" гээд бичлээ! Намайг хаана сууж байсныг тэр багш мэдэв гэж үү! гэлээ. Санзайжав их сургуульд сурч байсан болохоор сайн бодсон байна. Би нэг бодлогыг нь зориуд буруу бодоод, хоёрыг нь яг хуулаад, нэгийг нь мэдэхгүй юм чинь буруу бодоод өгчихлөө. Тэгсэн "Дунд" авчихсан байна.

Гурав дахь шалгалт нь Орос хэл юм л даа. Би Орос хэл юу ч байхгүй. Цээж бичиг бичсэн юм. Багш дуудаад хэлж өгснийг нь бид бичнэ. Нэг нөхөр орж ирээд дуудлаа. "Миний эх орон" буюу "Моя родина" гэсэн гарчигтай байсан. Хэл мэддэг хүн бол амархан л бичнэ шүү дээ. Гучин хэдэн үгтэй байсан байх. Би түүний 29-ийг нь алдсан байгаа юм. ДааНч хэрэг байхгүй. Хэл мэдэхгүй юм чинь тэгж алдалгүй яахав дээ. Хүний амыг дагуулаад ч бичиж чадахгүй л байлаа шүү дээ. Шалгалтын комиссд нь Ц.Дүгэрсүрэн сайд орсон байсан. Тэр хүн сая хөөрхий нас барлаа. Төв Хорооны хэлтсийн эрхлэгч О. Цэдэндамба гуай комиссын дарга нь байлаа. Комиссын гишүүд нь Дүгэрсүрэн гуайгаас гадна шүүх яамны дэд сайд, өшөө нэг хүн, нийт гурван хүн байсан юм. Тэд нар хожим нь бүгд л сайд болсон.

-Та нар хүний хувь заяаг баллаж байсан улс шүү! гэж би хожим тэдэнд тоглож хэлдэг байсан юм. Өнөөдүүл чинь дуудаад л оруулна шүү дээ. Ажлаас явах гэж байгаа хүмүүсийг нэг, нэгээр нь дуудна.

Надтай хамт шалгалтанд Б.Ренчинпэлжээ гуай орж байлаа.

Төлөвлөгөөний комиссын орлогч дарга хүн л дээ. Өөр нэг нь Я. Дэмчиг гэдэг хүн байсан юм. Бид 3 өрсөлдөж байгаа юм. Ренчинпэлжээ гуайн хувьд бол Ю.Цэдэнбал дарга явуулахыг даалгасан хүн юм. Нас нь явчихаасаа өмнө дээд боловсролтой болог гэж үзсэн юм билээ. Тэр маш сайн хүн байсан. Төлөвлөгөөний комиссын орлогч дарга хэрнээ дээд боловсролгүй байсан. Ю.Цэдэнбал дарга чинь хүнд их хайхрамжтай ханддаг хүн байсан юм шүү дээ. Ю.Цэдэнбал дарга явуулахаар даалгасан болохоор Ренчинпэлжээ гуайг шалгалтанд тэнцүүлсэн. Нөгөө Дэмчиг гэдэг хүн чинь чөлөөт бөхийн Магсар багшийн аав юм шүү дээ. Дотоод яамны санхүүгийн газрын дарга, хурандаа цолтой том хүн байлаа. Орос хэлэнд жигтэйхэн сайн. Дэмчиг гуай чинь Оросуудтай ажилладаг байсан.

Өнөө дөрвөн хүний хоёр нь дунд сургуулиас авсан болохоор үг дуугүй тэнцсэн байлаа. Нэгийг нь Цэдэнбал дарга явуулахаар даалгасан болохоор би хасагдаж байгаа юм. Өнөө комиссын хуралд орлоо. Тэгсэн чинь:

-Чи үүнийгээ хар даа! 30 хэдэн үгнээс 29-ыг нь алдсан байна шүү дээ. Зөвлөлтөд дээд сургуульд сурах гэж байж Орос хэлгүй, чи очоод яаж сурах юм бэ? гэж хэлээд хасаад хаячихлаа. Бүр сүүлд, наян хэдэн онд миний бичсэн диктантыг хүн архиваас авч ирж өгсөн юм. Одоо надад хадгалагдаж байгаа.

Бүр 8 сарын эцэс болчихсон хүүхдүүд бараг бүгд явчихлаа. Жаахан гомдолтой л байлаа.

-За яахав дээ, ня-богоо л хийе! гэж бодоод явж байлаа. Төлөвлөгөөний комиссын 1-р орлогч сайд А.Дулмаа гэдэг авгай байсан юм. Тэнд олон жил ажилласан эмэгтэй хүн л дээ. Төв Хороо, Төлөвлөгөөний комисс хоёр чинь нэг дороо байсан юм. Нэг өдөр Дулмаа дарга намайг дуудаж байна гэнэ. "Юу болсон юм бол?" гэж бодлоо. Сургуулийн асуудал бол бүр шийдсэн байсан шүү дээ. Тэгээд Дулмаа гуай дээр орлоо. Би түүнд өргөдөл олон өгөөд бүр танил болчихсон байлаа.

-Үгүй хө, өчигдөр Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөн боллоо. Төлөвлөгөөний комиссын нэр дээр явах хоёр хүн батлагджээ. Харин Дэмчиг хасагдчихлаа. Чи залуу хүн байна, хөөцөлдөөч! Дарга нар дээр ороох! гэж байна. НТХ-ны нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөн болдог байсан юм. Тэр зөвлөгөөнөөр гадаадад явах оюутнуудыг батладаг байлаа.

-Москвад гудамж болгонд архины мухлаг байдаг юм чинь Дэмчиг очоод түүнээс салахгүй.Тэгээд хөөгдөөд ирнэ! гээд түүнийг хасчихжээ. Дарга нар архи уудаг хүнийг явуулсангүй. Ингээд хасчихаар нэг хүн дутуу үлдлээ гэсэн үг биз дээ. Орон тоо гарлаа гэсэн үг.

Сургуулийнхан бараг явчихсан, 8 сарын эцэс болчихсон байлаа. 9-р

сарын нэгэнд хичээл эхлэнэ. Одоо нас барсан, ТХ-ны гол нарийн бичгийн дарга буюу 2-р нарийн бичгийн дарга Дамба гэж хүн байсан юм. Тэр үед Дамба дарга л бүх кадрынхаа асуудлыг шийддэг байлаа. Дамба гуай дээр орох гэсэн чинь хүлээж авдаггүй. Жижиг хүнийг том дарга хүлээж авахгүй шүү дээ. Завгүй гээд байдаг. Одоо амьд байгаа ТХ-ны боловсон хүчин эрхэлсэн нарийн бичгийн дарга С. Сосорбурам гэдэг хүн байсан юм. Сосорбурам гуай дээр орох гэсэн чинь бас авдаггүй. Миний орж чаддаг дарга нь манай санхүүгийн хэлтсийн дарга Нанзад гуай л байлаа. Бас хэрэг эрхлэх газрын дарга Т.Лувсандэндэв гуай дээр орж чадна. Байж, байж л Лувсандэндэв гуай дээр нэг орно доо.

-Ингээд орон тоо гарсан байна. Намайг явуулаад өгөөч! гэж хэлнэ. Өөр яахав дээ, хүлээж авдаг том дарга байхгүй юм чинь. Тэгээд Нанзад гуайгаа шалаад байдаг. Нанзад гуай их сайн хүн байсан юм.

-Би дарга нартай яринаа л! гээд байдаг. Яринаа гэсээр байтал 8 сар дууслаа.

Тэгээд нөднин нас барсан ТХ-ны боловсон хүчний эрхлэгч А.Галсан гэж хүн байсан юм. Тэр үед бид нар нэг доор конторлодог байсан юм. Тэр үеийн албан хаагчид чинь өглөө 9 цагт цуглаад өдөр завсарлагаа байхгүй, орой 5 цагт тардаг байлаа. 5 цагт тараад гэртээ харьж хоолоо идээд, орой 8 цагт дахин цуглаад ажиллана. 8 цагт цуглаад 11 хүртэл ажиллана. 11 цагаас хойш сууна уу, байна уу, өөрсдөө мэднэ. Ийм журамтай байлаа. Хэцүү шүү. Би тэр үед л ажил хийж эхэлсэн байгаа юм. Би чинь хүүхэд байсан. Ордон одоогийнхоо байранд ирчихсэн байлаа. Ордон чинь 1950-иад онд ашиглалтанд орсон юм шүү дээ. Элдэв-Очирын нэрэмжит кино театр Сүхбаатарын талбай дээр нээгдчихсэн байлаа. Хүүхэд юм чинь сайхан кино гарвал үзмээр байна. Бас тэрүүгээр явж охидуудыг хармаар санагдаад байна. Тэгтэл оройд нь зав байхгүй. Заримдаа манайхан нэг арга хэрэглэдэг байсан. Орой нь 8 цагт ирж бүртгүүлчихээд, 9 цагийн юмуу, 10 цагийн кинонд орно. Тэгэхдээ пальтогоо өлгүүрт өлгөчихөөд, гэрлээ асаагаад, үүдээ онгорхой хаячихна. Тэгэхээр хүн орж ирээд:

-Өө, энэ пальто нь байна. Гэрэл нь асаатай байна. Дотуур л явж байна даа! гээд явчихна. 10 цагийн кинонд орсон бол 11 хагасын үед л орж ирнэ дээ. Үргэлж тэгэхгүй л дээ. Хаяа нэг сонин кино гарвал л энэ аргыг хэрэглэнэ. Түүнээс албан хаагч хүн хамаагүй тэгж явж болохгүй. Тэгээд нэг орой, нөгөө Галсан дарга шат руу бууж явна.

-Хүүе, хүүе! Би чамд хэлэх гээд мартсан байна. Өнөөдөр дарга нарын зөвлөлгөөн болоод, чиний асуудлыг авч хэлэлцээд, чамайг явахыг зөвшөөрсөн шүү! гэлээ. Би ч бөөн баяр хөөр боллоо. Тэгээд л би Зөвлөлтөд сургуульд явсан байхгүй юу. Бүр хожуу юм шүү дээ.

7 Москвагийн амьдрал

К.Ю.: Москвад явсан уу?

П.Д.: Москвад явсан. "Москвагийн эдийн засгийн дээд сургууль" буюу "Московский государственный экономический институт" гэдэгт явсан юм. Тэр үед манай сургууль чинь бие даагаад тусдаа байсан юм. Сүүлд Плехановын нэрэмжит улс ардын аж ахуйн дээд сургуультай нийлсэн. Манай сургууль бүр эхлээд энэ Плехановын нэрэмжит улс ардын аж ахуйн дээд сургуулиас салсан юм гэнэ билээ. 1932 онд гэлүү дээ, салаад, сүүлд нь жаран хэдэн онд эргэж нийлээд Плехановын нэрэмжит улс ардын аж ахуйн дээд сургууль болоод, одоо "Плехановын нэрэмжит улс ардын аж ахуйн академи" гэдэг нэртэй болсон доо. Тэнд эхлээд очив оо. Тэгэхэд их сайхан байлаа л даа. Академич, багш нар орж ирээд л юм яриад байна. Надад ойлгох юм нэг ч байхгүй. Орос хэлийг ойлгодоггүй. Би лекцэнд суугаад ээж, аавдаа захиа бичээд байна. Одоо миний тэр дэвтрүүд байж л байгаа. Багшийг амаа хөдөлгөж үг хэлэх болгонд нь цэг тавиад байсан. Холбооны морз гээд нэг юм байдаг шүү дээ. Миний цэг яг л тийм юм байсан даа. Манайхан чинь морзоор бичээд байгаа юмуу? гэнэ. Үгийн утгаар цэг тавиад байдаг гэж байгаа юм. Хааяа нэг "революция" буюу "хувьсгал" гэдэг үг гарвал бичнэ. Страна, государство зэрэг үг гарвал бас бичнэ. Тэгээд л бусдыг нь барагцаалаад цэг тавиад байна даа. Би тэр дэвтрүүдээ одоо болтол хадгалчихсан байгаа. Би хүүхдүүддээ үзүүлдэг юм.

Тэгж байтал хагас жил ойртлоо. Шалгалт эхлэх боллоо. Надад мэдэх юм байхгүй. Өнөө бага, дунд сургуульд байдаг шиг шаардаад байхгүй шүү дээ. Сууна уу, байна уу хамаа байхгүй байсан чинь яг шалгалт өгөх болохоор юу ч байдаггүй. Урам гутаад, гэрээ ч их санаж байна. Аав, ээжээ ч санаж байна. Москва гэдэг чинь агаар муу. Нар нэг ч үзэгдэхгүй, ерөөсөө нар байхгүй юм шиг өдрийн 3 цагт л харанхуй болчихно. Хааяа нэг лекцэн дээр сууж байхад нар гарахаар л аав ороод ирж байгаа юм шиг санагдана.

-Ингэж хүний нутагт, үйл тамаа идэж, сурсан юм байхгүй байж байхаа болъё! гэж бодоод буцахаар шийдвээ. Тэр сургуульд Ренчинпэлжээ гуай бид хоёр хамт очсон юм л даа. Тэгээд түүнд:

-Би ер нь энэ улсын мөнгө бага үрсэн дээрээ нутаг буцъя! гэж хэллээ.

Тэр:

-Үгүй, чи яаж байгаа юм бэ? гэж байна.

-Надад юм сурах шинж алга. Их хэцүү байна! гэлээ.

Манай төлөвлөгөөний комиссын дарга Д.Майдар гэдэг хүн байсан юм. Тэр үед Д.Майдар дарга Москвад очсон байлаа.

Д.Майдар гуай дээр намайг дагуулж очоод, миний асуудлыг танилцуулж

өгөөч! гэж Ренчинпэлжээ гуайгаас гуйлаа. Тэр зөвшөөрч байна.
И.Л.: Нөгөө Улс Төрийн Товчоонд байсан Д.Майдар гуай мөн үү?
П.Д.: Тийм. Д.Майдар гуай чинь Сайд нарын зөвлөлийн орлогч дарга бөгөөд Улсын Төлөвлөгөөний комиссын жинхэнэ дарга байсан юм. Ренчинпэлжээ гуай хуучин хамт ажиллаж байсан дарга дээрээ намайг дагуулаад очлоо доо. Биднийг очиход Д.Майдар дарга дөнгөж л босч байна. Тэгээд л гурвуулаа цай уугаад л ярилаа даа. Би ч яахав. Тэр хоёр дарга хуучин нэг доор ажиллаж байсан болохоор бөөн юм л ярилаа даа. Цаг хиртэй ярилаа. Тэгээд:
-Даргаа. Одоо надад ярих юм алга. Энэ хүүхдийн тухай нэг юм ярих гэсэн юм. Энэ хүүхэд манай төлөвлөгөөний комиссын нэр дээр надтай хамт сургуульд ирсэн юм. Одоо нутаг буцна гээд байна. Улсын мөнгө бага үрсэн дээрээ нутаг буцаад ня-богоо хийнэ гээд байна гэж Ренчинпэлжээ гуай хэллээ.
Гэтэл Д.Майдар дарга:
-Чи шалгалтаа өгөөгүй, хагас жил ч болоогүй байж шантардаг муу эр байна. Нэгэнт л зорьж ирснээс хойш сурна шүү, нөхөр минь. Буцна гэж ярихгүй гээд л зад загналаа.

Тэгээд л яахав дээ. Ямар ч арга байхгүй. Тэгэхэд манай сургуулийн аспирантуурт Д.Цэнд гуай сурч байлаа. Цэнд гэдэг хүн байсныг та нар дуулсан байх. Цэнд гуай сургуульдаа их нэр хүндтэй байсан. Монгол хүн ямар их ухаантай, авъяастай юм бэ? гэдгийг Цэнд гуай үзүүлж байлаа. Тэр орос оюутнуудад хичээл заадаг байсан. Орос хэл гэдгийг чинь гайхамшигтай мэднэ. Багш нарын дунд онолын маргаан гарвал Цэндийг дуудаж асуудаг байлаа. Цэндийн саналаар маргаан шийдэгддэг байсан юм. Сургуульдаа ийм нэртэй хүн байсан юм. Тэгээд би Цэнд гуайгаас гуйлаа.
-Цэнд гуай, намайг бэлтгэл ангид оруулж өгөөч. Би ерөөсөө сурч дийлэхгүй байна. Тэр дээд тоо, Орос хэлийг ойлгож байгаа юм надад алга! гэлээ.

Тэр үед Хятадууд манай сургуульд очиж байсан юм. Тэд нар бэлтгэл хийдэг байсан юм. Санхүүгийн сургууль шиг дахиад бэлтгэл ангид орно гэсэн юм л даа. Надтай хамт очсон Ренчинпэлжээ гуай бэлтгэлд орохгүй гэдэг байлаа. Тэр 38 настай сургуульд очсон юм.
-Би дахин нэг жил суугаад яах юм бэ? Чадсан ч, чадаагүй ч эндээ сууна! гэдэг байсан юм.
Цэнд гуай :
-Чи залуу хүн, нэг жил Москвад суухад хэл чинь сайжирна! Ренчинпэлжээ бол өөр хэрэг. Чи бол залуу хүүхэд. Би чамайг дагуулаад захирал дээр оръё! гэж байна. Манай сургуулийн захирал профессор Черпанов гэдэг

хүн байсан. Цэнд гуай их сайн танил бололтой юм билээ. Цэнд гуай намайг дагуулаад очсон чинь захирал дор нь хүлээгээд авлаа. Цэнд гуай чинь сургуульдаа тийм нэр хүндтэй хүн байлаа. Тэгээд тэр хоёр шувт Оросоор яриад байлаа. Би юу ярьж байгааг нь ойлгосонгүй. Их удаан ярьсан даа. Тэр үед Сталины "Эдийн засгийн шинжлэх ухааны зарим асуудлууд" гэдэг зохиол гараад байсан юм. Зөвлөлт оронд энэ талаар их хэмжээний санал шүүмжлэл явагдаж байлаа. Тэд нар тэр зохиолын тухай яриад байгаа бололтой байсан. "Сталин" гээд л яриад байх юм. 2 цаг шахуу ярилаа. Энэ хооронд миний тухай юу ч ярисангүй. Тэгээд яриа нь дуусах гэж байгаа бололтой босоцгоолоо.

-Баяртай! гэж байгаа бололтой. Тэгсэн Цэнд гуай:

-Захирлаа, би нэг юм мартсан байна. Энэ хүүхдийн тухай нэг юм яръя! Энэ хүүхэд манай монголоос энэ жил ирээд нэгдүгээр курст сурч байгаа юм. Орос хэл мэдэхгүй, ерөөсөө боловсролоор тааруу. Хятадуудтай хамт бэлтгэл ангид оруулвал ямар вэ? гэлээ.

-Проблем нет! Оруулчих! Маргааш би тушаал гаргачихъя! гэж захирал хэллээ. Ингэж би 14 хятадтай хамт бэлтгэл ангид сурахаар болсон юм. Бас нэг Солонгос хүн ирээд 16-лаа болсон. Хятадууд Орос хэл, эдийн засгийн географи, СССР-ийн улс ардын аж ахуйн түүх гэсэн 3 хичээлийг үзнэ. Миний сэтгэл ч сайхан онгойлоо. Орос хэлийг ч ёстой шаргуу үзлээ дээ.

-Чи Орос хэлийг сурахад ойлгосон, ойлгоогүй хамаагүй ном л уншаад бай. Олон үг цээжлэх гээд яарах хэрэггүй. Уран зохиолын ном уйдатлаа унш! гэж Цэнд гуай зөвлөлөө.

Би ёстой уран зохиолын номыг чинь уншаад л байлаа. Анна Каренина-г авч ирээд уншаад байлаа. Эхлээд ерөөсөө ойлгохгүй байлаа. Нэг уншина, хоёр уншина, гурав уншаад ирэхээр өнөө үгнүүд чинь хонь шиг болоод ирж байгаа юм. Хонийг Монголчууд ялгахдаа сайн шүү дээ. Би бол манай хонь айлын хоньтой нийлсэн байхад шууд мэднэ. Монголчуудын төрөлхийн нэг тийм онцлог байдаг юм. Одоо ч манай хөдөөнийхөн тийм шүү дээ. 1000 хонь нийлсэн байхад эзэн нь ирээд л салгаад авна шүү дээ. Ямар ч асуудал байхгүй. Энэ бас хүний удамшлын гэх юмуу онцлог л доо. Цэнд гуайн хэлснээр ном уншаад л байлаа.

Бэлтгэлд ороод би чинь чөлөөтэй боллоо. Олон хичээл орохгүй. Аяндаа үгнүүд чинь танил болоод ирлээ. Эхлээд би дандаа словарьтай уншдаг байлаа. Бүхэл өдөр суухад тал хуудас л явсан байна. Тэгэхээр нь болиод словарийг хаяад метронд явж байсан ч, трамбайд, автобусанд явж байсан ч ном уншаад байлаа. Хүн харахад энэ Орос хэлтэй сүрхий нөхөр юм даа гэж бодогдохоор л доо. Нэг номыг 2-3 дахин уншаад ирэхээр үгнүүд нь танил болчихно. Жишээ нь, тантай уулзаагүй байхад танихгүй,

2-3 дахин уулзахад танидаг болно шүү дээ. Дараа нь нэг уулзаад та чинь хэн билээ гээд нэрээ хэлэхээр бүр хуучны танил болоод ирдэг. Түүн шиг л байгаа юм даа. Тэгээд яахав, Орос хэлийг жаахан гадарлаж аваад бэлтгэл ангиа онц төгссөн дөө. Бэлтгэл ангидаа нэг жил, үндсэн курсдээ таван жил, ингээд Москвад 6 жил суулаа. Ингэж явсан түүхтэй.

Миний хувь заяа их сонин шүү. Хөдөөнөөс орж ирээд, хойшоо яваад л сонин байгаа юм шүү. Анх намайг дэмжсэн улсууддаа би их баярладаг юмаа. Тэр Цэрэн багш болон бусад багш нар бэлтгэл ангид авахгүй гэсэн бол надад буцахаас өөр арга байхгүй л дээ. Санхүүгийн сургуулийн 70 жилийн ой 1995 онд болсон юм. Би тэр ойд оролцсон.

-Олон жил сайд хийлээ, улс орны удирдлагад ажиллаа. Энэ бол миний сайных биш. Энэ бол багш нарын маань сайных юм шүү! гэж би хэллээ.

Тэр ойн үеэр сургуулийнхаа багш нарыг танилцуулж байгаа юм.Тэр багш нар нь бид сурч байсан үе шиг залуучууд байсан. Санхүүгийн сургуульд би 17-той орсон, нэг нөхөр 23 настай орсон байгаа юм. Түүнийг Банзрагч гэдэг байлаа. Манай байгалийн багш 23 настай байсан. Их ширүүн зантай биднийг загнадаг багш байсан. Тэгэхээр нөгөө Банзрагч чинь өмөөрөөд :

-Чи битгий хүүхэд загнаад бай! Хөдөөнөөс ирсэн юм наадах чинь! Юм мэдэхгүй л байгаа биз гэнэ. Тэгэхээр багш уурлаад:

-Чи бид хоёр чацуу байх ямар хамаа байна. Чи гар! гээд хөөнө.

-Би гарахгүй. Би юм сурах гэж ирсэн! гээд Банзрагч гарахгүй. Бид чинь тэгж сурч байлаа шүү дээ.

-Монголын хүүдүүдийн төлөө, хүний төлөө та нар их анхаарал тавьж байсан шүү дээ! гэж ойн үеэр багш нартаа би хэллээ.

Ингэж би хоёр сургууль төгслөө. Энд төгсөөд, хойно очиж төгсөөд ирлээ. Төлөвлөгөөний комиссын нэр дээр явсан юм чинь тэндээ л ажиллана шүү дээ. Ирээд төлөвлөгөөний комисст мэргэжилтэн боллоо.

8 Монгол улсын Аж Үйлдвэрийн Яамны сайд

К.Ю.: Хэдэн онд ирсэн бэ?

П.Д.: 1952 онд яваад 1958 онд ирсэн. Мэргэжилтэн нэг жил орчим хийлээ. 1959 оноос төлөвлөгөөний комиссын аж үйлдвэрийн хэлтсийн дарга болж дэвшээд, 1960 оноос Аж Үйлдвэрийн Яамны сайдаар томилогдлоо. Манай улс чинь аж үйлдвэр хариуцсан ганцхан яамтай байлаа шүү дээ. Бүхэл бүтэн салбарыг хариуцсан ганц л яам байсан юм. Аж үйлдвэрийн яамны сайдыг 1960-68 онд хийсэн. Уул, уурхай, цахилгаан, нүүрс, түлш, хөнгөн, хүнсний бүх үйлдвэр нийлээд нэг л яамтай байсан.

К.Ю.: Та 1960 онд сайд болж байхдаа хэдэн настай байсан бэ?

П.Д.: 29 настай байсан. Намайг сайд болж байхад та 3 настай байсан байна шүү дээ. Яам томроод олон үйлдвэртэй болоод ирэхээр хүнд

үйлдвэрийг тусад нь салгасан юм. Тэгээд Хөнгөн Хүнсний Үйлдвэрийн Яам байгуулсан юм. 1968-79 он хүртэл Хөнгөн Хүнсний Үйлдвэрийн Яамны сайд байлаа. 1979-90 оны 3 сар хүртэл МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга байлаа. Ингээд миний амьдралын 34 жил нь аж үйлдвэрийн хөгжилтэй холбоотой байгаа юм. 2 жил төлөвлөгөөний комисст, 2 жил НТХ-ны санхүүгийн хэлтэст үлдсэн 30 жил нь аж үйлдвэртэй холбоотой юм. Иймээс манай улсын аж үйлдвэрийн хөгжилт муу ч байсан, сайн ч байсан миний л нэртэй холбоотой.

К.Ю.: Энэ үе бол Монголд аж үйлдвэр хамгийн эрчимтэй хөгжсөн үе юм. Өөрөөр хэлбэл Монголын аж үйлдвэр тантай хамт өсөж торнижээ.

П.Д.: Надад бол тийм завшаантай сайхан үе таарсан байхгүй юу. 1960 оноос хойш гучин жилд Монголын аж үйлдвэр дээд зэргээр хөгжсөн. Энэ бол манай нам засгаас авсан арга хэмжээний үр дүн юм. Хөгжлийн тийм үед нь би сайд, дарга нь байх завшаан тохиолдсон юм.

К.Ю.: Та авгайтайгаа хэзээ танилцсан бэ?

П.Д.: Сайд болсон хойноо, 1961 онд би гэрлэсэн дээ. Ганцаараа байхдаа сайд болсон. Тэгэхэд ээж, ах хөдөө байсан. Ах, бид хоёр авгай аваагүй байсан. Би чинь үндсэндээ хойно очиж л анх байшинд амьдарч үзсэн юм шүү дээ. Түүнээс өмнө энд байхдаа дандаа гэрт амьдарч байсан. Москвад төгсөж ирээд, манай нутгийн төрлийн айлд байсан. Тэгж байтал Төлөвлөгөөний комисс байшин барилаа. Одоо 5-р сургуулийн хажууд нэг байр бий дээ. Хэлтсийн дарга болсон болохоор намайг харж үзсэн байх. Тэр байшинд 2 өрөө байр өгсөн юм. Төлөвлөгөөний комисс байшин өгч анх удаа өөрийн гэсэн байртай боллоо. Тэр үед ах маань Төв аймагт Намын Хорооны дарга болсон байлаа. Ээж, дүү хоёр ахтай хамт байсан юм. Ээжийгээ би дуудаад л аваад ирнэ. Тэгснээ ах ирээд, над дээр хэд хоноод л ээжийг аваад явна. Хорин хэдтэй залуу сайд болчихно гэдэг хэцүү л дээ. Том албан тушаал юм. Гэтэл авгай аваагүй байдаг. Ажил гэдэг чинь маш их. Би чинь үйлдвэрт ажиллаж байгаагүй хүн шүү дээ. Маш хэцүү, тэр ажлыг нь мэдэж, сайжруулах ёстой байсан. Манай яам чинь их том яам байлаа. Би чинь өглөөнөөс шөнө хүртэл сууна. Би сүүлд тэр яаманд ажиллаж байсан хүмүүсийг их өрөвдөж билээ. Би чинь сайд хүн, нам засгаас их хүндэтгэл хүлээлгэлээ шүү дээ. Тэр итгэлийг нь хариулах, өгсөн үүрэг даалгаврыг нь биелүүлэх хэрэгтэй. Тиймээс их суух шаардлагатай байсан. Хариуцсан ажилтайгаа холбоотой их зүйлийг мэдэж авах ёстой байлаа. Авгайгүй хүн чинь орой болохоор хоолтой, хоолгүй л байна. Заримдаа айлын хоол буудна. Ээж байгаа бол гэртээ ирээд хоол иднэ. Ээж байхгүй бол гуанзаар явна даа. Сайд хүн тэр болгон гуанзаар яваад байх бас зохимжгүй байсан. Засгийн газрын гуанз бол өдөр л хоол өгөхөөс орой хоол өгдөггүй байсан. Орой сайд хүн ресторанд

суугаад байх бас хэцүү. Тэр үед "Алтай" гэдэг ганцхан ресторантай байсан. Гуанз, Ресторанаар сайд хүн үргэлж яваад байх эвгүй л дээ. Тэгээд л ажил дээрээ суучихна даа. Шөнийн 1 цаг, 2 цагаас нааш гэртээ харихгүй.

Би чинь яаманд ирсэн шинэ сайд байлаа. Тэндхийн хүмүүсийг тэр бүр сайн танихгүй. Би чинь 4 орлогч сайдтай байсан. Тэд чинь миний аав шиг л настай хүмүүс байсан даа. Би тэднийг над шиг ажлаа хийгээд орой суу гэж хэлэхгүй. Нэгэнт сайд сууж байгаа учраас 4 орлогч сайд нь сууна, 4 орлогч суухаар 10-аад хэлтсийн дарга сууна. Хэлтсийн дарга нар суухаар ажилтнууд нь сууна. Тэгсээр тэр яам бүхэлдээ суудаг байлаа. Үүнийг сүүлд тэдэнтэй танил болоод ирсэн үедээ ярьж байсан юм.

-Нэг авгай аваагүй хүүхэд ирсэн биш, ёстой баллуулж байна! Гэртээ ч харихаа байлаа, авгай хүүхдээ ч үзэхээ байлаа! гэж ярьдаг байсан гэнэ.

К.Ю.: Аав чинь тэгэхэд хөдөө байсан уу?

П.Д.: Аав намайг сургуульд байхад нас барсан юм. Ээж хотод байж байгаад саяхан 1986 онд нас барсан.

9 Аж үйлдвэрийн комбинат

К.Ю.: Монголд анхны баригдсан үйлдвэр ямар үйлдвэр байсан бэ?

П.Д.: Манай хамгийн анхны үйлдвэр бол Аж үйлдвэрийн комбинат юм. Монголд ер нь үйлдвэр гэж юм байгаагүй, нойлоос эхэлсэн. Яахав дээ, ээмэг бөгж хийдэг ч юмуу, хувийн жижиг аж ахуйнууд байсан. Жижиг хэвлэх үйлдвэр, Налайхад нэг уурхай зэрэг жаахан, жаахан үйлдвэрийн газрууд байсан боловч одоогийн бидний ойлгож байгаа шиг фабрик, завод гэж байгаагүй. Улаанбаатар хот гэхэд л 60 квт-ын л хүчин чадалтай цахилгаан станцтай байсан. 60 квт-ыг бол одоо манай хөдөөний малчид ажиллуулж байна шүү дээ. 60 квт-ын нэг л мотор гэсэн үг юм. Японччууд одоо манайд нэг мотор худалдаад байна шүү дээ. Түүнтэй л адилхан юм. 1924 оны анхны цахилгаан станц ийм байж. Тэгээд Аж үйлдвэрийн комбинат гэдгийг байгуулжээ.

К.Ю.: Үүнийг хэзээ барьсан бэ?

П.Д.: 1928-29 оны үед барилга нь эхлэж, 1934 оны 3 сарын 24-нд ашиглалтанд орсон юм. Энэ бол манай улсын аж үйлдвэрийн суурь болж байсан бөгөөд, тэр комбинат дотроо 4 фабрик, заводтой байлаа. Эсгий, савхин гутал, цэмбэ, булигаар хийдэг байжээ. Булигаараар манайхан Монгол гутал, гөлөм хийдэг шүү дээ. Үүнээс гадна цахилгаан станцыг нэмж барьсан юм. Тэр цахилгаан станц нь нөгөө 60 квт-ын оронд 1500 квт болж сүрхий юм болжээ. Үүнийг байгуулаад 1934 онд ашиглалтанд оруулсан гэдэг. Комбинатаа барьсан газар нь онгоцны буудлаас нааш ирэхэд байдаг район юм шүү дээ.

Тэр үед Улаанбаатар энэ хоёрын хооронд хоосон тал газар байсан

юм. Тэр үеийн зургуудыг түүнийг анх байгуулж байсан хүн 1971 онд надад өгсөн юм. Оросын Трестийн орлогч байсан хүн. Манай улсын архивт байхгүй зурагнууд тэнд байсан. 1930 онд комбинатын суурь тавих ёслол болжээ. Зурагнуудыг тэр ёслолын үеэс эхлээд авчээ. Тэгтэл тэр суурь тавих ёслолын үеэр анх удаа үйлдвэр байгуулж байгааг үзэх гэзд Улаанбаатарынхан цугларчээ. Хүмүүс тэр суурь тавихад оролцохыгоо нэр төрийн хэрэг гэж үзэж байж. Улсдаа үйлдвэр байгуулах, суурь фундаментийг ухах ажилд лам, цэрэг гээд янз бүрийн хүмүүс оролцож байжээ.

Монголын аж үйлдвэр яаж хөгжсөнийг яриад байвал хэдэн өдөр ярина. Тиймээс хэдэн тоо хэлчих үү? Тоо сонирхдог уу?

К.Ю.: Сонирхоно шүү.

П.Д.: Ингээд 1934 онд Аж үйлдвэрийн комбинат ашиглалтанд оржээ. Тэгээд дараа нь дайн боллоо. Дайны үед хөгжих юм байхгүй шүү дээ. Харин нэг жижигхэн мах комбинат байгуулсан юм. Дайны үед улс даяар хөдөөд сүү, тосны тасаг байгуулсан. 40-өөд онд анх удаа айлуудыг хамтад нь буулгаад, сүүг нь аваад, гар машинаар машиндаад, цөцгий гаргаад, түүнийгээ машиндаад, цөцгийн тос хийдэг боллоо. Одоо түүнийг "масло" гэж нэрлэж байна. Энэ чинь тэр үеэс эхэлж хөгжсөн юм шүү дээ. 1946 онд 5500 тн цөцгийн тос хийж байлаа. Тэр үед Монголчууд талх бага иддэг, цөцгийн тос бараг хэрэглэдэггүй байсан учраас 5000 тн-ыг экспортонд гаргаж байжээ.

Одоо цөцгийн тос хийдэг газар бүгд устсан шүү дээ. Энэ бүгд устаад, мал нь хусран болоод, үнээгээ саахгүй явуулаад байна шүү дээ. Яагаад бид өнөөдөр Герман, Дани, Оросын ургамлын тос холисон тос идэж байна вэ? Түүх мэдэхгүй хүн ийм юм байсныг мэдэхгүй шүү дээ. Тэр үед цөцгийн тос 1 кг нь 12 төгрөгний үнэтэй байлаа.

10 Дайны дараах үеийн аж үйлдвэрийн хөгжилт

Ингээд дайн дууслаа. 1948 онд манай улс анхдугаар 5 жилийн төлөвлөгөө гэдгийг баталж, үүнээс хойш олон жилийн төлөвлөгөөтэйгээр хөгжиж ирсэн юм. Манай аж үйлдвэр хөгжсөн гол үе бол миний сайд байсан үе юм шүү дээ. Би бол өөрийгөө азтай хүн гэж боддог. Би үйлдвэрийн инженер хүн биш, эдийн засагч хүн шүү дээ. Тийм үед намайг үйлдвэрийн салбар дээр тавьсан. Би чинь тэр үед туршлагагүй байлаа. Манайд сүүлийн үед гарч ирсэн ардчилагчид бид их залуу сайдууд, бид нар их сайн байна! гээд байгаа юм. Би тэгэхэд тэр сайн ахмадуудын үед 29 настай залуу сайд байлаа. Нам, ард түмэн надад итгэл хүлээлгэсэн, би тэр итгэл найдварыг биелүүлэхийн төлөө бүх зүйлээ зориулсан. Энэ бол цаг хугацааны хувьд аж үйлдвэрийн хөгжлийн үетэй яг таарсан юм л даа.

Энэ үед нам засгаас, ялангуяа 1966 онд хуралдсан намын 15-р их хурлаас Монгол улсыг аж үйлдвэр, хөдөө аж ахуйн орон болгоно гэсэн зорилтыг дэвшүүлсэн байлаа. 1966 оны үеэс манай аж үйлдвэрийн хөгжилт их хүчээ авсан юм. Тэр үед олон зорилтууд тавигдаж байсан. Юуны өмнө МАА-н гаралтай түүхий эдийг болвсруулах, эрдэс баялгаа ашиглах чиглэлийг хүчтэй тавьж эхэлсэн. Намын их хурал хуралдаад дараагийн таван жилийн төлөвлөгөөний удирдамжийг баталдаг байсан. Яаж, юунд хүрэх вэ гэдэг удирдамж гарна. Тэр удирдамжийн үндсэн дээр таван жилийн төлөвлөгөө хийгээд, тэр төлөвлөгөөг Ардын Их Хурлын чуулганаар баталдаг байлаа. Ингээд тэр төлөвлөгөө хууль ёсны болдог, тэр төлөвлөгөөний дагуу ажилладаг байлаа.

Би үйлдвэрийн өсөлтийг хэдэн тоогоор хэлээд өгье. Манай улсын аж үйлдвэр 1940 онд 86 оны үнээр ердөө 116 сая төгрөгийн бүтээгдэхүүн хийдэг байж. Энэ үзүүлэлт 1989 онд 9 млрд 181 сая төгрөгт хүрчээ. Ямар байна даа. Аж үйлдвэрийн өсөлтийн гол үзүүлэлт чинь бүтээгдэхүүн шүү дээ. Ингээд өсөлтийг нь харьцуулж үзэхээр 79 дахин өссөн байгаа юм. 1940 оныг 100% гэж үзвэл 1960 оноос хойш 79 дахин өссөн байна шүү дээ. Энэ чинь маш сайн үзүүлэлт байгаа биз дээ. 1960 оноос хойш маш том өсөлт байсан нь харагдаж байгаа юм. 1960 онд 715 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол 1989 онд 10 млрд болсон байгаа юм. Нийгмийн нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувийн жин гэж байна шүү дээ. Миний сайд болж байх үед нийгмийн нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн эзлэх хувийн жин 20% байжээ. Тэгвэл 1989 онд бараг 50% буюу 48 хувьтай болсон байна. Энэ бол маш их ахиж байгаагийн илрэл юм. Үндэсний орлого гэдэг чухал үзүүлэт байдаг. 60 онд намайг сайд болж байхад үндэсний орлогод аж үйлдвэр 9.6%-ийг эзлэж байсан. 89 онд 34.1% болсон байлаа. Энэ чинь шийдвэрлэх ач холбогдолтой болсон байна гэсэн үг шүү дээ. Хөрөнгө оруулалт гэхэд 60 онд 540 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай байсан. Тэгэхэд 89 онд 16 млрд 500 сая төгрөгийн хөрөнгө оруулалтай болсон. УААА-д оруулж байсан бүх хөрөнгө оруулалтын 50%-ийг аж үйлдвэрийн салбарт оруулж байсан юм. Өөрөөр хэлбэл аж үйлдвэрийг хөгжүүлэхгүйгээр дан ганц МАА-гаар явж болохгүй гэдэг нь тодорхой болсон. Малаас мах авахаас өөр юм байхгүй гэж шүүмжилж байсан. Энэ махыг чинь боловсруулах хэрэгтэй, бас арьс ширийг нь ч боловсруулах хэрэгтэй. Энэ үед ямар үйлдвэрүүд байгуулагдсан бэ? жишээ хэлье л дээ.

Хуучин арьсыг түүхийгээр нь гаргадаг байлаа. Арьсыг боловсруулаад тухайлбал, үхрийн ширээр гутлын ул хийдэг болсон. Хонины арьс 5 сая гардаг байсан. Хонины арьсаар юу хийх вэ? Савхин дээл, цамц хийнэ. Ямааны арьсаар гол нь савхин гутал хийдэг болсон. Ингээд ноос, арьс

ширээ бүгдийг нь боловсруулдаг болсон юм. Хуучин чинь Монгол ноосоо бараг угаалгүй гаргадаг байлаа. Гэтэл бид ноосоо угаагаад, боловсруулаад, дотооддоо хамгийн хэрэгтэй эсгий хийдэг боллоо. Гэрийн эсгий, эсгий гутал хийнэ. Сүүлдээ ноосон даавуу, бүр хивс хийдэг боллоо. Ноолууpаа болвсруулаад бүтээгдэхүүн хийдэг боллоо. Ингээд харахад ахиад л цаашаа яваад л байгаа юм. Намайг сайд болж байхад аж үйлдвэрт 50 мянган хүн ажиллаж байсан. 89 онд 2 дахин өсөөд 120 мянган хүнтэй болсон. Энэ салбарт ямар өсөлт байсныг харж болно. Тиймээс нэгдсэн үзүүлэлтээр нь авч үзье.

Энд эдийн засагч нарын боловсруулсан 2 тоог харъя. 60 онд 106 сая квт цахилгаан эрчим хүч ашиглаж, боловсруулж байлаа. Тэгвэл 90 онд 3 млрд 347 сая квт болсон байна. Намайг сайд болж байхад манайх ганцхан цахилгаан станцтай байсан. Одоо бол өчнөөн олон станцтай болсон байна шүү дээ. 1960 онд 600-аад мянган тн нүүрс гаргадаг байсан бол 1990 онд 7 сая 100 мянган тн-ыг гаргадаг болсон. Зэсийн баяжмал хуучин хийдэггүй байсан бол 1970 хэдэн оноос 300-аад мянган тн зэсийн баяжмал хийж эхэлсэн. Молибдены, жоншны баяжмал хуучин байдаггүй байсан бол үүнийг бас хийдэг болсон. Мөн 440 гаруй мянган тн цемент хийдэг болсон.

МАА-н орон мөртлөө бид чинь хониныхоо ноосыг сайн ашиглаж чадахгүй байлаа. Монгол хонины ноос даавуунд тохирдоггүй, бид судлаад шинжлээд үзтэл хивс хийхэд хамгийн тохиромжтой байсан. Тэгээд хивсний үйлдвэр байгуулсан даа. 1960-аад онд гар хивс хийдэг байлаа. Намайг сайд болж байхад үйлдвэр хоршоололд гар хивсний нэг л цех байсан юм. Жилд 100 хавтгай дөрвөлжин метр хивс хийдэг байлаа. Тэгээд 2 сая х.д.м хивс хийдэг болсон байлаа. Ноосон даавуу гэж хуучин хийдэггүй байсан. Бид ноосон даавууны үйлдвэр барилаа. Анх үйлдвэр комбинат баригдахад цэмбэ хийдэг болсон. 1990-ээд онд сая гаруй метр ноосон даавуу хийж байлаа. Хуучин сүлжмэл эдлэл хийдэггүй байсан. 1960 он гэхэд 137 мянган ширхэг сүлжмэл эдлэл хийж байсан бол 1990 онд 4 сая 400 мянган ширхгийг хийдэг болсон. Энэ чинь өсөлт биз дээ.

Одоо бид дандаа гадны пальто өмсөж байна шүү дээ. Солонгос, Герман гээд янз бүрийн л пальто ирэх болжээ. Монгол дээл гэдэг чинь хотын нөхцөлд тохиромж муутай эд шүү дээ. Монгол дээл гэдэг чинь нүүдэлчин хүмүүсийн хувцас болохоос хотын хүмүүсийн хувцас биш юм. Хот чинь халуун учраас үстэй дээлтэй сууж ажиллаж болдоггүй юм. Бид пальто хийдэг боллоо. 1960 он гэхэд 16000 ширхэг пальто хийдэг байсан бол 1990 онд 64000-ыг хийдэг боллоо. Монгол хүн костюм өмсдөг боллоо. 1960 онд 32000 ш костюм хийж байсан бол 1990 онд 140000 ш костюм хийдэг боллоо. Одоо энэ бүгд байхгүй болсон. 60 онд 290000 м гэрийн эсгий хийж байсан бол 90 онд 700000м болсон. Энэ мэтээр өсөлт байсан

юм. 90 оны байдлаар бид чинь 4 сая 800000 хос гутал хийж байлаа. Одоо тэр үйлдвэр маань түрээсийн байр, баар болчихоод байна, ямар вэ?
К.Ю.: Энэ бичсэнийг копи хийж болох уу?
П.Д.: Ийм муухай бичсэн юм та нарт хэрэг болох уу?
К.Ю.: Болно, болно.
П.Д.: Энэ мэтээр өсөлт гарсан юм. Энэ тоог танд ямар зорилгоор хэлж байгаа юм бэ гэхээр олон үйлдвэр байгуулж байсныг үзүүлэх гэсэн юм. Байгуулсан үйлдвэрийн нэр хэлээд байхаар цаг хэмнэх зорилгоор ийм эдийн засгийн үзүүлэлтүүдийг хэлж, Монголын аж үйлдвэрийн хөгжлийг харуулах гэсэн юм.
К.Ю.: Одоо тоогоор зааж өгсөн юмыг газрын зураг дээр зааж өгөх үү
П.Д.: За тэгье.

11 Хүнд үйлдвэрийн болон цахилгаан эрчим хүчний салбарын хөгжилт

К.Ю.: Та сайд болсны дараагаар анх ямар үйлдвэр байгуулагдсан бэ?
П.Д.: Маш олон үйлдвэр байна шүү дээ. Миний сайд байхад арьс шир, ноос, хүнсний гол үйлдвэрүүд байгуулагдсан юм шүү дээ. Тоочих уу?
К.Ю.: Анх ямар тусламжаар, Орос хүн юмуу, Чех хүн ирээд ямар үйлдвэр байгуулсан бэ?
П.Д.: За тэгвэл би хүнд үйлдвэрээсээ эхлэе. Намайг сайд болж байхад Улаанбаатар ганц цахилгаан станцтай байсан юм л даа. Станцууд юу хангаж байсан бэ гэвэл 1-рт цахилгаанаар хангаж байсан. Үйлдвэрийн газруудыг уур, усаар, хотыг дулаанаар хангаж байлаа. Улаанбаатар томрох тусам ганц станц дийлэхгүй болсон. Намайг сайд болж байхад сонинд зарлал өгөөд хотын районуудын гэрлийг ээлжээр таслаж байсан. Залуу сайд хүнд бас нэр төр гэж байна шүү дээ. Ухаандаа одоо Намын төв хорооны бүгд хурал гэдэг чинь их том хурал шүү дээ. Тэр үед харанхуй болох, ИХ-ын чуулган болох үед харанхуй болох зэрэг нь маш хэцүү асуудал шүү дээ. Сайд шууд хариуцна шүү дээ. Би нэг жишээ хэлье. Хятадын төлөөлөгчдийг даргалаад Жоу-Эн-Лай ирлээ. Тэр нэг том хүлээн авалт хийлээ. Би сайд болоод авгай аваад, миний анхны хүү гарч байсан үе юм. Авгай тэр хүлээн авалтанд очих ёстой байсан боловч нялх хүүхэдтэй байсан болохоор чадаагүй юм. Ю.Цэдэнбал дарга гээд манай том дарга нар бүгд очлоо доо. Сайд нар цугларлаа. Тэгээд Жоу Эн Лай үг хэллээ. Дараа нь Ю.Цэрэнбал дарга үг хэллээ. Би бол хурал, хүлээн авалтанд ороход үйл явдлыг бараг анхаарахгүй. Гэрэл яах бол гэж л бодож сууна. Хятадын гадаад явдлын яамны сайд Чин-И гэдэг хүн байсан юм. Тэр хүн үг хэлж байтал харанхуй болчихлоо. Одоо яах ч арга байхгүй. Энэ мэт тохиолдол олон гарч байсан үе.

Гэтэл 1990 он гэхэд цахилгаан тасарна гэж байхгүй болсон байлаа.

Айлууд өвөл цонхоо дулаална гэж мэдэхгүй болсон. 90-ээд оноос хойш байрнууд хүйтэн болсон шүү дээ. Манай байрны хүмүүс:

-Таныг сайд байхад бид цонхоо ч наадаггүй байлаа шүү дээ. Одоо бүр хөлдөж үхэх нь ээ гэж хэлдэг юм. Энэ цахилгааныг хэн бий болгосон бэ? Улаанбаатарын 1,3,4-р станцуудыг ЗХУ (хуучин нэрээр) барилаа. 2-р станцыг барихад Хятад тусаллаа. Дархан, Эрдэнэтэд ЗХУ цахилгаан станц барьж өглөө. Анхны өндөр хүчдэлийн шугамыг Монголд тавилаа.

Уул, уурхайн салбарт Налайхын уурхай гэж Улаанбаатараас холгүй, 45км-т байгаа уурхайн өргөтгөлийг ЗХУ хийлээ. Бас Шарын голын нүүрсний уурхайг барихад ЗХУ тусаллаа. Энд хүнд үйлдвэрийн салбарт ЗХУ-ын тусламж голлож байлаа. Ингээд уул, уурхай, түлш эрчим хүчний хувьд Монгол улс хүнд байдлаас богино хугацаанд гарлаа.

К.Ю.: 1, 2-р цахилгаан станцуудыг хэзээ байгуулсан бэ?

П.Д.: 1-р цахилгаан станцыг 1934 онд аж үйлдвэрийн комбинатыг байгуулахад анх байгуулжээ. Тэр бол 1500 квт-ын хүчин чадалтай байсан. 1960 хэдэн онд 2-р станцыг Хятадууд барьсан юм. Тэр бол 24 мг вт-ын хүчин чадалтай станц юм. Энэ ч бас тийм том станц биш л дээ. 3-р станцыг 70 хэдэн онд, 4-р станцыг 80 хэдэн онд ашиглалтанд оруулсан юм. Аж үйлдвэрийг хөгжүүлэхэд, ер нь зөвхөн аж үйлдвэр ч биш Монгол улсын хүн амын амьдралын бусад хэрэгцээг хангахад эрчим хүч маш чухал үүрэгтэй. Энэ асуудлыг Монгол улс богино хугацаанд амжилттай шийдвэрлэж чадсан юм. Энэ асуудлыг ингэж шийдээд цаашдаа Эрдэнэтийн зэсийн орд газрыг ашиглах асуудал гарч ирсэн. Энэ асуудлыг ч бид амжилттай шийдсэн. 1978 онд Эрдэнэт үйлдвэрийг ашиглалтанд оруулсан.

Та Эрдэнэтэд очиж үзсэн үү?

К.Ю.: Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрээр ороогүй. Харин Эрдэнэт хотоор бол орж байсан.

П.Д.: Та тэр үйлдвэрээр орж үзээрэй. Уул уурхайн салбарт бид олон жил амжилттай ажиллаа. Монголын аймаг бүр нүүрсний уурхайтай боллоо. Уурхайн орд газар байхгүй бол өөр хэрэг л дээ. Нүүрсний ордтой аймаг бүр нүүрс олдворлох болсон. Аймаг бүр дизель цахилгаан станцтай болсон.Та хөдөө явж байгаа байх. Одоо Японы тусламжтайгаар сумдын цахилгаан станцыг шинэчилж байна. 90 оноос өмнө аймаг, сум бүр цахилгаан станцтай, гэрэл тасрана гэдгийг мэддэггүй болсон байлаа.Тэр үед гэрэл гэдэг бол зөвхөн нэг амьдралын асуудал биш улс төрийн том асуудал байлаа. Орой ном уншъя гэвэл яах юм бэ? Алийн болгон дэнгийн гэрэлд унших вэ? Би бол дэнгийн гэрэлд ном уншиж байсан. Та дэн гэж мэдэх үү? Одоогийн залуучуудыг дэн бариад сууж байна гээд бодчихдоо. Цахилгаан станцыг сум бүрт байгуулж өгсөн. Аймгаа хангаад сумаа

хангаад дууссан.

К.Ю.: Хөдөөд цахилгаантай болсон энэ ажил бас таны хийсэн ажил уу?

П.Д.: Тийм. Манай ажил л даа. Аж үйлдвэрийн яамны сайд байх үед хийсэн ажил шүү дээ. Монголд анх удаа өндөр хүчдэлийн шугам тавилаа. Сүүлд би Намын Төв хорооны аж үйлдвэр хариуцсан нарийн бичгийн дарга болсон юм. Би Монголын аж үйлдвэртэй холбоотой бүх асуудлыг хариуцаж байсан. Тэр үеийн манай нам чинь одоогийнх шиг сандал ширээний төлөө байлдаан хийхгүй шүү дээ. Ард түмний амьдрал ямар байгаагаар ажлаа дүгнүүлнэ. Та үүнийг ялгаж салгаж ойлгох хэрэгтэй. Одооны энэ намууд чинь парламентийн суудлын төлөө л гэсэн үг шүү дээ. Засгийн эрхийн төлөө гэдэг чинь юу гэсэн үг вэ? Энэ чинь "сандал ширээний төлөө" гэсэн үг шүү дээ. Тийм биз дээ. Би яг үнэнийг нь хэллээ.

Би гурван жилийн өмнө нэг таньдаг сайдтайгаа уулзлаа. Сайдын өрөө том ч юм. Дотор нь Сингапурын ч юм уу, Японы ч юм уу мебель авч ирээд тавьчихжээ. Сайд карманаасаа гар утас гаргаж ирээд ярьж байна. Машин гэдэг нь бас гадаадын машин юм. Японых уу, Германых уу, Солонгосынх уу, мэдэхгүй барууны л машин байсан. Би тэр сайдад:

-Та нар ч мөн сайхан юм. Кабинет гэдэг чинь том, мебель гэдэг чинь гадаадынх, машин гэдэг чинь барууных болжээ. Харин ажил гэдэг чинь напрас болж. Та нар ийм гоё машин унаад, ийм гоё өрөөнд суугаад ард түмний өмнө явахаас ичдэггүй юм уу? гэж хэлсэн. Бид бол муухан машин унаад үүргээ онц биелүүлж байсан. Бидний дутагдал байсан байж болно. Сайн машин унаагүй, сайхан кабинетад сууж чадаагүй, сайн мебель авч тавиагүй. Харин бид ард түмнийхээ төлөө хүч чадлаа зориулж байсан юм шүү. Бид бол Оросын л машин унадаг байсан. Гадаадын машин унадаггүй байсан. Бид бол мэдэхгүй дээ биш. Бид бол "Мерседес бенц", "Тоёота" гэдэг сайн машинууд байдгийг мэднэ. Бид түүнийг авч тансаглаж байснаас тэр хөрөнгийг ард түмэндээ зориулж байх ёстой гэж үздэг байсан. Одоо тэгэхэд ямар байна. Нэг албан газрын дарга гэхэд "Тоёота" унасан давхиж явна шүү дээ. Ард түмний амьдрал ийм байхад тэгж тансаглаж хэрэггүй шүү дээ. Тийм биз дээ. Би тэр сайдад:

-Таны машинд суухад, кабинетад ороход их сайхан юм. Та нар ард түмний урдуур явахаасаа ичмээр юм даа. Энэ сайдууд чинь хэрэг алга! гэж хэлсэн. Бидний үед сайдын үг гэдэг чинь маш хүчтэй байсан. Сайд л шийдсэн бол биелдэг байлаа. Одоо бол сайд үг хэлэхэд хэн ч тоохгүй шүү дээ. Харин "хуцваа" гэж хэлээд яваад өгнө дөө. Тийм биз дээ. Яг үнэнийг хэлэхэд ийм байна.

К.Ю.: Тийм байх аа.

12 Нэхмэлийн үйлдвэр

П.Д.: За хүнд аж үйлдвэрийн хувьд ийм байна. Хөнгөн аж үйлдвэр ямар байв? Ноос, арьс, шир голлоод ажиллах ёстой байсан. Энэ хоёрыг бүрэн боловсруулаад эцсийн бүтээгдэхүүн гаргахыг зорьж байлаа. Бид жилд 300 мянган савхин дээл гадаадад гаргадаг боллоо. Энэ бол 60-аад он юм. Энэ чинь юу вэ? Энэ бол том амжилт байсан. 3 сая 500 мянга, 4 сая шахам гутал хийгээд ард түмнийхээ хэрэгцээг хангаж байлаа. Түүгээр ч зогсохгүй гутлын үйлдвэртээ хийсэн гутлаа бид Чехэд гаргаж байлаа. Чех чинь гутлын орон шүү дээ. Тэр манайхаас гутал авч байсан.

К.Ю.: Таныг сайд болохын өмнө тийм үйлдвэр байсан уу?

П.Д.: Байгаагүй. Ерөөсөө намайг сайд болоход комбинатын хэдэн хуучин үйлдвэрээс өөр үйлдвэр байгаагүй. Бид хонины арьс боловсруулаад шеврет, ямааны арьс боловсруулаад шеврот хийдэг хоёр үйлдвэр байгууллаа. Та шеврет, шевротыг мэднэ биз дээ. Булигаарын завод гэж жилдээ 400 мянган ширхэг үхрийн шир боловсруулдаг үйлдвэр байгуулагдлаа. Нэхмэлийн, ноос угаах зэрэг үйлдвэрүүдийг байгууллаа.

К.Ю.: Хаана байгуулагдсан бэ? Бүгд адилхан газар уу?

П.Д.: Өө, яалаа гэж. Би байгуулсан газруудыг хэлье. Улаанбаатарт байгуулсан нь арьс шир боловсруулах, холих үйлдвэр юм. Үхрийн шир, хонь ямааны арьс боловсруулах үйлдвэр. Нийтдээ Улаанбаатарт хорь шахуу үйлдвэр байгуулсан.

К.Ю.: Улаанбаатарын хаана байгуулагдсан бэ?

П.Д.: Энэ чинь үйлдвэр комбинатад шүү дээ. Бие гайгүйсэн бол энд дээр үед гутал хийдэг үйлдвэр байсан, одоо Японы болон Хятадын, Солонгосын баар байна гээд та нарт танилцуулж болно шүү дээ. Манай Худалдаа, үйлдвэрийн сайд Ч.Ганзориг гэдэг залуу бий. Би танилцсан. Намайг байсхийгээд урьдаг юм. Сайхан залуу л даа. Би түүнд:

-Энэ үйлдвэрүүдээр сурвалжлага, сурталчилгаа явуулъя! гэж хэлсэн. Бид яаж залуу насаа, бүх зүйлээ зориулж байгуулсан билээ. Одоо юу болчихоод байгааг та нарт явж үзүүлье! гэж түүнд хэлсэн.

Сайд :

-Тэгье! гэж байна билээ. Одоо бидний үед байгуулагдсан үйлдвэрүүд бүгд байхгүй болсон. Би сүүлийн үед бие муудчихаад явж чадахгүй байна. Тэр үйлдвэрийн байрнууд нь бүгд түрээсийн байр болчихсон. Одоо хөнгөн үйлдвэрээс ажиллаж байгаа нь гэвэл Улаанбаатарын хивсний үйлдвэр байна даа. Бид хивсний гурван үйлдвэр байгуулсан юм. Та бодоод үз л дээ. 60-аад онд намайг сайд болж байхад мянгаадхан хавтгай дөрвөлжин метр хивс хийдэг байсан. Бид Улаанбаатарын хивсний үйлдвэр, Чойбалсан, Эрдэнэтийн хивсний үйлдвэрийг байгуулсан юм. Ийм гурван газар хивсний үйлдвэр байгууллаа. Ноос угаах үйлдвэр

байгууллаа. Хуучин бид ноосоо яадаг байсан бэ? Ноос, үс гэдэг чинь жил болгон л бэлтгэгдэнэ шүү дээ. Тийм үү? Түүний заримыг бараг угаалгүй, эсвэл аргал хоргол төдийхнийг нь арилгадаг хүйтэн угаалга гэж нэрлэдэг угаалганд оруулаад Зөвлөлт рүү гаргачихдаг байлаа. Ийм хүйтэн угаалгаас өөр ноос угаах үйлдвэргүй байлаа. Сүүлд бид ноос угаах дөрвөн үйлдвэр буй болголоо. Улаанбаатарын ноос угаах үйлдвэрийг шинэчиллээ. Чойбалсан , Баян-Өлгийд шинээр барилаа. Монгол улс чинь жилд 20-оод мянган тонн ноосыг бэлтгэдэг юм. Бүгдийг нь угаагаад, цэвэрлээд дотоодынхоо хэрэгцээнд зориулан хивс хийлээ. Илүү гарсныг нь гадаадад гаргадаг боллоо. Монголчууд чинь сүлжмэл эдлэлээ бүгдийг гадаадаас авдаг байлаа. Бид сүлжмэл эдлэлийн хоёр үйлдвэр Улаанбаатарт байгууллаа. Сүлжмэл эдлэл чинь нэхмэл биш шүү дээ Оросоор трикотаж гэдэг шүү дээ. Аймгуудаар яахав дээ жижиг оёдлын үйлдвэрүүд их байсан юм. Бүх аймагт ийм оёдлын үйлдвэр байсан Одоо бүгд байхгүй.

К.Ю.: Бүгд байхгүй болсон уу?

П.Д.: Бүгд баар болсон. Тэнд чинь гутал, дээл, пальто костюм хийдэг байсан. Орон нутагт хийсэн юм Улаанбаатарынханд жаахан гологдох хандлагатай байсан. Гэхдээ орон нутагтаа их хэрэгтэй. Тухайлбал орон нутагт “цагаан ултай гутал” гэж манайхан нэрлэдэг гутал хийдэг байсан. Одоогийн хүүхдүүд мэдэхгүй байх. Энэ гутал хүний биед маш сайн гутал байсан юм.

Одоо манай залуучууд Англи, Америк, Германы резинин ултай гутал авч ирээд л өмсөж байна. Одоо хорин хэдтэй байгаа залуучууд чинь тавь шахаад ирэхээрээ ихэнх нь бөөрний өвчтэй болно. Манай цаг агаарын нөхцөл тийм байхгүй юу. Энд чинь тийм чийг татсан юм өмсөж болдоггүй газар шүү дээ. Энийг залуучууд мэдэхгүй байна. Хятадын хар шаахай нэг хэсэг өмслөө. Дараа нь барууны резинин ултай, хүйтэн гутлыг өмсөх боллоо. Резинин ул гэдэг чинь маш хүйтэн, хүний биед хортой эд шүү дээ. Энэ орчин үеийн залуучуудад тийм гутал одоохондоо сайхан санагддаг байх. Кет гээд нэг юм өмсөөд гүйгээд байна. Залуу байхад болох л юм. Ийм гутал өмсөхөөр 40-50 нас хүрээд ирэхээр бөөр нь болохоо байгаад ирдэг юм. Бөөрнөөс гадна бас элэгний өвчтэй болно. Энэ бол манай амьдралаар шалгагдсан зүйл.

Бид 4 сая гутал хийдэг байлаа. “Цагаан ултай гутал” гэж дутуу боловсруулсан үхрийн ширээр хийдэг, зөөлхөн, морин дээр явахад их тохиромжтой, хөлд дулаахан гутал байсан. Түүнд ганц л дутагдал байсан. Усанд норохоороо жаахан сунадаг. Тийм учраас хотынхон өмсөх дургүй байсан. Хуурай газар өмсвөл яах ч үгүй. Монгол газар чинь их ширүүн хуурай шүү дээ. Бас чулуу ихтэй. Тэр шахмал резинин ултай гутал чинь

ийм газар явахад амархан байхгүй болдог юм. Цагаан ултай гутал бол мөлийгөөд яваад л байна шүү дээ.

Тэр жил америкаас ирсэн турист:

-Би дэлхий дээр ийм гутал хайгаад олохгүй байсан юм! гээд маш олон гутал худалдаж аваад явсан гэнэ шүү. Дээр үед бас тийм гутал хийдэг байж л дээ. Тэгээд сүүлдээ яагаад ч юм хийхээ больсон юм гэнэ. Тэгээд тэр хүнд олдохгүй байж л дээ. Юм мэддэг хүмүүс гэж тийм байгаа юм.

Ийм маягаар хөнгөн үйлдвэр арьс шир, ноосоо бүгдийг экспортонд гаргадаг байсан. Ялангуяа 70-80 онд их гаргаж байлаа.

К.Ю.: Орост бас гаргаж байсан уу?

П.Д.: Зөвхөн Орост биш, Европын социалист орнууд болох Чех, Герман, Болгар, Румын, Унгар бүгдэд нь гарч байсан. За арьс, ширний асуудлыг ингээд шийдлээ.

За ноосны асуудал байна. Бид сая нэг зуун мянгаад метр даавуу хийгээд дотооддоо борлуулдаг байлаа. Манайхан дээл өмсдөг шүү дээ. Дээлийг ноосон даавуугаар хийвэл дулаахан, бороо орвол дотогшоо нэвтрэхгүй шүү дээ. Бид ноосон даавууг дотооддоо хангалттай хийдэг болсон. Энэ бол нарийн ноос голлож хэрэглэдэг. Нарийн ноостой хонь бол манайд байсан. Бүдүүн ноос 20 мянган тонн бэлтгэдэг байлаа. Түүнийг чинь угаагаад хивс хийгээд дотоодын хэрэгцээгээ хангаад экспортонд гаргаж байсан тухай би ярьсан. Бид 2 сая хавтгай дөрвөлжин метр хивс хийгээд дотоод, гадаадад гаргаж байлаа. Үүнийг хаана ч гаргаж байсан. Японд ч гаргаж байсан.

13 Хүнсний үйлдвэрүүд

Хүнсний салбар дээр байдал ямар байсан вэ? Өөрийн чинь бичсэн өгүүлэлд Монгол өөрийн түүхий эдээ боловсруулаад, эцсийн бүтээгдэхүүн хийдэг болох хэрэгтэй гэсэн санаа байна билээ. Би өөртэй чинь санал нэг байна. Малыг чинь зөвхөн харж байхын тулд биш, зөвхөн махыг нь идэхийн тулд биш, харин малаас авах ашиг, шимийг бүгдийг нь ашигладаг байх ёстой юм.

Манай нам засгийн бодлого үүний дагуу л явж байсан юм. Малаас чинь мах, арьс, шир, үс, ноос, сүү гарна. Улаанбаатарт том мах комбинат Германы тусламжаар баригдсан. Чойбалсан хотод Болгарын тусламжаар мөн Дарханд Унгарын тусламжаар том комбинатууд баригдсан. Тэгээд хэд хэдэн аймагт жижиг мах комбинатыг байгуулсан. Хуучин малаа нилээд хэсгийг нь амьдаар нь гаргаж байсан бол бүгдийг боловсруулаад мах болгоод гаргадаг боллоо. Монгол анх удаа консервын завод барилаа. Махан консерви хийдэг болсон, одоо хийхээ больсон байх. Жилд 20 сая хайрцаг консерви хийгээд Европын бүх оронд гаргаж байлаа.

Манай махан консерви гэдэг чинь шал өөр шүү дээ. Таны өгүүлэлд бичсэн байна лээ. Манай мах гэдэг чинь сайн учрыг нь олж наймаалбал үндсэндээ зэрлэг амьтны махтай адилхан шүү дээ. Биенд их сайн ашиг тустай. Та Европ болон ийш тийшээ их явсан биз дээ. Тэндэхийн мах гэдэг чинь резин шиг шүү дээ. Тийм биз дээ. Ерөөсөө амт байхгүй. Үзэмж сайтай, гоё цэвэрхэн боодолтой. Манай малын мах өөр амт чанартай. Энэ тухай манай ерөнхийлөгч, гадаадын элчин сайд хоёрын хооронд болсон сонирхолтой яриа байдаг юм. Манай ерөнхийлөгч Ж.Самбуу гэдэг хүн байсан. Их хурц ухаантай, сайхан өвгөн байсан юм шүү. Гадаадын элчин сайдууд манай ерөнхийлөгчид итгэмжлэх жуухаа барьдаг байсан юм. Ж.Самбуу гуай өөрөө мал аж ахуйн том мэргэжилтэн хүн шүү дээ. Энэ талаар хэд хэдэн ном бичсэн. Ж.Самбуу гуай манай малын мах сайн гээд ярьж л дээ. Түүнтэй уулзсан элчин сайд:

-Ноён ерөнхийлөгч өө! Танаас тодруулах юм байна. Яагаад та Монголын малын мах сайн гээд яриад байна вэ? Европынхоос ялгаагүй биз дээ. Та тайлбарлаж өгөөч гэжээ. Тэгтэл Ж.Самбуу гуай:

-Европод бол мал юу өгснийг нь иддэг юм. Монголын мал бол юу дуртайгаа олж иддэг. Тийм учраас мах нь шал өөр байдаг юм гэжээ. Тэр бол яг үнэн үг.

Та Өвөр Монголд малаа маллах суурин аргад шилжээд мал хүн хоёр төвлөрөөд хэцүү байдалд орж байгаа тухай бичсэн байна билээ. Тэндэхийн мал нь бэлчээрт явж чадахаа байгаад эргэж буцаж хашаа руугаа, бэлэн тэжээл байгаа газар руугаа гүйгээд байдаг болсон тухай бичсэн байсан. Мал бэлчээрт явахаараа өөрөө өөрийгөө маш хямд үнээр тэжээдэг. Бид малаа амьдаар нь гадаадад худалдахаа болиод гурван том мах комбинат байгуулаад, түүгээр ч барахгүй консерви хийдэг боллоо.

Би сайд байхдаа Японд адууны мах экспортлох яриа хийгээд хариугүй бүтдэгийн даваан дээр зогссон юм. Түүнээс хойш 20 жил хожимдоод, одоо л Японд адууны мах гарч эхэлж байна шүү дээ. Юм гэдэг чинь их сонин байдаг юм. Хүн болгон адилхан бодож сэтгэж байдаггүй л дээ. Санаачлагагүй бол ямар ч ажил зогсоно шүү дээ. Миний танил Хаяаши гэдэг япон хүн байсан. Одоо нас барсан, их сайн хүн байсан юм. Тэр монголд ирлээ. Би түүнд адууны махны наймаа хийхийг санал болголоо.

-Манайд адуу их байна. Та үүнийг Японд сурталчилаад өгөөч. Би адуугаа бэлтгэе. Мах комбинатаа ажиллуулая! гэлээ. Манай мах комбинат бол улирлын чанартай ажилдаг юм. Одоо өдийд ажиллаж байх ёстой. 7 сараас 12 сар хүртэл ажилладаг байсан юм. Манай мал туувраар ирдэг учир улирлын чанартай ажилладаг байсан. Өвөл бол мал ирэхгүй гэсэн үг шүү дээ. Адуу бол өвөл ирж болно. Адуу бол өвөл л тарган байдаг. Тиймээс мах комбинат зогсох үеэс эхлээд адууг нядлаад Японд гаргах санал

тавьсан юм. Би Японд очиж хүнсний зүйл оруулах журамтай танилцаж байсан. Япон улс их өндөр шаардлага тавьдаг юм билээ. Ариун цэврийн талаас нь их анхаарч байсан. Би Хаяаши гуайд өөр нэг хүсэлт тавьсан.

-Адууны махны өөхийг шулаад хайрцаглах хайрцаг сав, гялгар уут зэргийг гаргаарай! гэсэн. Ингээд хоёулаа тохиролцоод нилээд удаан ярилцлаа.

Түүнийг ярьсны дараа би яамныхандаа үүрэг өгөөд Төв аймгийн нутагт 1200 сайхан залуу адуу бэлдүүллээ. Хөгшин адууны мах гэдэг чинь их хатуу шүү дээ. Шүдлэн, хязаалан чинь зөөлөн махтай. Японд хүнсний зүйл оруулахад их хатуу хянадаг. Тийм үү? ХАА Яам их хатуу хянадаг юм билээ. Хаяаши гуай хавар ирсэн юм. Тэгээд түүнийг намар дахин ирээрэй гэсэн. Тэр чинь 1977 онд байсан шиг санагдаж байна.

Хаяаши гуай:

-Намар би ХАА Яамны мэргэжилтэнтэй ирнэ. Тэр хүн адууг яаж, ямар нөхцөлд нядалдагийг үзнэ. Тэд нар газар дээр нь үзэж зөвшөөрөл өгдөг юм! гэж хэлээд явлаа. Одоо Японы ХААЯ гэж байна уу? Ингээд бид адуугаа бэлтгээд, үйлдвэрээ бэлэн байдалд оруулаад хүлээгээд байлаа.

Тэгээд тэр намар нь ирлээ. ХААЯ-наас хоёр хүн дагуулаад ирсэн байна. Би хүлээж авлаа. Манай мах комбинат ч сайхан л даа. Улаанбаатарын мах комбинат чинь жилдээ 1 сая 200 мянган бог мал, 120 мянган үхэр нядлах хүчин чадалтай юм. Энэ чинь их том хүчин чадал шүү дээ. Зарим үед энэ үйлдвэр дээр технологи алдагдах, балиартах, цус нөж болох явдал гардаг байсан. Ер нь махны үйлдвэр гэдэг ч хэцүү шүү дээ. Бид цэвэрлэгээг хийлгээд улам сайхан болгосон байсан. Германы технологитой үйлдвэр юм. Манай яамны орлогч сайд Японоос ирсэн хүмүүсийг дагуулаад үйлдвэрээ үзүүллээ. Дараагаар нь мах комбинатын бүтээгдэхүүнээр дайллаа. Ямар бүтээгдэхүүнүүд хийдгээ үзүүллээ. Би орлогч сайдаас дараа нь:

-Ямар болов? гэсэн

-Маш сайхан боллоо, их өндөр сэтгэгдэлтэй байна! гэж байна. Би тэднийг буцахын нь өмнө хүлээн авч уулзлаа. Тэд долоо хоноод явсан л даа. Хүн бол хүн шүү дээ. Япон ч, Орос ч, Монгол ч адилхан. Хаяаши гуайд сайхан сэтгэгдэл төрж л дээ.

-За ноён сайд аа! Би танд үнэнээ хэлье. Би танайд ямар бодолтой ирсэн бэ? Би үндсэндээ мах авахгүй байх гэж бодож байсан. Яагаад гэвэл монголчууд малыг яаж нядалдаг вэ? Үхрийг цохиод унагачихдаг. Хонийг гэдэргээ нь харуулж хэвтүүлж байгаад өрлөөд нядалдаг. Ийм бүдүүлэг аргаар нядалдаг газраас Япон яаж мах авах вэ дээ? Би үндсэндээ танайхаас мах авахгүй байх гэж бодож байсан. Танай мах комбинатыг үзээд манайд байдаг л мах комбинат байна. Европын дээд зэрэглэлийн

тоноглолтой, сайхан мах комбинат байна. Эндээс бид мах авахад ямарч саад байхгүй. Танай нөхөд дагуулж аваачаад адуу хариулж байгааг үзүүлсэн. Хоёр зуу, хоёр зуугаар нь суурилаад 6 суурь болгосон 1200 адууг чинь үзлээ. Адуу үнэхээр тарган, залуу, үйлдвэр чинь ийм сайхан байхад бидэнд ямар ч саад бэрхшээл алга! гэж байна. Та нар хонь гаргаж байгааг үзээ биз дээ. Тэр хүн тиймэрхүү л ойлголттой явжээ.

Тэгээд Хаяаши гуай:

-Би танд нэг зөвлөгөө өгье болох уу? гэж байна.

-Тэг тэг! гэлээ. Танайх тэр махандаа "Улаанбаатарын мах комбинат" гэж Англиаар бичээд "Японы тийм газарт" гэж хаяглаарай. Англиар бичсэн хаяг хийнэ гэсэн үг шүү дээ. Дотор нь хийх юмыг би ойлголоо. Харин энэ англи хаягаа гоё сайхан хийгээд наагаад байгаарай. Тэгвэл танай махыг японд авна. Хаягаа сайжруулаад наагаад байхад дотор нь хийж байгаа махны хувьд надад хэлэх юм алга гэж байна. Ингэж зөвлөж байсан юм. Манай хийсэн хаяг жаахан муухай харагдаж л дээ. Манайхан англи хэл мэдэхгүй болохоор жаахан болхидуу юм хийсэн биз. Ингээд би ч баяртай, Хаяаши гуай ч баяртай байлаа.

Тэр үед гадаад худалдааны гэрээг манай яам хийдэггүй, Гадаад Худалдааны Яам хийдэг байлаа. Ингээд бусад Япон нь яваад Хаяаши гуай гэрээ хийхээр үлдлээ. Би ч гэрээ нь юу болж байгаа бол гээд л дотроо бодоод, чагнаад байлаа. Хаяаши гуай нэг өдөр ирлээ. Сэтгэл маш дундуур байгаа бололтой царай нь онцгүй байна. Настай хүн л дээ.

-За ноён сайдаа! Би нөгөөдөр явлаа! гэж байна.

-Та нөгөөдөхөө яав? гэж би асуулаа.

-Танай гадаад худалдааны яам даан ч хэрэг алга. Их өндөр үнэ хэлээд байна. Танайхан нэг тонн адууны махыг 1400 ам.доллар гээд дэлхийд байхгүй үнэ хэлээд байна. Би бүр танай Гадаад Худалдааны Яамны сайдтай уулзлаа. Түүнээс гуйлаа, ядлаа! гэж байна. 1200 адууны мах гэдэг чинь нилээд мах шүү дээ. 100 гаруй тонн болно. Цэврээрээ бол 200-аад шахуу тонн болно. Тэр Японд их сурталчилгаа хийсэн байж. Монголоос адууны мах ирнэ гээд сурталчилсан юм байх. Америкаас адууны махныхаа гэдэс дотрыг нь манайд өгөөч гэсэн хүсэлт түүнд бас ирсэн байж. Давхар давхар бөөн шуугиан болж л дээ. Монголын адууны мах гэдэг чинь деликатес юм шүү дээ. Хүний эрүүл мэндэд маш сайн. Ялангуяа цусны даралт ихсэх, судас бүдүүрэх зэрэгт маш сайн. Адууны махыг чинь баячууд л иддэг байсан юм. Жирийн ардад бол олдохгүй шүү дээ. Тийм учраас тэр авахаар зүтгэсэн юм л даа.

Тэгээд Хаяаши гуай:

-Танай Гадаад Худалдааны Яам даан ч хэрэг алга. Ашиг олохыг хэн ч бодно. Япон ч бодно, Монгол ч, Орос ч, Немц ч бодно. Хэн ч орлого

бодно. Танайхан чинь нэг тонн махыг 1400 амдолларааp өгнө гээд байна. Тэгэхээр нь би компаныхаа нууцыг задаллаа. Би Улаан-Үдэд очсон. Тэнд танай адууг нядлаад надад өгөхөөр болсон. Би тэр Улан-Үдээс, Оросоос авч байгаа контрактаа үзүүллээ. Уг нь үзүүлэх ёсгүй л дээ. Дэлхийд байхгүй, жишиггүй юм яриад байхаар нь уур хүрээд, компаныхаа нууцыг задлаад Улаан-Үдийн Оростой байгуулсан гэрээгээ үзүүллээ. Тэндээс 950 ам.доллараар авна гээд заасан байсан. Гэтэл танайх 1400 доллар гэдэг чинь дэндүү үнэтэй байна. Монгол нөхөд их анхаарал тавьж байна. Ялангуяа Хөнгөн Хүнсний Үйлдвэрийн Яам их анхаарч байна. Бид анх удаагаа ийм наймаа хийж байна. Японд мах гаргах чинь цаашдаа олон жилийн юм болно гэж бодоод танай адууны махыг 1100 ам.доллараар авмаар байна. гээд л ярилаа. Танайхан огт зөвшөөрөхгүй юм. Би ядлаа. Би одоо явлаа. Харин би танд өгөхөөр бэлтгэсэн хайрцаг савны машин, хайрцаглах картон, гялгар уут зэрэг бөөн юм тэр Находкагийн цаана боомтод ирээд, одоо хоёр сар хүлээж байна. Маш их төлбөр төлчихөөд байж байна! гэж хэлээд тэр яваад өглөө. Их муухай юм болж байгааг би ойлгож байлаа. Тэглээ гээд ямар ч арга байхгүй. Сүүлд нь би Гадаад Худалдааны Яамныхантай муудалцаад, хэрэлдээд зүйл дууссан. Ноднин Багахангайн мах комбинатаас Японд адууны мах гаргаж эхэллээ гэж би сониноос уншаад:

-Цаг үе өөр болжээ. Тухайн үедээ би муугүй л бодож байж! гэж дотроо бодож билээ. 20 жилийн өмнө гарчихсан бол энэ хугацаанд чинь замаа олоод жигдэрчихсэн байна шүү дээ. Ингэж мах, махны үйлдвэрүүдийн асуудлыг шийдвэрлэсэн шүү дээ.

За гурилын үйлдвэрүүд ямар байв? Манайх чинь 800 гаруй мянган тонн будаа хурааж аваад 200 гаруй мянган тонн гурил хийдэг байлаа. Будаанаасаа илүү гарсныг нь экспортонд гаргадаг байсан. Гурил хийгээд гурилаа гаргадаг байсан. Одоо Монголоор дүүрэн Хятадын гурил байна шүү дээ. Тийм биз дээ. Гурилын үйлдвэрүүд Улаанбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл, Булган, Улаангом, Хархорин, Хэнтий, Дорнод ийм хэдэн газруудад байгуулаад гурилын асуудлыг шийдвэрлэсэн.

К.Ю.: Одоо Улаанбаатарт гурилын үйлдвэр ажиллаж байна уу?

П.Д.: Ажиллаж байна. Гэхдээ хуучиндаа хүрэхгүй байна. Хамгийн гол нь Улаанбаатарын гурилын үйлдвэр гадаадаас, Казахстанаас будаа авч байна шүү дээ. Энэ ямар хэрэгтэй юм бэ? Бид чинь 800 мянган тонн будаа авдаг байлаа. Өнгөрсөн жил дөнгөж 200 мянган тонныг хурааж авлаа шүү дээ. Бид 800 мянган тонныг хурааж аваад өөрийнхөө хэрэгцээг бүгдийг хангаад, гурил, будаагаа экспортонд гаргадаг байлаа.

К.Ю.: Би 20 жилийн өмнө Улаанбаатарт сууж байсан. Тэр үед гадагшаа гаргаж байсан шүү дээ.

П.Д.: Ийм байдлаар гурилын асуудлыг шийдсэн. Монгол хүнд нэг сонин юм бий. Боов чихрийг их хэрэглэдэг. Өөрийг чинь айлд ороход заавал нэг тавагтай чихэр өгч багаа биз. Тэр чинь их чухал юм шүү дээ. Чихрийг хуучин гаднаас авдаг байлаа. Тэгээд бид чихрийг дотооддоо хийх болсон. Улаанбаатарт чихэр боовны хоёр комбинат байгууллаа. Хуучин комбинатаа өргөтгөлөө. Шинэ комбинатыг Толгойтод байгууллаа. Дарханд шинэ комбинатаа байгууллаа. Үүгээр чихрийн асуудал шийдэгдсэн.

Монгол хүн талх иддэггүй байлаа. Талх хийдэг боллоо. Талхны 1,2,3-р үйлдвэрийг Улаанбаатарт байгууллаа. Том үйлдвэр шүү. Аймаг болгон өөрийн талхны үйлдвэртэй болсон. Улаанбаатарт үйлдвэрийн хоёр район байдаг юм. Энэ нь аж үйлдвэрийн комбинатын район, Толгойтын район юм. Энэ нь нөгөө цахилгаан станцтай холбоотой юм. Хүнсний үйлдвэрүүд голдуу Толгойтын районд байдаг. Тэнд мах комбинат, гурилын үйлдвэр, талх чихрийн үйлдвэр бий. Арьс, шир, ноосны үйлдвэрүүд комбинатын хашаан дотор байдаг. Чихэр боов, печень-жигнэмэг зэрэг гаднаас авдаг байсан зүйлүүдээ өөрсдөө хийдэг болсон.

К.Ю.: Печень бас хийж байсан уу?

П.Д.: Хийлгүй яахав.Одоо манай захаар ороход дандаа л гадны печень байна шүү дээ.

К.Ю.: Одоо монгол печень гэж байхгүй болсон уу?

П.Д.: Байх нь байгаа байх л даа. Их л бага болчихсон байна. Ингээд бид ард түмний өргөн хэрэгцээний дээл, гутал хувцас, идэж уух зүйл бүгдийг хангаад, хүнсний гол зүйлүүдээс сахарыг л гадаадаас авдаг байсан. Архи, ундааны зүйлээс бол пиво, архи, амтат ус бүгдийг өөрсдөө хийдэг байсан. Одоо Улаанбаатараар дүүрэн гадаадын архи байна. Энэ мэтээр миний сайд байсан 1960-80-аад оны 30 жилийн дотор ард түмний өргөн хэрэгцээний барааг бүгдийг хангаад илүү гарснаа экспортонд гаргаж байсан. Тэгээд харамсалтай нь та нар одоо үзэж байна, өнөө үе, сүүлийн 10 жил энэ бүх барьж босгосон зүйлүүдийг устгалаа.

14 Хувьчлалын алдаа, завхралууд

Энэ дээр би нэг зүйлийг хэлье гэж бодож байна. Сүүлийн үед манай үйлдвэрүүд зогссон шалтгааны талаар “Их мэдэгч” нарын зүгээс тайлбар хийхийг оролдож байна. “Их мэдэгч” гэж та мэдэх үү? Монголоор дүүрэн их мэдэгч нар байгаа шүү дээ. Та их мэдэгч нартай танил уу? Их мэдэгч манайд их байгаа.

Тэд нар:

-Өө тийм байсан, ийм байсан, тийм нийгэм, ийм нийгэм гээд л ярина.

Түүхийг их гуйвуулна. Өөрөө түүх мэддэг үү? Түүх мэддэггүй хүмүүс түүхийг гуйвуулдаг шүү дээ. Тэд нар манай мал аж ахуйн түүхий эд боловсруулдаг, ялангуяа хүнсний үйлдвэрүүд зогссон явдлуудыг буруу тайлбарладаг юм.

-Манай үйлдвэрүүд хоцрогдсон. Тэр Зөвлөлт, Чех, Германы байгуулж өгсөн үйлдвэрүүд бүгд хоцрогдсон техниктэй учраас зах зээлийн шаардлага хангаж чадаагүй, арга буюу гараа өргөөд бууж өгсөн! гэж ярьцгаадаг. Энэ бол өөрсдийнхөө хийсэн алдааг хаацайлсан яриа мөн. Тэд нар өөрсдийнхөө алдааг шударгаар хүлээж чадах чадваргүй байгаагийн баталгаа юм. Би энэ тайлбарыг хүлээж авахгүй. Манай үйлдвэрүүд бол орчин үеийн үйлдвэрүүд шүү. Та бодоод үз. Англид одоо 18-р зуунд байгуулагдсан их хэмжээний үйлдвэрүүд ажилласаар байна. 19-р зууны үед байгуулагдсан үйлдвэрүүд ч тэнд байна. Америкт ч, Японд ч байж л байна. Түүнийг яадаг вэ гэхээр байшин барилгыг нь засдаг юм, техникийг нь өөрчилдөг юм. Түүнээс биш одоо энэ манай их мэдэгч нар шиг тайлбар хийгээд сууж байдаггүй юм.

Би ер нь их мэдэгчийг бидэнтэй адилхан хоёр хөлтэй, гутал өмсдөг байх гэж бодож байна. Их мэдэгч учраас хөл нь дөрөв болоод л, нүд нь дөрөв болоод л, өнөө бидний хийж байсан гутал хувцас таарахаа байчихдаг гэж бодохгүй байна. Адилхан л байх ёстой шүү дээ. Тэд нарын тайлбар гадаад, дотоодын хүмүүст буруу ойлголт төрүүлээд байгаа юм. Энэ бол их муу.

Манай үйлдвэрүүдэд хоцрогдсон юм байсан уу? Байсан. Муу тал байсан нь уу? Байлгүй яахав. Тэр чинь хаана ч байдаг зүйл. Байдаг ёстой юм. Тэгвэл яах ёстой вэ? энэ 10 жилийн дотор муугий нь сайжруулаад, сайныг нь хэвээр үлдээгээд улам сайн болгох ёстой юм. Би ганцхан жишээ хэлье. 4 сая гутал хийж байлаа. Энэ гутлыг монгол хүн өмсөөд эрүүл энх сайхан л байна. Одоо тэр 4 сая гутал чинь байхгүй болсон. Хэрвээ тэр гутлыг аваад үнэхээр сайжруулсан бол манай нөхцөлдөө таарсан сайхан гутал байсан юм. Тэр үйлдвэр одоо цамц оёж Америкт гаргадаг Хятадын үйлдвэр болсон байна. Өнөө гутлын үйлдвэр байхгүй болсон. Ингэж болохгүй шүү дээ.

Өмч хувьчлал манайд явагдлаа шүү дээ. Гутлын үйлдвэрийн 6 давхар том сайхан байшин бий. Орчин үеийн тоног төхөөрөмж тавьсан байлаа. Зарим тоног төхөөрөмж нь жаахан хуучирсан тал бий. Түүнийг сайжруулаад ажиллуулж болно. Манай энэ "ухаантай" улсууд хувьчлалыг буруу хийгээд байна. Би ухаан "муутайгаараа" хувьчлалыг өөр аргаар хийх байсан юм. Үйлдвэр хувьчлаад авч байгаа хүн чинь их баян хүн байна шүү дээ. Тэр чинь нэг луйварчин явж байгаа юм. Улсын банкнаас их мөнгийг хуйвардаад авсан байна. И.Лхагвасүрэн банкны эзэн гэж бодьё л

доо:

-За надад чи хоёр милиард төгрөг зээлээр өгчих! гээд хуйвалдаад авчихна. Өнөө мөнгөөрөө үйлдвэр авчихаад, байрыг нь Хятадад хөлслөөд зээлж авсан мөнгөө эргүүлээд олоод авч байгаа юм. Хувьчлалыг хийх ёстой. Улсын нуруун дээр бүгдийг үүрүүлээд байх нь хэцүү байх л даа. Хийхдээ нэг ийм маягаар хийж болохгүй.

-За энэ 4 сая гутал хийдэг үйлдвэр. Та аваад 4 саяас доош буулгаж болохгүй. Манай хүн ам хүүхэдтэйгээ нийлээд 2 сая 500 мянга. Тиймээс энэ тоог бууруулж болохгүй. Хамгийн гол нь хийж байгаа гутлаа гоё, чанартай болго! Ингэсэн нөхцөлд танд өгнө! гэвэл хувьчлал болох ёстой юм шүү дээ. Ийм нөхцөл тавиагүй өгчих дээр чинь хөнгөн үйлдвэрүүдийг унагаад таны тэр бичсэн өгүүлэлд байгаа шиг малчин ардууд яах вэ? Мөнгө өгсөн хүнд л малынхаа үс, ноос, арьс ширийг өгөхөөс өөр аргагүй байдалд орно шүү дээ. Хэрвээ хуучнаараа байсан бол энэ систем нь улам боловсронгуй болно шүү дээ. Би үйлдвэрийн газруудыг хувьчлах ёстой гэж боддог. Гэхдээ ухаантай учир зүйг нь олж хувьчлах ёстой гэж боддог. Тэгсэн бол таны тэр өгүүлэлд байгаа шиг малчин ардыг зах зээлтэй холбоотой хэвээр байлгаж чадах байсан юм.

Манайд ХАА-н 259 гаруй нэгдэл байсан. Үүнийг чинь бүгдийг нь устгаад хаясан шүү дээ. Ингэж болохгүй шүү дээ. ХАА-н нэгдлийг устгаж болно. Гэхдээ малаа жинхэнэ мал маллах хүнд нь өгөөд, харин ХАА-н нэгдэл чинь малчин ардаасаа арьс, шир, ноос, ноолуурыг нь авдаг, үүнийхээ оронд малчин ард түмнийг цай, даалимба, хоол хүнсээр хангаж байх ёстой шүү дээ. Энэ холбоог нь тасдаад хаячихаар малчин ард чинь зах зээлд ямар ч барьцгүй болж байна шүү дээ. Үүнээс хэн хожиж байна вэ? Нэг жип унасан, араасаа арав гаруй машин дагуулсан, улаан шар иштэй янжуур зуусан, кармандаа 2-3 хутга хийчихсэн наймаачин л хожиж байна шүү дээ. Ийм хүн ирээд ноолуур авна гэхээр малчид өгөхөөс өөр яах юм бэ? Тэд чинь гурил будаа, сахар, хувцас, даавуу авах хэрэгтэй. Би үүнийг зүгээр нэг алдаа биш улс төр, эдийн засгийн том алдаа гэж ойлгодог. Тийм үү? Үгүй юу? Би буруу ярьж байна уу? Тэгвэл та уучлаарай. Би энэ үйлдвэрүүдийг бариулсан хүний хувьд эд нар ингэж нурсанд нь их харамсаж байгаа. Их харамсаж байна. Яахав учир дутагдалтай байсан байж болно. Тэр дутагдалыг нь засаад авах хэрэгтэй шүү дээ.

Манай Монголчуудад нэг сайхан заншил бий. Аав, ээжийн сууж байсан гэрийг хэзээ ч нурааж хаядаггүй. Сайхан засаад, эвдэрсэн бол эвлүүлээд, өнөө муу шар эсгийг нь шинэ цагаан эсгий болгоод, гадуур дотуур цагаан бүрээсийг нь солиод, өнөө аав, ээжийн хэдэн муу авдрыг нь шинэ авдар болгоод ингээд аав ээжийн гал голомт тэр чигээрээ цаашаа

бадарч явдаг шүү дээ. Одоогийнх шиг нурааж хаяачихаад, сайн сайхан болно гэж ярьдаггүй юм. Энэ бол гал голомтоо залгамжлах Монгол ёс заншил юм. Одоо нүүдлийн соёл иргэншил гээд яриад л байна. Энэ нүүдлийн соёл, иргэншил гэдэг чинь шинжлэх ухааны том ойлголт юм. Нүүдлийн амьдрал гэдэг бол хоцрогдол биш. Өөрийн амьдралыг байгаа орчиндоо тохируулан авч явах арга ухаан юм. Үүнийг улам сайжруулахын оронд хийсэн юмаа эвдээд хаячихаж байгаа юм. Манайхан тэр Англи, америкт жаахан ном үзэж л дээ. Тэдний амьдрал гэдэг чинь шал өөр юм шүү дээ. Тэгээд энэ 10 жилд нураагаад хаячихсан. Одоо дахиад үйлдвэрээ сэргээх гэсэн асуудал тавьж байна.

15 Үндэсний үйлдвэрүүдийг сэргээх бодлого

К.Ю.: Одоо яаж сэргээх вэ?

П.Д.: Нилээд зоригтой арга хэмжээнүүд авах хэрэгтэй. Одоогийнх шиг ийм бэлбэгэр байж болохгүй. Монгол чинь онгоц, трактор, автомашин хийдэггүй. Монгол хийдэг юм бол арьс, шир, ноос гаргадаг. Бидний гол зүйл чинь энэ шүү дээ. Монгол улс ноос, арьс ширийг экспортлохгүй гэсэн л шийдвэр байвал боллоо. Хэрвээ эдгээр зүйлүүдийг улсын хилээр гаргасан байвал толгойг чинь авна шүү гэхэд л болно. Тэгвэл тэр малчид чинь улсад арьс, шир ноосоо тушаана. Бид эргээд тэднийгээ харна шүү дээ. Ингэвэл тэр үйлдвэрүүд чинь ажиллах түүхий эдтэй болно шүү дээ. Тэгэхэд одоо яаж байна. Монголын ноосыг Хятадын наймаачин авч байна. Гэтэл үйлдвэрүүд нь түүхий эдгүй зогсож байдаг. Би үүнийг ойлгохгүй байгаа юм. Ийм бодлого гэж яаж байж болох вэ? Ийм байхад яаж үйлдвэрүүдээ сэргээх тухай ярих вэ дээ.

Одоо манайхан чинь хөтөлбөр гэдэг юмыг их хийх болж. Ноолуур боловсруулах үйлдвэрийн хөтөлбөр, арьс, шир боловсруулах хөтөлбөр, тариа тарих хөтөлбөр гээд хөтөлбөргүй юмгүй болсон байна. Одоо авгай бид хоёр л хоол хийх хөтөлбөр хийх л дутаж байх шиг байна. Тэгээд нөгөө хөтөлбөр нь болж байгаа юм ердөө ч алга. Тэгээд тэр болохгүй байгаа шалтгаанаа тайлбарлахдаа их сонин үг хэрэглэнэ. Үгүй би тэр үгийг санахгүй байна. Тогтолцоо нь гэнэ үү цогцолбор нь гэнэ үү, тэр нь буруу учраас биелээгүй гэх юм. Нэг тийм үг бий. Манай том дарга нар үргэлж хэлж байгаа. Тэр чинь аливаа хариуцлагагүй, сахилгагүй юмаа дарагдуулсан тайлбар шүү дээ. Сүүлийн үед өмч хөрөнгө идсэн, уусан зүйл их болсон шүү дээ. Энэ бол өмч хувьчлал буруу явуулснаас л болсон хэрэг. Өмч хувьчлал буруу явуулснаа булзааруулаад тогтолцоо нь буруу байснаас ийм боллоо гэдэг болсон. Ингэж ард түмний толгойг эргүүлж байна. Бас "менежмент" гэдэг үгийг их хэрэглэх болсон. Малчин хүн тэр үгийг нь ойлгохгүй. Танай энэ ноосыг буруу боловсруулсан байна

гэхийн оронд менежмент нь буруу байна гэж хэлдэг. Малчин хүн үүнийг ойлгохгүй л дээ. Энэ мэтээр хэдэн гадаад үг, хэдэн Монгол үгээр тоглооод байгаа юм. Энэ бол их аюултай. Тэгээд бидний босгосон бүхнийг буулгаад байна шүү дээ.

70 жил МАХН Монголын ард түмнийг буруу замаар будаа тээлгэсэн гэж байна. Буруу замаар будаа тээлгээгүй. Бид Монголын ард түмний сайн сайхны төлөө бүхнийг хийсэн. Ажил хийж байгаа хүн алдаа гаргадаг л юм даа. Дутагдал байсан байж болно. Би саяхан нэг нөхрийн бичсэн өгүүлэлийг уншлаа. Дэг журам гэдэг юм аль ч үед байх ёстой юм. Одоо манайх дэг журамгүй болжээ. Дэг журам дээр ардчилал байх ёстой юм. Үнэндээ ардчилал гэдэг чинь өөрөө дэг журам юм. Ардчилалгүй дэг журам бол диктатур болдог гэнэ. Ардчилал нь дэг журамгүй байгаа учраас анархизм болсон. Хуучин дэг журам байгаад ардчилал байгаагүй учраас диктатур байсан юм. Хуучин диктатур байгаад одоо анархизм болж байгаа юм. Манайд одоо анархизм бий болчихоод байна. Үндэсний үйлдвэрийг босгоход манайд одоо юу байна. 5-6 сая хонь, ямааны арьс шир нь байж байна. Жил тутам гардаг 400-500 мянган үхрийн шир нь байж байна. 3000 тонн ноолуур нь байж байна. 20 мянган тооно ноос нь байж байна. Тариа таривал нэг сая га газар нь байж байна. Бүх л юм байдгаараа л байж байна шүү дээ. Нэг талаас түүхий эд, нөгөө талаас үйлдвэрүүдэд ажиллаж байсан инженер, техникийн ажилтнууд нь байж л байна. Харамсалтай нь сүүлийн үед тэр инженер, техникийн ажилтнууд нь ТҮЦ-ийн худалдагч, захын наймаачин болоод дуусч байна. Би танд хэлж байсан 100-аад мянган ажилчид чинь ажилгүй гудамжинд гарсан. Авхаалжтай нэг нь дамын наймаанд явсан. Тэгсэн ч тэд ажлын дадлагатай тул дахин цуглуулбал ажиллаж чадна.

Бидний үед ажилчин хүнийг яаж бэлтгэж байсан бэ? гэдэг асуудал байна. Малчин хүнийг ажилчин болгоно гэдэг сэтгэл зүйн том өөрчлөлт явагдаж байгаа юм. Малчин хүнийг авч ирээд шууд ажилчин болгоно гэдэг чинь зөвхөн хөдөлмөрийн хөлсийг шийдэх асуудал биш. Өчигдөр морины дэл дээгүүр, эрх дурааараа, чөлөөтэй, эрүүл агаарт давхиж явсан хүн, гэнэт нэг их шуугиантай, хачин үнэр танартай байшин дотор орж ирээд ажил хийнэ гэдэг хэцүү асуудал. Манайд ажилчин анги байгаагүй. Ажилчин анги цоо шинээр бий болсон. Одоо ажилчны хүүхэд ажилчин болдог, хүүхдийн хүүхэд нь ажилчин болдог сайхан үе эхэлж байна.

Ажилчдаа бэлтгэдэг системтэй байлаа. Нарийн мэргэжлийн инженер техникийн ажилтнуудыг социалист орнуудад явуулж сургадаг байсан. Бас нарийн мэргэжлийн ажилчин, мастер зэргийг тэдгээр орнуудад бэлтгэдэг байлаа. Үүний хажуугаар манайд 30 гаруй техник мэргэжлийн сургууль байгуулагдсан байсан. Энэ бол 2 жилийн хугацаатай сургууль байсан.

Энд хүүхдүүд 8 ангиа төгсөж ороод 10 жилийнхээ боловсролыг аваад, хоёр жилд мэргэжлийн дадлага олоод мэргэжлийн ажилчин болж төгсдөг байсан. Энэ бол 70-80-аад онд байсан сургууль шүү. Одоо энэ бүгд "баар" -ны ТМС болсон. Зарим нь аймаг дундын техник мэргэжлийн сургууль болсон. Манай хөнгөн үйлдвэрийн салбарт хоёр техник мэргэжлийн сургууль байсан. Хөнгөн үйлдвэрийн ТМС, Хүнсний ТМС байсан. Энд хөнгөн үйлдвэрийн салбарт ажилладаг нэхмэлчин, гуталчин, арьсчин, монтер, слесарь зэрэг төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийг бэлтгэж байлаа. Хүнсний техник мэргэжийн сургуульд талхчин, нарийн боовчин, чихрийн мэргэжилтэн бэлтгэж байлаа. Мөн гадаадын техник мэргэжлийн сургуульд нарийн мэргэжлийн хүнийг бэлтгэж байсан. Ингэж гол мэргэжлийн ажилчдаа техник мэргэжлийн сургуулиар сургаж бэлтгэдэг байлаа.

Бас мэргэжилгүй хүн ажиллах ёстой шүү дээ. Бүгдийг сургуулиар бэлтгэх шаардлага байгаагүй. Тийм хүмүүст үйлдвэрийн дадлагыг туршлагатай ажилчин дагуулаад олгож байсан. Тийм хүмүүс нэг хоёр сарын дагалдан хийгээд ажилчин болно. Ийм замаар бэлтгэсэн ажилчин анги 100-аад мянган хүнтэй болсон. Одоо тэдний хүүхэд нь ажилчин болж байна. Бид ийм сайхан үед хүрлээ. Тэгтэл тэд нарыг гудамжинд гаргасан. Энэ зогссон үйлдвэрүүдийг сэргээж болно. Жаахан мөнгө, хугацаа хэрэгтэй. Эвдэрсэн байшин барилгыг засчихна. Баарны лангуунуудыг гаргаж хаяад оронд нь суурь машинуудаа тавьчихна. Энэ бол болох асуудал. Харин мөнгө хэрэгтэй.

Миний сэтгэлийг зовоодог бас нэг зүйл бол энэ ажилгүй болсон залуучуудыг яаж засах вэ? Энэ хамгийн хэцүү асуудал болоод байна. Олон сайхан ажилчин залуучууд байлаа. Энэ өнгөрсөн 10 жилд 10 настай байсан хүүхэд гудамжинд гараад, одоо 20 настай болсон. Тэр бол ямар ч мэргэжилгүй, боловсролгүй хүн. Тэр хэн бэ? Тэр бол дээрэмчин, алуурчин, хулгайч хамгийн аюултай хүн гарч ирсэн. Сайхан залуу нас шүү дээ. Мэргэжилгүй болчихсон. Үйлдвэрүүдийг сэргээж болно. Мэргэжлийн ажилчдыг бэлтгэж болно. Үүнийг хийхэд 10-15 жил л шаардлагатай. Бид анх байшин барилга байхгүй байхад нь бариад, ажилчдыг нь хэнийг нь дотоодод, хэнийг нь гадаадад, хэнийг нь дагалдангаар сургахыг шийдээд, гадаадаас мэргэжилтэн уриад өөрсдийнхөө ахмад ажилтнуудыг дагалдуулаад сургаад авч чадсан юм. Намайг сайд болж байхад манай ажилчин анги 20 мянган хүнтэй байсан бол 80-аад оны сүүлчээр 100 гаруй мянган хүнтэй болсон. Бүгд мэргэжлийн хүмүүс байсан. Мэргэжлийн хүмүүс гэдэг чинь машин техниктэйгээ сайн харьцана, хөдөлмөрийн бүтээмж нь өндөр байна шүү дээ. Ингэж бид бэлтгэж авч чадсан юм.

Энэ 10 жилийн дотор энэ сайхан мэргэжилтэй залуусыг эвдээд

дууссан. Энэ эвдэрсэн залуучуудыг чинь засахад дахиад 10 жил, 20 жил багадана. Одоо 10 настай хүүхэд эцэг эхдээ хөөгдөөд гудамжинд гараад траншейнд амьдарч байна. Тэд том болоод намайг хүүхэд байхад хэн харж үзлээ, хэн ч харж үзээгүй гээд өшөө авагч болно шүү дээ. Тэр хүний амьдрал 60-70 жил үргэлжилдэг юмаа гэж бодоход тэдний хүүхдүүдэд нь энэ хүмүүжил нь нөлөөлнө шүү дээ. Энэ мэтээр үргэлжилнэ. Тийм учраас миний сэтгэлийг хамгийн их зовоож байгаа зүйл бол энэ буруу замаар орсон олон залуучуудын асуудал байна. Эднийг эргүүлээд бидний байсан үе шиг боловсролтой, хүмүүжилтэй, сахилга баттай, ажилтай болгоход олон жил шаардагдана.Энэ л хамгийн аюултай асуудал болоод байна.

1990 онд манай хүн ам бичиг үсэгтэй, бичиг үсэг мэдэхгүй хүн гэж байхгүй байсан. Одоо захаасаа аваад тийм залуучууд олширч байна. Цэрэгт очсон залуучууд бие биенийгээ буугаар буудаж алаад байна. Тэр чинь буудаж алахгүй яах юм бэ? Тэр хүүхэд чинь 18 настай цэрэгт очсон байгаа. Түүний 10 жилийг нь траншейнд амьдарсан байгаа. Тэр чинь ямар ч бичиг үсэг мэдэхгүй, ямар ч боловсролгүй хүн шүү дээ. Тийм хүний гарт цэргийн буу өгөхөөр өөр нэгийгээ буудаж байгаа юм л даа. Энэ чинь зүгээр нэг асуудал биш. Энэ бол маш том асуудал. Тийм учраас энэ Монголыг сэргээн босгоно гэдэг бол нилээн хатуухан зохион байгуулалтын доор нилээд хүчин чармайлт гаргаж байж биелүүлэх асуудал юм. Зүгээр нэг хөтөлбөр хийгээд биелэх асуудал биш.Тэр хөтөлбөр гээчийг их хийж байна. Түүндээ их том гарчиг өгнө. Одоо ажил хийхийн тулд өнөө тогтолцоо билүү, тохиролцоо ч билүү юмаа тааруулах гэж л нэг их юм болох юм. Одоо манайд зөвлөгөөн болохгүй өдөр гэж байхгүй болж. Би түүнийг бүртгэж үзээгүй.

"Говь" комбинатыг барихад дээд тал нь 60-70 хүн ирж, энэ үйлдвэрийг чинь барьж босгосон юм шүү дээ. Ашиглалтанд орсны дараа бид Японоос 2-3 мэргэжилтнийг урьсан. Урихдаа бид зүгээр уриагүй. Жинхэнэ нарийн мэргэжлийн хүнийг урьсан л даа. Тэр хүн ирээд багшлах хүнийг бүр тогтчихсон байна. Ирээд 3 сар ажиллана гээд хугацааг нь бас заачихсан байсан. Тэд нар ирээд заасан хугацаанд, тогтсон хүмүүсийг сургаад буцсан. Ийм маягаар бүх юм тодорхой байх ёстой шүү дээ. Одооны зөвлөгөөнийг хийхгүй сэдэв гэж алга. Мөдхөн энэ ТҮЦ, баарны асуудлаар зөвлөгөөн болох байх. Япон, Америкт баар яаж байгуулдагийг л заалгах дутаад байх шиг байна. Улаанбаатарт өдөр бүр "Чингис" зочид буудалд л гэнэ, "Их тэнгэр"-т л гэнэ хурал зөвлөгөөн л хийгээд байх юм. Хурал зөвлөгөөнийг хийж болно. Манай Монголд нэг зүйр үг байдаг юм. Та нар бараг дуулсан байх.

Хурал ихэдвэл ажил муудсаны тэмдэг

Хуушуур ихэдвэл мах муудсаны тэмдэг гэж хэлдэг.

Махаа муудахаар хуушуур хийгээд л хайраад хаячихдаг. Энэ их оносон үг л дээ. Одоо манайд өдөрт хэдэн арван хурал болж байна. Ийм учраас энэ хурал зөвлөгөөний асуудлыг нарийн бодох ёстой юм. Та тэр бичсэн өгүүлэлдээ Өвөр Монголтой холбоод их зөв асуудлыг дэвшүүлсэн байна лээ.

Би өнөөдөр танд их баярлаж байна. Энэ миний ярьсан зүйлүүдээс манайхан хэрэгтэй санаа, оноог аваад ажилдаа хэрэглэвэл, энэ бол таны зүгээс бидэнд үзүүлж буй тусламж шүү дээ. Бид нэг тивд байдаг Азийн орны хувьд сайхан сэтгэл гаргаж туслаж байна гэж ойлгож байгаа. Гэхдээ энэ тусламжийг ухаантай ашиглах хэрэгтэй. Сато Норико гэдэг хүн өгүүлэл бичсэн байна билээ. Тэр хүн Японоос өгсөн тусламж Улаанбаатарт ирж алга болоод жинхэнэ хөдөөний ард түмэнд хүрэхгүй байна гэжээ. Тиймээс тусламжийг их ухаантайгаар юунд зарцуулахаа сайн бодож байх хэрэгтэй л дээ. Гадаадын хүнийг урихдаа ч их учир зүйтэй хандах хэрэгтэй. Бид үнэхээр хэрэгтэй зүйлдээ тусламж авах хэрэгтэй юм. Тэр өндөр хөгжсөн орнуудад нэг хэцүү зүйл байдаг.Тэд чинь өөрсдийнхөө хэмжээгээр бодоод байдаг юм. Тэд нар өөрсдийн хэмжээгээр хэмжээд, ийм байх ёстой гэсэн зөвлөгөө өгөөд байдаг юм. Манай нөгөө "их мэдэгч" нар яг түүнийг дуурайгаад л тийм болох гээд зүтгээд явчихдаг. Тэдний өгсөн зөвлөгөөнд бидний амьдралд таарахгүй юм их байдаг. Тийм учраас хурал зөвлөгөөнийг учир зүйтэй хийх хэрэгтэй л дээ.

16 Ямааны ноолуурын "Говь" үйлдвэр

И.Л.: "Говь" комбинатыг ашиглалтанд оруулж байхад та энэ асуудлыг хариуцаж байсан юм байна. Энэ үйлдвэрийг байгуулсан түүхээс ярьж өгнө үү?

П.Д.: Энэ талаар би ярина гэж бодож байлаа. Би ноос, хүнсний асуудлыг шийдэж чадсан гэж ярьсан шүү дээ. 60-70-аад оны үед бидний шийдэж чадаагүй нэг асуудал байсан. Энэ бол ямааны ноолуур, тэмээний ноосыг боловсруулах асуудал байсан юм. Манай тэмээ бараг 800 мянган толгойд хүрч байсан шүү дээ. Одоо манай тэмээ хорогдоод 200-аад мянга байгаа байх. Тэмээний ноосыг боловсруулж чаддаггүй байсан. 60-аад оны дундуур бид 1300 тонн ямааны ноолуур бэлтгэдэг байлаа. Миний хувьд, манай яамны хувьд нам засгаас өгсөн үүрэг даалгаврыг бүрэн биш ч гэсэн биелүүлж л байсан. Ганц биелэгдээгүй, миний сэтгэл дундуур явдаг зүйл бол ямааны ноолуур, тэмээний ноосыг боловсруулах аргыг олоогүй байсан явдал юм.

Манай улс ЭЗХТЗ-ийн гишүүн орон байлаа. Та нар мэдэх байх. Одоо манай "Их мэдэгч" нар :

-Шал дэмий юманд Монгол улс гишүүнээр орж мөнгө үрж байсан! гэж

шүүмжилдэг юм. Би бол тийм биш гэж боддог. Бас нэг жишээ хэлэхэд, тэр ЭЗХТЗ-ийн гишүүн 8 орон байсан. Манайх гишүүнээр элсээд 9 дэх орон болсон. Үүний дараа Вьетнам элсээд 10 орон болсон байх. Энэ Зөвлөлийн гишүүн орнуудын аж үйлдвэрийн яамны сайд нар жил бүхэн цуглараад хурал хийдэг байлаа. Хүнд үйлдвэрийн яам, хүнсний үйлдвэрийн яамны сайд нар хуралддаг байсан. Сайд нар сууж байгаад сайхан ярина шүү дээ. Танил сайд нар уулзахаараа амьдрал байдлын элдвийн л юм ярина. Би тэр сайд нартай манай ноолуурыг боловсруулах талаар ярьдаг байсан. Тэд нар чинь манайхаас ноолуур худалдаж аваад цааш нь Англид худалдчихдаг байлаа. Тэднээр дамжаад манай ноолуур гол нь Англи, Швейцарь руу гардаг байлаа. Би тэднээс:

-Энэ ноолуурыг яаж боловсруулдаг болох вэ? гэж асууна.

-Чи бидэнтэй энэ талаар яриад ямар ч нэмэр байхгүй. Бид энэ талаар туслаж чадахгүй. Манайханд ноолуур боловсруулдаг үйлдвэр нэг ч байхгүй. Бид энэ талаар ямар ч мэдлэг байхгүй! гэдэг байлаа. Тэгтэл нэг удаа миний танил Болгарын сайд эмэгтэй:

-Чи үнэхээр ингэж бодож байгаа бол Итали, Швейцарь, Япон, Англи гэсэн дөрвөн улсад очиж үз! Болвол дөрвүүлэнг нь, болохгүй бол хоёрыг нь ч болов судалж үз! гэж зөвлөлөө.

Тэр үед ингэж явна гэдэг хэцүү байсан үе. Одоо манай сайд нар амралтаа ч юм уу аваад, дуртай газраа явчихдаг, сайхан болсон байна шүү дээ.

-Япон явж үзлээ. 7 хоног тэнд баардлаа. Маш их ажил хийлээ! гээд л ороод ирнэ. Одоо сайхан болсон байгаа виз. Тэр үед явахад их бэрхшээл байсан юм. Одоо энэ хүмүүст ЗХУ бүгдийг мэдэж байсан болохоор хэцүү байсан гэж тайлбарлаж байгаа юм. ЗХУ мэдэх юм байсан. Ер нь гадаадын хөрөнгөтөн оронд толгой мэдэн явж болдоггүй байсан. Гадаадад явахад чинь гадаад валют их орно шүү дээ. Манайх валют муутай байсан. Өнөө үед тэр гаднаас ирж байгаа тусламжийн хичнээнийг нь гадаад томилолтонд үрж байгааг би мэдэхгүй байна. Би саяхан том дарга нартай уулзаад:

-Та нар энэ гадаад явдаг асуудлаа жаахан замбараатай болгооч! гэж хэлсэн. Өнөөдөр нэг сайд нь очоод л ярьдаг, маргааш бас нэг сайд нь яг адилхан юм яриад байдаг, тэгж болохгүй шүү дээ. Үүнийг замбараатай байлгах хэрэгтэй юм л даа. Тэр үед Монгол хаалттай байснаас бид явдаггүй байсан биш. Очоод хүнтэй чинь тодорхой юм ярих хэрэгтэй шүү дээ. Үйлдвэр авбал гэрээ хийх хэрэгтэй. Кармандаа юмгүй байж үйлдвэр авна гэж яриад яах юм бэ? Тийм биз дээ? Гол нь үүнд л байгаа юм. Тийм учраас би яаж явж судлах вэ? гэдэг талаар арга бодоод байлаа.

Би их олон жил Их хурлын гишүүн, НТХ-ны гишүүн байсан хүн.

НТХ-ны гишүүнээр 6 удаа, Их хурлын депутатаар 8 удаа сонгогдож байсан. Тэр үед гадаадад хурал их болдог байлаа. Хөрөнгөтөн орнуудын коммунист намуудын их хуралууд болно. Түүнд төлөөлөгч явах ёстой. Бас олон улсын парламентын холбооны хурал болно. Энэ хуралд одоо ч манайхаас төлөөлөгчид оролцож байна. Тэгээд би Төв Хороонд орлоо. Хариуцсан даргатай нь уулзлаа.

-Би чинь ТХ-ны гишүүн биз дээ? Тэгээд би яагаад намын их хурлуудад явж болдоггүй юм бэ? Намайг нэг хөрөнгөтөн орны коммунист намын их хуралд явуулаад өгөөч! гэлээ. Тэгсэн:

-Чи хаанахын хуралд явах бодолтой байна? гэж байна.

-Италид явмаар байна! гэлээ. Тэр үед буюу 1972 онд Италийн Коммунист Намын 13-р их хурал болох гэж байсан юм. Ноолуурын асуудлыг би 1970 оноос маш эрчимтэй судлаж эхэлсэн байлаа. Тэгээд ТХ-ны нарийн бичгийн дарга Д.Моломжамц гуайгаас:

-Намайг Италийн Коммунист Намын их хуралд төлөөлөгчөөр явуулаад өгөөч! гэж гуйлаа.

-Чи намын ажил хийдэг хүн биш шүү дээ! гэж байна.

-Юуны чинь намын ажил хийдэг хүн биш гэж. Би чинь НТХ-ны гишүүнээр олон жил сонгогдож байгаа шүү дээ! гээд шалаад байлаа.

Тэгтэл Ю.Цэдэнбал дарга тэр их хуралд төлөөлөгчөөр биш, төлөөлөгчдийн тэргүүнээр томилж өглөө. Олон хүн явахгүй л дээ. Нэг хүн дагуулаад Италийн Коммунист Намын их хуралд очлоо. Тэнд улсын, хувийн хосолсон нэг том монполи бий шүү дээ. Түүний харьяа нэг том компани байдаг юм. Түүнийг л үзээрэй гэж миний найз сайд зөвлөсөн байсан. Тэр үед Италийн КН-ын дарга Южи Лонго гэдэг хүн байсан. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Берлингуэр гэдэг хүн байлаа. Би хуралд баяр хүргээд л Ю.Цэдэнбал даргын мэндчилгээг дамжууллаа. Тэгээд Лүйжи Лонго даргатай уулзлаа. Тэр их нэр, хүндтэй хүн шүү дээ.

-Би их хуралд ирсэндээ их баяртай байна. Миний ирсэн нэг гол зорилго бол үйлдвэр үзэх явдал юм. Та надад энэ асуудал дээр туслаж өгөөч! гээд ярилаа.

-Би энэ асуудлыг сайн мэдэхгүй. Манай ерөнхий нарийн бичгийн дарга Берлингуэртэй уулз! Би Берлингуэрт таны хүсэлтийг хэлчихнэ! гэж байна. Тэр настай хүн, тэгээд ч улс төр голдуу барьж байсан болохоор аж ахуйн нарийн зүйлийг мэдэхгүй байсан байх л даа. Би Берлингуэртэй уулзлаа.

-Хурал сайхан болоо! гэлээ. Би нэг ноолуурын үйлдвэр үзмээр байна. Танайд ноолуурын үйлдвэр илүү сайн хөгжсөн юм байна! гээд би гол зорилгоо хэллээ.

-За та энэ хурлын үеэр ийм асуудал битгий тавиарай! Цаадуул чинь коммунистууд тагнуул хийж байна! гээд шуугиан болно. Ердөө болохгүй

шүү! Та яамны сайд хүн гэдгийг би ойлгож байна. Тэгэхээр та хурал дуусахаар энд үлд! Тэр үеэр би зохион байгуулж өгье! гэж байна. Ингээд би ч хуралдаа суугаад байлаа. Тэндхийн социалист орнуудтай худалдаа хийдэг "Рест Итали" гэдэг компанийн захирал нь коммунист хүн байж. Нэг өдөр тэр хүнийг дуудаж ирүүлээд:

-Монголоос ирсэн хурлын төлөөлөгчдийн тэргүүн, Хөнгөн Хүнсний Үйлдвэрийн Яамны сайд П.Дамдин гэдэг хүн байна. Энэ хүн хурлын дараа үлдэж үйлдвэр үзнэ. Чи зохион байгуулж өг! гэж Берлингуэйр гуай хэллээ. Хөөрхий тэр компани биднийг мөнгөгүй гэдгийг мэдэж байсан байх л даа. Италид байх миний бүх зардлыг компаниасаа гаргахаар боллоо. Тэгээд би тав хоног хуралд суугаад, хоёр хоног үйлдвэр үзлээ. Маш том комбинат байсан. Түүнийг үзээд би ноолуур боловсруулах арга гэж юу байдгийг ойлгосон. Хялгас ялгана гэдэг нь онцгой ач холбогдолтой юм байна. Бусад нь үндсэндээ нэхмэлийн үйлдвэр юм байна гэдгийг харсан. Энэ үйлдвэр надад их сэтгэгдэл төрүүлсэн.

Тэгээд Монголдоо буцаж ирээд би мөнгө олох гэж маш их хөөцөлдсөн. Хөөцөлдсөөр байгаад НҮБ-ийн тусламжаар 1974 онд ноолуур, тэмээний ноосны жижигхэн туршилтын үйлвэр байгууллаа. Ердөө л ганц, ганцхан машинтай үйлдвэр байсан. Хялгас ялгах нэг машин, нэхмэлийн хоёр машинтай. Манай нөхдүүд ч намайг их дэмжсэн. Анх туршилтын лаборатори нэртэй байсан. Үйлдвэр байгуулна гэвэл НҮБ тусалдаггүй юм. Тийм учраас туршилтын лаборатори гэж нэрлэсэн юм. Жилд 50 тонн ноолуур боловсруулж байсан. Ноолууpаар ийм сайн юм хийж болдог юм байна гэдгийг баталсан юм. Ингээд 1977 онд би бас дээшээ орлоо. Би Их хурлын гишүүн байсан. Их хурлын гишүүн хүн парламентын хуралд явж болно шүү дээ. Олон улсын парламентын холбооны хурал Австралид болох гэж байлаа.

-Би тийшээ явж үзмээр байна. Би их хурлын гишүүн хүн. Яагаад би олон улсын парламентийн холбооны хуралд явж болдоггүй юм бэ? гээд асуудал тавилаа. Тэгэхэд Австрали руу Японоор дайрч явж байсан. Би шаардлага тавьсаар байгаад хуралд явах зөвшөөрөл авлаа. Би тэгэхэд авгайгаа дагуулаад явлаа. Авгайдаа Японыг үзүүлэх гэж бодсон юм. Тэр бол 1977 он байсан. Авгайгаа дагуулж явах байтугай, сайд хүн Япон явахад хэцүү байсан үе шүү дээ. Би тэгэхэд Ю.Цэдэнбал дарга дээр орсон.

-Ю.Цэдэнбал дарга аа! Би Австралид Олон улсын парламентийн хуралд явах гэж байна. Би Японоор дайрч явах юм. Японд бас зорилготой очино. Би Японы ноолуурын үйлдвэрийг үзнэ. Ер нь ноолуурын үйлдвэр манайд их чухал ач холбогдолтой шүү. Би ноолууpаа боловсруулж чадахгүй байна. Би Япон руу авгайгаа дагуулж явах гэсэн юм гэлээ. Ер нь Ю.Цэдэнбал дарга бол хүнлэг, их сайн хүн байсан юм шүү дээ. Тэр :

-Тэгэлгүй яахав. Авгайгаа дагуулж явалгүй яахав гэж байна.
Тэгэхээр нь би:
-Улсаас ердөө зардал гаргахгүй. Би авгайгаа хувийнхаа зардлаар аваад явна. Миний зардлыг улсаас гаргана! гэлээ. Тэгээд явлаа.

Ер нь японд авгайгаа дагуулж очсон анхны сайд бол би л байх. Токиод Элчин сайдын яаман дээр авгайгаа орхичихоод, цаашаа Австрали ороод 7 хоноloo. Тэнд нэг том мах комбинат үзлээ. Австрали чинь 160 сая хоньтой орон шүү дээ. Манайх тэгэхэд 14 сая хоньтой юм. Мах комбинат ямар байдгийг үзлээ. Японд суугаа элчин сайдад:
-Би буцах замдаа Японы ноолуурын үйлдвэрийг үзнэ. Японд би өөр юу ч үзэхгүй! гэж хэлсэн байна. Тэгээд буцах замдаа Осака хотод ноолуурын 3-4 үйлдвэрээр орлоо. Ингээд ноолуурыг Япон, Италид яаж боловсруулж байгааг үзчихлээ.

Одоо миний гурав дахь зорилго бол Англи орж үзэх явдал байлаа. Ингээд Англи явах аргаа хайгаад байлаа. Тэр үед Англитай соёлын солилцооны хэлэлцээр байгуулагдаад эмч, багш нар явдаг байлаа. Тэгээд би манай Гадаад харилцааны яаманд хандаж та нар намайг соёлын хэлэлцээрийн шугамаар Англи явуулаад өгөөч гэлээ.
-Та яаж байгаа юм бэ? Соёлын хэлэлцээний шугамаар үйлдвэрийн хүнийг явуулахаар журамд заагдаагүй шүү дээ! гэж байна. Үгүй яахав дээ. Та нар миний асуудлыг тавиад үзээч. Манай Хөнгөн, Хүнсний Үйлдвэрийн Яамны сайд явах гэсэн байна гэсэн хүсэлт тавьчих. Гэхдээ би очоод театр энэ тэрийг үзэхгүй, үйлдвэр үзнэ гэлээ. Ингээд хөөцөлдөөд бүтлээ. Гадаад Харилцааны Яамны соёлын хэлтсийн нэг ажилтныг дагуулаад Англи орлоо. Англид байгуулагдаад 130 жил болчихож байгаа байх "Даусан" гэдэг ноолуурын том компани байдаг юм. Тэр компанийн үйлдвэрүүдийг бүгдийг нь үзэж авлаа. Ингээд Итали, Япон, Английн ноолуурын үйлдвэрүүдийг үзлээ.

Яг энэ үеэр манай засгийн газар, Японы засгийн газартай хэлэлцээр байгуулагдаж Японоос дайны төлбөрт манайд 17 сая ам. доллар өгөхөөр болсон юм.
-Дайны төлбөрт авах тэр доллараар чинь үйлдвэр байгуулах ёстой доо! гэж бодож байлаа. Яам болгон л өөртөө юм авахаар төсөл боловсруулсан юм. Тэр үед тендер зарладаггүй, мэддэгч үгүй байсан. Тийм үг дуулаач үгүй байлаа. Тэгээд одоогийнхоор бол тендер маягийн юм болж байна. Би туршилтын үйлдвэр байгуулсан, өөрөө хэдэн газар яваад үзчихсэн болохоор Японоос өгөх хөрөнгийг ашиглахаар санал боловсруулаад, нөгөө туршилтынхаа үйлдвэр дээр хийсэн бүтээгдэхүүнээсээ 2 чемодан дүүргэж аваад, 2 залууг, нэг нь орлогч сайд, нөгөө нь одоогийн "Говь" комбинатын дарга Ёндонжамц нарыг дагуулаад дарга болгон дээр орж

танилцууллаа. Ёндонжамц тэр үед манай яаманд ажиллаж байсан юм. Улс төрийн товчооны гишүүд дээр 2 чемодантай, 2 залуутайгаа ороод л ярьж гарлаа даа. Японоос дайны төлбөрт өгөхөөр болсон 17 сая доллараар үйлдвэр байгуулах гэсэн саналаа хэллээ.

К.Ю.: Тэр мөнгөөр яг ийм үйлдвэр байгуулахаар шийдээгүй байсан юм уу?

П.Д.: Шийдээгүй байсан.Тэр мөнгийг юунд ашиглахыг шийдэхийн тулд арван хэдэн төсөл бий болсон байлаа. Барилгын Яам цементийн үйлдвэр, шилний завод байгуулах төсөл, Нийтийн Аж Ахуйн Яам юуны төсөл хийснийг би санахгүй байна. ХАА Яам их сонин төсөл хийсэн байлаа. Бүх малчин өрхөд дээлийн 2-3 төрлийн торго, сум, нэгдлийн дарга нарт УАЗ-469 машины дугуй өгөх төсөл хийсэн байлаа. Тэр үед УАЗ-469 машины дугуй маш ховор байсан. Зөвлөлтийн дугуй хийдэг үйлдвэрийн ажил муудсан байсан байх. Тэгээд 2-3 жилийн запас дугуйтай болох төсөл хийгдсэн байлаа. Ийм хачин төсөл хүртэл хийгдээд, тэгээд бараг тэр УАЗ-469 машины дугуй авах төсөл шийдэгдэх шахаж байлаа. Айл болгонд 2-3 дээлийн торго гэдэг чинь ёстой том юм шүү дээ. Тэр үед 200 гаруй мянган өрх мал маллаж байсан байх. Энэ хэдэн арван төсөл дотор хэрэггүй юм ерөөсөө байгаагүй. Бүгд л хэрэгтэй. Би бүх дарга нарт танилцуулаад яваад байсан Зарим нь "Зүйтэй л" гээд дэмжиж байна. Харин зарим нь "тэртэй тэргүй манайх ноолуураа гадаадад гаргаад валют олж байгаа шүү дээ. Ноолуураар хийсэн бүтээгдэхүүнийг маань харин авах ч юм уу, үгүй ч юмуу. Ноолуур бол баталгаатай авна шүү дээ!" гээд дургүй байна.

Тэгээд би хамгийн сүүлд Ю.Цэдэнбал дарга дээр орж танилцуулаад бүтээгдэхүүнээ үзүүллээ. Дарга их дэмжиж байна. Тэгээд :

-Бид улс төрийн товчоогоор ярьж шийднэ! Чи бэлтгээд байж бай! гэж байна. Тэгээд нэг хоногийн дараа улс төрийн товчооны хуралд намайг дуудлаа. Ороод удсан ч үгүй.

Дарга :

-За, энэ асуудлаар 10 орчим төсөл явж байгаа юм байна. Үүнийг түргэн шийдэж японы талд хариу өгөхгүй бол болохгүй. Энэ П.Дамдин надад танилцуулсан. Тэмээний ноос, ямааны ноолуурын үйлдвэр байгуулах төсөл хийсэн байна. Энэ төсөл бол ирээдүйтэй. Монголд ямаа, тэмээ байгаа цагт ноос, ноолуур жил болгон л гарна. За ийм байна. Одоо энэ үйлдвэрээ хурдан шийдье! гэж хэллээ. Даргыг тэгж хэлэхээр бусад нь дуугарсангүй. Тэгээд л шийдчихлээ. Би ч манай төсөл унах бол уу яадаг бол, манайхан дэмждэг болов уу гэж түгшиж л суулаа. Тэгээд шийдэж өгсөн болохоор бөөн баяр боллоо. Тэгээд л үйлдвэр баригдсан юм даа.

Энэ үйлдвэрийг 3 жилийн дотор барьсан. Монголд энэ хэмжээний

үйлдвэрийг 3 жилд барьж байсан түүх байхгүй. Ер нь бол 5-6 жил барина шүү дээ. Ингэж би энэ асуудлыг сайд байхдаа шийдсэн. Би 1979 онд Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга болсон. Тэнд очоод барилгачдыг сайхан зохион байгуулсан. Тэдэнд өндөр шаардлага тавьсан. Тэдэнд сайн ажиллах бололцоо олгосон. Үүний хүчинд богино хугацаанд бариулсан. Одоо бол Япон улстай харилцаа өргөн болж ард түмэн, мэргэжилтнүүдийн хооронд сайхан харилцаатай болжээ. Тэр 70-хэдэн онд Японтой наймаа, арилжаа хийх нь бүү хэл, япон хүнтэй зүгээр уулзахад зовлонтой үе байсан шүү дээ. Би одоогоос 3 жилийн өмнө танай ЭСЯ дээр нэг удаа очсон. Тэр үед, өнгөрсөн, хэцүү байсан үеийн тухай түүх ярьж суулаа. Би Япон-Монголын найрамдал нөхөрлөл өргөжихөд, ялангуяа эдийн засаг худалдаа, арилжааны харилцаа өргөжихөд өөрийн хувь нэмрийг оруулсан гэж боддог. Ингэж "Говь" комбинатыг байгуулсан түүхтэй.

Тэр комбинат анх байгуулагдаж байхдаа жилд 1200 тн ноолуур, 200 тн ноос боловсруулдаг байлаа. Одоо нилээд өргөтгөсөн байна билээ. Энэ комбинатын 20 жил болох гэж байгаа. Өнөөдөр надтай уулзаж ярилцлага хийж, кино зураг авах гэж байгаа. Тантай уулзсны дараагаар тийш явна.

Бас нэг түүх ярья. "Говь" комбинатын инженерүүдийг нь Японд бэлтгэсэн юм шүү дээ. Манайх Германд 30 хэдэн онд мэргэжилтэн сургаж байсан юм билээ. Тэгээд сүүлдээ тэднийгээ "Хувьсгалын эсэргүү" гээд барьж аваад шоронд хийж байсан түүхтэй. Түүнээс хойш 70-80-аад он хүртэл хөрөнгөтөн оронд мэргэжилтэн бэлтгээгүй юм. Энэ асуудлыг шийдэхэд би сайд байсан, юмны эвийг олдог болсон туршлага гэх ч юмуу даа, нэг тийм арга хэрэглэсэн юм. Энэ асуудлаар эхлээд Япон улсын Элчин Сайдын яамтай ярьсан юм. Элчин сайд Акияма гэдэг хүн байсан.

К.Ю.: Яг тэр үед би Улаанбаатарт байсан.

П.Д.: Аа, тийм үү?

Би Акиямa гуайг уриад:

-Одоо ингээд үйлдвэр байгуулж эхлэх гэж байна! Үйлдвэр гэдэг чинь инженергүйгээр, ялангуяа тэр үйлдвэрийг байгуулсан оронд мэргэжил эзэмшсэн инженергүйгээр ажиллахад хэцүү л дээ! Энэ үйлдвэрийн инженерийг танайд бэлтгэе! Та үүнд туслаж өгөөч! Бидэнд мөнгө байхгүй! Энэ үйлдвэр байгуулах төсөл дотор инженер бэлтгэх зардал тусгагдаагүй. Та ямар нэгэн шугамаар инженер бэлтгэх зардал олж туслаач! гэж хэллээ. Акияма гуай бид хоёр чинь нилээд дотно танил болсон юм.

Тэгтэл Акияма гуай :

-Хэдэн хүн бэлтгэх ёстой юм бэ? гэж асууж байна.

Би урьчилаад тооцоо хийсэн байсан. Миний тооцоогоор 24 хүн бэлтгэх

хэрэгтэй байсан. Түүнийгээ хэлбэл :

-Тийм олон хүн, тэгээд Японы зардлаар сурна гэдэг бүтэхгүй байхдаа! гэж Акияма гуай хэлж байна.

-Бүтэхгүй байж болно. Ямар ч байсан та энэ асуудлаар өөрийнхэнтэйгээ ярилцаарай! гэлээ. Тэр хүн Токио руу байнга явдаг байсан. Тэгж очихдоо энэ асуудлыг ярьсан байна. Тэгээд нэг ирээд надтай уулзлаа.

-Ноён сайдаа! Энэ асуудал ерөөсөө бүтэхгүй юм шиг байна. 24 хүнийг дээд сургуульд 5 жил сургахад хичнээн хэмжээний зардал гарна гэж та бодож байна? Та хүнийхээ тоог цөөлөөч! гэж байна. Би бодлоо. Хүний тоог 12 болголоо. Элчин сайд дахиад л Токио явлаа. Дахиад хүнийхээ тоог цөөлөөч гэлээ. Надад үнэнээ хэлж байна.

-Танайх хүнээ бэлтгээд авья! гэж бодож байгааг би ойлгож байна. Ийм олон хүнийг сургах зардал чинь явсаар байгаад манай Сангийн яаман дээр очино. Японы Сангийн Яам ийм их зардлыг гаргахгүй шүү! гэж байна.

Ингээд явсаар байгаад хүний тоо 2 боллоо. Тэгээд 2 хүнийг бол аргалж чадна гэж элчин сайд хэлж байна. Энэ хоёр хүний бүх зардлыг Японы тал даах боллоо. Одоо Японд суугаа ЭСЯ-ны дэргэд худалдааны төлөөлөгч хийж байгаа Ганхуяг, ГХЯ-нд ажиллаж байгаа Жигжид хоёр анх Японд сурахаар явж билээ. Энэ хоёрыг явуулсан түүх бас их сонин болсон. МУИС-ийн 2 курс, ПТДС-ийн 2 курсээс сонгож авсан юм. Өөр газраас авахгүй гэж шийдсэн. Тэгээд Японы ЭСЯ-тай хамтраад шалгаад авчихлаа. Тэгсэн чинь Японд хүн сургах гэж байна гээд цуу яриа гарч их дуулиантай юм болжээ. Миний найз сайд нар над руу утасдаад өөрийн хүүхэд, дүүг явуулж өгөхийг гуйж гардаг юм байна. Тэгээд би ерөөсөө Улаанбаатараас нэг ч хүн авахгүй! гэж хэлээд л байлаа. Өөрийн яамны боловсон хүчний даргад Улаанбаатараас хүн авахгүй, хөдөөний малчин, аав ээжтэй хүүхдийг аваарай! гэж үүрэг өглөө. Энэ хоёр хүүхэд маань Архангай, Дундговийн хүүхдүүд таарсан юм. Улаанбаатараас нэг багшийн хүүхэд, нэг эмчийн хүүхэд, нэг сайдын хүүхэд явбал надад инженер хийж өгөхгүй болох байсан. Тийм хүүхэд чинь аав, ээжийгээ дагаад л алга болно шүү дээ.

Шалгалтанд 32 хүн орсон юм. Түүнээс дөрвийг нь үлдээгээд Японы ЭСЯ дээр авч очоод шалгалаа. Японы их сургуулиас багш ирсэн юм. Тэр шалгалтанд Ганхуяг, Жигжид хоёр тэнцээд явуулах боллоо. Тэгтэл нэг том асуудал бослоо. Тэр үед хөрөнгөтөн оронд оюутан сургах асуудлыг НТХ-оор оруулж шийддэг журамтай байлаа. НТХ-ны зөвшөөрөл эхлээд гарч байж дараа нь явуулах хүнээ сонгох асуудалд орох ёстой байсан юм. Би бол явуулах хүний тооны ч зөвшөөрөл аваагүй, юуны ч зөвшөөрөл аваагүй байсан. Тэгээд ТХ-нд сонгосон 2 хүнийхээ асуудлыг оруулах үед

хамаг асуудал босно биз дээ.

-Японд хүн сургахыг хэзээ, хэн зөвшөөрсөн юм бэ? Зөвшөөрсөн тогтоол байна уу? гээд л асуудал гарлаа даа. ТХ-оос зөвшөөрсөн тогтоол гаргуулахгүй бол гадаад паспорт гарахгүй шүү дээ. Японы хичээлийн шинэ жил 4 сараас эхэлдэг тийм үү? Өнөө 2 маань хэлний бэлтгэл хийгээд 3-4 сар боллоо. 3 сард багтаж японд очих ёстой байсан. ТХ-нд энэ 2 хүүхдийн асуудлыг оруулах ёстой байсан манай орлогч сайд:

-Сайд аа! Энэ асуудал ер нь бүтэхгүй юм шиг байна. ТХ-ны зөвшөөрөл гараагүй байхад хөрөнгөтөн оронд хүн сургах асуудал ярьсан гээд асуудал босч ирж байна. Та өөрөө Цэдэнбал дарга дээр орохгүй бол энэ чинь бүтэх янз алга! гэж байна. Би ч ийм юм болно гэдгийг мэдэж байсан л даа. Тэгээд Цэдэнбал дарга дээр орлоо.

Цэдэнбал дарга их хүн сайтай хүн л дээ.

-Дарга, аа! Би нэг юм асуух гэж ирлээ. Одоо бид ноолуурынхаа үйлдвэрийг барьж эхлээд байна. Таны дэмжлэгээр энэ асуудлыг Улс төрийн товчоо шийдээд өгсөн. Энэ үйлдвэр 3 жилийн дараа ашиглалтанд орно. Инженер бэлтгэх асуудал доод тал нь 5 жил байдаг. Бид тэгэхэд үйлдвэр ашиглалтанд ороход бэлэн инженергүй сууж байдаг. Одоо хурдан хүн явуулж сургахгүй бол өшөө дахиад хэдэн жил алдана. Бид одоо 2 жил алдаад байгаа дээрээ явуулмаар байна. Бид Японы ЭСЯ-тай хамтраад гучин хэдэн хүүхдээс хоёрыг сонгож аваад байна. Ингээд энэ 2 хүүхдийн асуудлыг ТХ-нд оруулсан чинь шийдэгдэхэд бэрхшээл тулгараад байна! гээд л ярилаа. Үүнийг сонссоод Цэдэнбал дарга:

-НТХ-ны зөвшөөрөл гараагүй байхад, чи яагаад хөрөнгөтөн оронд хүн сургах асуудлыг дурааараа ярьж явсан юм бэ? Ийм журам байдгийг чи мэднэ биз дээ? гэж байна.

-Тийм журам байдгийг би мэднэ! гэлээ.

-Тэгвэл яагаад асуудлаа журмаар нь шийдүүлээгүй юм бэ? гэж байна.

-Дарга, аа! Хэрвээ энэ асуудлыг тэр журмаар оруулсан бол надад хэзээ ч, хэн ч шийдэж өгөхгүй шүү дээ. Би Японы талтай яриад тэдний сургалтын зардлыг тэднийх гаргахаар болсон. Манайхаас зардал ерөөсөө гарахгүй. Хүнээ бүр сонгоод шийдчихсэн. Одоо явуулахаас өөр аргагүй л дээ. Та зөвшөөрөөд өгөөч, би гуйж байна! гэлээ.Тэгэхдээ надад арга хэмжээ авчих! гэлээ. Би дарга дээр орохдоо нэг тогтоолын төсөл хийгээд орсон юм. Тэр тогтоолын төслийн нэгдүгээр заалтанд "Хөнгөн Хүнсний Үйлдвэрийн Яамны сайд П.Дамдин, хөрөнгөтөн орон хүн сургах асуудлыг НТХ-ны зөвшөөрөлгүй дурааараа ярьж, зарчимгүй явдал гаргасан тул намаас донгодох арга хэмжээ авсугай" гээд хоёрдугаар заалтанд нь "Сонгосон хоёр хүүхдийг Японд суралцуулахыг зөвшөөрсүгэй" гээд биччихсэн байсан. Тийм бэлэн төсөлтэй орохгүй бол

наадуул нь саатуулчихна шүү дээ. Тогтоолынхоо төслийг даргад өглөө.

-Та энэ тогтоолын төсөл дээр гарын үсгээ зурна уу? гэлээ. Дарга түүнийг уншиж үзээд:

-Чамд арга хэмжээ авахаа больё! Харин чи үүнээс хойш анхааараарай! гээд нөгөө нэгдүгээр заалтыг дарж хаяад, хоёрдугаар заалтыг нь үлдээгээд гарын үсгээ зурчихлаа. Ингэж анх удаа Японд хүн сургах асуудал шийдэгдэж байлаа.

Сүүлийн үед манай их мэдэгчдийн зүгээс:

-Бид гар ч ирээд л гадаадад хүн сургадаг боллоо! гэж ярих болжээ. Би 1978 онд хүнээ ингэж явуулж сургаж байлаа. Одоо Японд олон хүн сурдаг болоо биз дээ. Анхны юм гэдэг хэцүү шүү дээ. Тэгээд явах хоёр залуугаа би яаман дээрээ хүлээээж аваад :

-За та хоёр нэр төрөө бодоод сайн сураарай! Хэрвээ та хоёр сайн сураад, сахилга баттай байвал, дараагийн хүүхдүүд чинь яваад эхлэнэ шүү дээ. Харин сахилга бат алдаад, хөөгдөөд ирвэл дахин японд хүн сургах асуудал дуусгавар болно шүүдээ! гэж захиалаа. Тэр хоёр их сайн сурч ирсэн юм.

Японтой харьцаж байсан бас нэг сонин жишээ хэлье. Би үйлдвэрийн барилга дээрээ 7 хоногт нэг удаа очдог байлаа. Тэгээд тэнд ажиллаж байгаа хүмүүстэй бүр танил болчихсон. Тэд нарт контор байхгүй. Тэр хавийн байшин барилгыг нураагаад, нэг вагончиг тавиад түүнд тэр барилгын захиргааны дарга суудаг байлаа. Одоо комбинатын дарга болсон Ёндонжамц тэр үед захиргааны дарга байсан юм. Японччууд ер нь ажлаа их сайхан явуулна. Юу хийж байгаагаа зураг дээр буулгачихсан байна. Намайг ч сайн мэддэг болсон. Тэгээд нөгөө зургаараа ажилаа танилцуулна. Нэг удаа очсон чинь нэг том лоозон шиг юм хадсан байв. Монгол-Японы ажиллагсдын мөрдлөг болгох 5 зарчим гэнэ.

-Багаж зэвсэгтээ хайр гамтай хандаж, алдаж үрэгдүүлэхгүй байх.

-Ажлын хувцастай байх.

-Ажлаас хоцрохгүй байх.

-Хариуцсан ажлаа чанартай хийх ч гэх мэтийн яг Монгол ажилчдад байдаг 5 дутагдал мөн байлаа. Ажлаас хоцордог, ажил дээрээ унтдаг, багажаа хайрладаггүй, эвддэг нь монгол ажилчдын дунд байдаг жирийн үзэгдэл мөн. Би тэдний даргад нь:

-Та үнэхээр зөв зүйтэй юм бичсэн байна. Энд бичсэн зүйл бол үнэхээр манай ажилчдын дунд байдаг зүйл мөн! гэж хэллээ. Тэгсэн өнөө хүн санаа зовж байгаа бололтой.

-Ноён сайдаа! Та үүнийг дахиад нэг уншаад үзээч! 1-рт энэ нь Монгол, Япон хоёр хэл дээр бичигдсэн байгаа, 2-рт Монгол, Япон ажилчдад хандаж бичсэн байгаа биз дээ. Ганц Монгол ажилчдад хэндэж бичээгүй

юм шүү! гэж байна. Үнэхээр лоозонгийнхоо нөгөө хэсгийг Японоор бичсэн байлаа.

Би :

-Үүнийг ойлгож байна. Гэхдээ ажлаас хоцордог Япон хүн гэж байхгүй, багажаа хамаагүй хаядаг Япон хүн байхгүй, муухай хувцастай ажилдаа ирдэг Япон хүн байхгүй, ажил дээрээ унтдаг Япон хүн байхгүй. Тиймээс энэ бол яг манай дутагдал мөн. Тэгээд бөөн инээдэм болж билээ.

Өөр нэг түүх ярья. Комбинатын барилгыг барьж байхад дээд тал нь 70-аад хүн ирж байсан. Тэдний Монголд байх хугацааны үйлчилгээний асуудал босч ирлээ. Манайд гадаадын мэргэжилтнүүдийн үйлчилгээний газар гэж тусгай байгууллага байсан юм. Тэр газар Герман, Чех, Орос зэрэг орноос ирж байгаа мэргэжилтнүүдийг орон сууц, хоол унд, ор дэрээр хангадаг байлаа. Тэгээд би өөрийн орлогч сайддаа :

-Японоос ирж байгаа энэ мэргэжилтнүүдээр далимдуулаад яамныхаа ажилчдын сайхан байртай больё! Чи японоос ирж байгаа мэргэжилтнүүдийг байр, хоол, сууцаар хангах, өндөр хэмжээнд үйлчлэх нэг тогтоолын төсөл хийгээд НАА Яам, Сангийн яам, Төлөвлөгөөний комисс зэрэг чухал газруудаас визийг нь аваад ир! гээд үүрэг өгөөд явууллаа. Японоос Монголд анх удаа мэргэжилтнүүд ирж байна. Тэднийг орон сууц, хоол хүнс, унаагаар хангах асуудал бол хэцүү асуудлын нэг байлаа. Чухал газруудаас визийг нь аваад, тогтоол гаргасан нь дээр байсан юм. Тэгээд ийм тогтоол гарчихвал энэ бүх асуудлыг виз өгсөн газрууд өөрсдөө хариуцах ёстой л доо. Японд ийм систем байна уу, үгүй юу мэдэхгүй байна. Тэгээд виз авах гэтэл нэг ч яам зөвшөөрөл өгдөггүй.

НАА Яамны сайд О.Нямаа гэдэг хүн байсан юм. Тэр хүн :

-Ямар ч байсан энэ асуудлаа Сайд нарын Зөвлөлд оруулчих! гэж байна. Оруулсан асуудлыг бол хурлаар хэлэлцдэг журамтай шүү дээ. Удалгүй намайг, бас холбогдох яамны сайд нарыг дуудлаа. Тэр хурал дээр би:

-Одоо Японоос үйлдвэрийн барилга дээр ажиллах мэргэжилтнүүд ирэх гэж байна. Тэд нарын орон сууц, үйлчилгээний асуудлыг яаж шийдэх вэ? гэсэн асуудлыг тавилаа. Тэр үед Сайд нарын зөвлөлийн дарга Ж.Батмөнх гуай байлаа.

-Чиний энэ оруулсан асуудлыг зөвшөөрөх газар нэг ч алга байна шүү! гэж тэр хэллээ. Тэгэхээр нь би дахиад бослоо.

-Яагаад зөвшөөрөхгүй байдаг юм бэ? Манайд чинь гадаадын мэргэжилтнүүдэд үйлчилдэг бүхэл бүтэн яам, өчнөөн олон дарга, сайдууд бий шүү дээ. Эд нар хариуцахгүй юм бол хэн хариуцах юм бэ? гэлээ. Тэгээд ч японы мэргэжилтнүүд ирж байна. Энэ хүмүүс өдөр тутам усанд ордог, хоол унд, их нарийн юм шаарддаг, үйлчилгээ их шаарддаг, орны даавууг нь өдөр бүр сольж өгөхгүй бол болохгүй гэлээ. Тэгсэн чинь:

-Чи бариулж байгаагаараа өөрөө хариуцна биз дээ! гэж байна.
-Тэгдэг юм бол надад байр өгөх хэрэгтэй шүү дээ! Байргүй бол би 80-аад хүнийг чинь хаана байлгах юм бэ? гэж хэллээ.
-Тэг, тэг! Чи тэр ирэх хүмүүсийнхээ асуудлыг өөрөө хариуц! гэж дахин тэр хэлж байна.
-Тэгвэл би тогтоол гаргуулна! Би зүгээр нэг үүрэг аваад гармааргүй байна. Ийм маягаар шийдэхгүй бол энэ асуудал хариуцах эзэнгүй болно! гэж хэлээд гарлаа.

Үнэндээ бол 70-80 хүн маань байнга байх хүний тоо биш шүү дээ. Нэг удаа зарим үед 5 хүн ирж болно. Тухайлбал монтаж хийхэд 10 хүн ирж ажиллаад буцна. Би нийт ирэх хүний тоог дээд хэмжээгээр хэлсэн юм. Тэр үед манай яамны хажууд 48 айлын орон сууц барьж байсан юм. Би түүнийг хараад л явдаг байлаа. Тэр бол хотын захиргааны мэдэлд байсан орон сууц л даа. Тэр хурлаас гараад ажил дээрээ ирээд 2 заалттай тогтоолын төсөл хийлээ. 1-р заалт нь "Хотын 48 айлын орон сууцыг Хөнгөн Хүнсний Үйлдвэрийн Яаманд шилжүүлсүгэй", 2-р заалт нь ""Говь" комбинатын ажлыг гүйцэтгэж байгаа Япон мэргэжилтнүүдэд үйлчлэх асуудлыг Хөнгөн Хүнсний Үйлдвэрийн Яаманд даалгасугай!" гэж заагаад засгийн газарт өгсөн. Тэгээд тэр орон сууц манай мэдэлд хүрээд ирлээ.

Тэр 4 орцтой орон сууц байсан. Түүнийг яамнаасаа зардал гаргаад сайхан заслаа. Өрөө болгонд нь шинэ мебель, хөргөгч зэргийг хангалттай тавилаа. Тэгээд 2 орцонд нь яамныхаа ажилтнуудыг оруулчихлаа. 2 орцонд нь Япончууд байлаа. Тэд нар комбинатынхаа барилгыг барьж дуусаад буцсан. Тэднийг явахаар манай яамны ажилтнууд орсон. Яамнаас холгүй хэдэн метрийн цаана сайхан орон сууцтай боллоо. Энэ маягаар бид Японоос ирж байсан мэргэжилтнүүдийн хүчээр яамныхаа ажилтнуудын амжиргаанд бага ч гэсэн туслаж чадсан юм.

П.Д.: Одоо ингээд асуух юм байна уу?

К.Ю.: Маргааш бидэнтэй хамт яваад таны сайд байх хугацаанд хаана, ямар үйлдвэр баригдсныг зааж өгөх үү?

П.Д.: Би гадуур явахад их хэцүү байна. Лхагвасүрэн чи яваад заагаад өгнө биз дээ.

И.Л.: Болно, болно. Ямар ямар үйлдвэрийг үзүүлэх вэ?

П.Д.: Тэгвэл дараах үйлдвэрүүдийг үзээрэй. Арьс ширний үйлдвэр, Гутлын үйлдвэр, Савхин эдлэлийн үйлдвэр, Шевретийн үйлдвэр, Арьс ширний эрдэм шинжилгээний төв, Арьс ширний засварын завод, Нэхмэлийн үйлдвэр, Ээрмэлийн үйлдвэр, Ноос угаах үйлдвэр, Нэхээсгүй даавууны үйлдвэр зэргийг хөнгөн үйлдвэрүүдийг төлөөлүүлж үзвэл болно.

Харин хүнсний үйлдвэрүүдийг төлөөлүүлж "Өгөөж" компани, Талх

чихрийн үйлдвэр, Мах комбинат, Гурилын үйлдвэр, Чихэр, боовны үйлдвэр гэх мэтийг үзээрэй. Хүнд үйлдвэрүүдээс 1,2,3,4-р цахилгаан станцуудыг үзэж болно.

Миний сайд байхад ажиллаж байсан хүмүүс одоо ихэнх нь байхгүй байна. Дан шинэ залуучууд ажиллаж байна. Тэд нар ийм шинэ асуудлыг мэдэхгүй л дээ. Одоогийн залуучууд хаана ямар үйлдвэр байдгийг бараг мэдэхгүй дээ. Харин ямар баар хаана байдгийг бол сайн мэднэ. Би удахгүй Үйлдвэр худалдааны яамны шинэ сайдтай үйлдвэрүүдээр явахаар тохирсон. Би түүнд энд ямар үйлдвэр, хэдэн онд, яаж байгуулсан, одоо ямар болчихоод байгааг нь харуулах гэж байгаа юм. Одоо их муухай болсон.

Бидний үед ямар сайхан ажилтай үйлдвэрүүд байлаа. Одоо бол харамсмаар болчихсон. Эзэнгүй юм чинь өнгө зүсгүй, зэвхий даасан байдаг шүү дээ. Хуучин бидний үед Монголд ирсэн зочдод хэдэн үйлдвэрээ үзүүлдэг байлаа. Одоо ажилчид нь гудамжинд гараад, үйлдвэр нь эвдрээд, эвдрээгүй нэг нь түрээсийн байр болсон байна. Түрээслэгчид нь голдуу Хятадууд байна билээ.

Таны асуусан юманд хариулж чадав уу.

К.Ю.: Хариулж чадлаа. Маш сайхан түүх ярьж өгсөнд их баярлалаа.